

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 06 дугаар сарын 27-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-34</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>35-73</i>
<hr/>	
<i>1. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл /Засгийн газар 2021.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	<i>36-44</i>
<i>2. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	<i>44-54</i>
<i>3. Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Дээд боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл /Засгийн газар 2021.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	<i>54-73</i>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны
06 дугаар сарын 27-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга Г.Мөнхцэцэг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 16 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 56.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 59 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Э.Батшугар, Г.Дамдинням, Н.Учрал;

Чөлөөтэй: Ё.Баатарбилэг, Б.Баярсайхан;

Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Мөнхцэцэг.

Хэлэлцэх асуудлын дараалалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан хэлэлцэх асуудлын дарааллын хоёрт байгаа Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Дээд боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэх асуудлын гуравдугаарт хэлэлцье гэсэн горимын санал гаргав.

Г.Мөнхцэцэг: Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 1

Бүгд: 9

88.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Дээд боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэх асуудлын гуравдугаарт хэлэлцэхээр тогтов.

Нэг.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл /Засгийн газар 2021.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Г.Ганбаяр, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир, Боловсрол, шинжлэх ухааны яамны Сургуулийн өмнөх боловсролын хэлтсийн дарга Ж.Мягмар, мөн яамны Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн секторын эрхлэгч У.Туяа, Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах шинжээч А.Цолмон, мөн хэлтсийн шинжээч Ж.Нарантуяа, Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах шинжээч Ч.Баярмаа, Шинжлэх Ухааны академийн Философийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Ш.Ариунаа, Монголын хувийн хэвшлийн бага, дунд сургуулиудын холбооны тэргүүн Н.Номин, Хувийн цэцэрлэгийн үүсгэн байгуулагчдын холбооны тэргүүн А.Цэнгэл, “Бүх нийтийн боловсролын төлөө” Иргэний нийгмийн үндэсний эвслийн ерөнхий зохицуулагч Д.Тунгалаг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Р.Болормаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвсүрэн нар байлцав.

Төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийг танилцуулгыг Байнгын хорооны дарга Г.Мөнхцэцэг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны тавьсан асуултад Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэний дагуу санал хураалт явуулав.

Г.Мөнхцэцэг: 1.Төслийн 17 дугаар зүйлийн 17.1.3 дахь заалтын “нөхцөл боломжийг бүрдүүлэх” гэснийг, мөн зүйлийн 17.6 дахь хэсгийг төслөөс хасаж, 17.1.5 дахь заалтын “сургуулийн” гэснийг “сургууль, дотуур байрын” гэж өөрчилж, 17.1.3 дахь заалтын “суралцагчийн хөгжил, төлөвшлийг дэмжих” гэсний өмнө “хамран сургах тойргийн хүүхэд бүрийг цэцэрлэг, сургуульд бүрэн хамруулах, бүртгэх ажлыг зохион байгуулах,” гэж, “сургалтын” гэсний дараа “үйл ажиллагааны” гэж, 17.1.5 дахь заалтын “зохион байгуулах” гэсний дараа “эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, тэдний эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах,” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 17.1.10, 17.1.11 дэх заалт, 17.7, 17.8 дахь хэсэг нэмж, 17.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“17.1.8.боловсролын чанар, үр дүнг суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, нутгийн удирдах болон захиргааны байгууллагад тухайн хичээлийн жилд тайлагнах;

17.1.10.энэ хуулийн 18.8-д заасан байгууллагад арга зүйн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

17.1.11.Төсвийн тухай хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж, төсөв, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагналтай холбоотой мэдээллийг багш, ажилтан, суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид ил тод, нээлттэй, ойлгомжтой байдлаар мэдээлэх.

17.7.Боловсролын ерөнхий хуулийн 10.2 дахь хэсэг, энэ хуулийн 13.1.2, 13.1.3-т заасан үүргээ биелүүлээгүй суралцагчийг ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтны болон сэтгэл зүйчийн зөвлөгөө, үйлчилгээнд хамруулж болно. Шаардлагатай тохиолдолд холбогдох хуульд заасан үйлчилгээнд холбон зуучилж болно.

17.8.Боловсролын ерөнхий хуулийн 45.3-т заасан эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй байгуулах гэрээнд сургалтын төлбөр төлөх, хураамж авах харилцаанд багш, суралцагчийг оролцуулахыг хориглоно.” гэсэн саналаар дахин санал хураалт явуулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10

Гуравны хоёроор дахин санал хураалгах санал дэмжигдлээ.

Г.Мөнхцэцэг: 1.Төслийн 17 дугаар зүйлийн 17.1.3 дахь заалтын “нөхцөл боломжийг бүрдүүлэх” гэснийг, мөн зүйлийн 17.6 дахь хэсгийг төслөөс хасаж, 17.1.5 дахь заалтын “сургуулийн” гэснийг “сургууль, дотуур байрын” гэж өөрчилж, 17.1.3 дахь заалтын “суралцагчийн хөгжил, төлөвшлийг дэмжих” гэсний өмнө “хамран сургах тойргийн хүүхэд бүрийг цэцэрлэг, сургуульд бүрэн хамруулах, бүртгэх ажлыг зохион байгуулах,” гэж, “сургалтын” гэсний дараа “үйл ажиллагааны” гэж, 17.1.5 дахь заалтын “зохион байгуулах” гэсний дараа “эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, тэдний эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах,” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 17.1.10, 17.1.11 дэх заалт, 17.7, 17.8 дахь хэсэг нэмж, 17.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“17.1.8.боловсролын чанар, үр дүнг суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, нутгийн удирдах болон захиргааны байгууллагад тухайн хичээлийн жилд тайлагнах;

17.1.10.энэ хуулийн 18.8-д заасан байгууллагад арга зүйн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

17.1.11.Төсвийн тухай хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж, төсөв, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагналтай холбоотой мэдээллийг багш, ажилтан, суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид ил тод, нээлттэй, ойлгомжтой байдлаар мэдээлэх.

17.7.Боловсролын ерөнхий хуулийн 10.2 дахь хэсэг, энэ хуулийн 13.1.2, 13.1.3-т заасан үүргээ биелүүлээгүй суралцагчийг ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтны болон сэтгэл зүйчийн зөвлөгөө, үйлчилгээнд хамруулж болно. Шаардлагатай тохиолдолд холбогдох хуульд заасан үйлчилгээнд холбон зуучилж болно.

17.8.Боловсролын ерөнхий хуулийн 45.3-т заасан эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй байгуулах гэрээнд сургалтын төлбөр төлөх, хураамж авах харилцаанд багш, суралцагчийг оролцуулахыг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9

77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Г.Мөнхцэцэг: 2.Төслийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн “сургалтыг” гэснийг “сургалтыг бага, дунд, ахлах” гэж, 22.6 дахь хэсгийн “суралцах, хөдөлмөрийн зах зээлд шилжихэд” гэснийг “суралцахад” гэж, мөн зүйлийн 22.2 дахь хэсгийг хасаж, 22.3, 22.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төсөлд 22.7, 22.8 дэх хэсэг нэмэх:

“22.3.Ерөнхий боловсролын сургууль нь нэг бүлэгт суралцах суралцагчийн тоо, суралцагчийн ялгаатай хэрэгцээнээс хамаарч холимог бүлгээр хичээллэж болно.

22.5.Суралцагчийг ерөнхий боловсролын сургуулийн орчинд дасан зохицоход дэмжлэг үзүүлэх, сургалтын агуулгыг нөхөх зорилгоор энэ хуулийн 20.11, 20.12-т заасан сургалт үйл ажиллагаа, нэмэлт сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

22.7.Ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын ерөнхий хуулийн 30.1.15-д заасан журмыг баримтлан зайн болон цахим сургалтыг зохион байгуулна.

22.8.Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүсэлтээр бага боловсролыг гэрийн сургалтаар эзэмшүүлж болох бөгөөд гэрийн сургалт зохион байгуулах, түүнд хяналт тавих журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэсэн саналаар дахин санал хураалт явуулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9

Гуравны хоёроор дахин санал хураалгах санал дэмжигдлээ.

Г.Мөнхцэцэг: 2.Төслийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн “сургалтыг” гэснийг “сургалтыг бага, дунд, ахлах” гэж, 22.6 дахь хэсгийн “суралцах, хөдөлмөрийн зах зээлд шилжихэд” гэснийг “суралцахад” гэж, мөн зүйлийн 22.2 дахь хэсгийг хасаж, 22.3, 22.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төсөлд 22.7, 22.8 хэсэг нэмэх:

“22.3.Ерөнхий боловсролын сургууль нь нэг бүлэгт суралцах суралцагчийн тоо, суралцагчийн ялгаатай хэрэгцээнээс хамаарч холимог бүлгээр хичээллэж болно.

22.5.Суралцагчийг ерөнхий боловсролын сургуулийн орчинд дасан зохицоход дэмжлэг үзүүлэх, сургалтын агуулгыг нөхөх зорилгоор энэ хуулийн 20.11, 20.12-т заасан сургалт үйл ажиллагаа, нэмэлт сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

22.7.Ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын ерөнхий хуулийн 30.1.15-д заасан журмыг баримтлан зайн болон цахим сургалтыг зохион байгуулна.

22.8.Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүсэлтээр бага боловсролыг гэрийн сургалтаар эзэмшүүлж болох бөгөөд гэрийн сургалт зохион байгуулах, түүнд хяналт тавих журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9

77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Г.Мөнхцэцэг: 3.Төслийн 19 дүгээр зүйлийн нэрийг “Цэцэрлэг” гэж, 19.1 дэх хэсгийн “хүүхдийн цэцэрлэг /цаашид “цэцэрлэг” гэх/” гэснийг “Цэцэрлэг” гэж, 19.2 дахь хэсгийг 21.2 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.2.Сургалт, үйл ажиллагааг бага, дунд, ахлах болон бэлтгэл, холимог бүлгээр зохион байгуулна.” гэсэн саналаар дахин санал хураалт явуулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны тавьсан асуултад Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 2

Бүгд: 9

Гуравны хоёроор дахин санал хураалгах санал дэмжигдлээ.

Г.Мөнхцэцэг: 3.Төслийн 19 дүгээр зүйлийн нэрийг “Цэцэрлэг” гэж, 19.1 дэх хэсгийн “хүүхдийн цэцэрлэг /цаашид “цэцэрлэг” гэх/” гэснийг “Цэцэрлэг” гэж, 19.2 дахь хэсгийг 21.2 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.2.Сургалт, үйл ажиллагааг бага, дунд, ахлах болон бэлтгэл, холимог бүлгээр зохион байгуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 2

Бүгд: 9

77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Г.Мөнхцэцэг: 4.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.3.Ерөнхий боловсролын сургуульд судлах үндсэн гадаад хэл нь энэ хуулийн 10.1-д заасан сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалд туссан хэл байна.” гэсэн саналаар дахин санал хураалт явуулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам үг хэлэв.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 4

Бүгд: 9

Гуравны хоёроор дахин санал хураалгах санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Мөнхцэцэг: Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 3

Бүгд: 9

66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Мөнхцэцэг: Горимын санал дэмжигдсэн тул дээрх санал хураалт явуулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
Гуравны хоёроор дахин санал хураалгах санал дэмжигдлээ.

Г.Мөнхцэцэг: 4.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.3.Ерөнхий боловсролын сургуульд судлах үндсэн гадаад хэл нь энэ хуулийн 10.1-д заасан сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалд туссан хэл байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Г.Мөнхцэцэг: 5.Төслийн 30 дугаар зүйлийг төслөөс хасах гэсэн саналаар дахин санал хураалт явуулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9
Гуравны хоёроор дахин санал хураалгах санал дэмжигдлээ.

Г.Мөнхцэцэг: 5.Төслийн 30 дугаар зүйлийг төслөөс хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Г.Ганбаяр, Боловсрол, шинжлэх ухааны яамны Дээд болон мэргэжлийн боловсролын бодлогын газрын дарга Х.Тамир, мөн яамны Мэргэжлийн боловсрол, сургалтын хэлтсийн дарга А.Халиунаа, Боловсролын бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Цолмон, мөн газрын шинжээч Ж.Нарантуяа, Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах

шинжээч Ч.Баярмаа, Боловсрол, шинжлэх ухааны сайдын орон тооны бус зөвлөх Д.Билгүүдэй, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн секторын эрхлэгч У.Туяа, Шинжлэх Ухааны академийн Философийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Ш.Ариунаа, Монголын хувийн хэвшлийн бага, дунд сургуулиудын холбооны тэргүүн Н.Номин, Хувийн цэцэрлэгийн үүсгэн байгуулагчдын холбооны тэргүүн А.Цэнгэл, “Бүх нийтийн боловсролын төлөө” Иргэний нийгмийн үндэсний эвслийн ерөнхий зохицуулагч Д.Тунгалаг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Р.Болормаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Хуулийн төслийн 1, 20 дугаар зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан, Г.Мөнхцэцэг нарын тавьсан асуултад Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан хариулж, тайлбар хийв.

Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Г.Мөнхцэцэг: Ажлын хэсгийн гаргасан, 1.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтын “ахисан түвшний чадамжийг” гэснийг “чадамжийг” гэж, 3.1.9 дэх заалтын “богино хугацааны сургалтыг” гэснийг “сургалтыг” гэж, 3.1.11 дэх заалтын “өмнө эзэмшсэн мэдлэг” гэснийг “эзэмшсэн мэдлэг, ур чадвар” гэж, “мэдлэг, ур чадварыг” гэснийг “чадамжийг” гэж өөрчилж, 3.1.12 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.12."дадлагажуулагч" гэж суралцагчийг үйлдвэрлэлийн орчинд дагалдуулан сургах, ур чадвар эзэмшүүлэх үүрэг бүхий, арга зүйн сургалтад хамрагдсан ажилтныг” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	2
Бүгд:	9

77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын зорилго нь нийгмийн хөгжил, эдийн засгийн бүтээмжийг дэмжих, хөдөлмөрийн зах зээл, ур чадварын эрэлт, шаардлагад нийцсэн мэргэжлийн ур чадвар бүхий иргэн бэлтгэж, мэргэшлийн түвшин ахиулах, тасралтгүй хөгжих хэрэгцээг хангахад оршино.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.3 дахь заалт, 5.1.4 дэх заалтын "нийгмийн" гэснийг тус тус төслөөс хасаж, доор дурдсан агуулгатай 5.1.5, 5.1.6 дахь заалт нэмэх:

“5.1.5.хөгжлийн бодлогод нийцсэн байх;

5.1.6.хөдөлмөр эрхлэлт, ур чадварын хөгжлийг дэмжсэн байх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 6 дугаар зүйлийн 6.7 дахь хэсгийн “6.3,” гэснийг төслөөс хасаж, 6.2 дахь хэсгийн “бие даан ажил” гэснийг “хувиараа” гэж /цаашид тохиолдол бүрд/, 6.5 дахь хэсгийн “хэмжих ба багц цагийг дараагийн түвшний боловсролд тооцож дүйцүүлнэ” гэснийг “тооцох бөгөөд дараагийн боловсролын түвшинд дүйцүүлнэ” гэж, 6.6 дахь хэсгийн “багц цаг” гэснийг “Мэргэжлийн болон техникийн боловсролын багц цаг” гэж, 6.8 дахь хэсгийн “ажил олгогчийн” гэснийг “түншлэлийн” гэж өөрчилж, 6.14 дэх хэсгийн “тусгай” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн "тавигдах" гэснийг "тавих нийтлэг" гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Төслийн 8 дугаар зүйлийн гарчгийн “Үнэлгээ, баталгаажуулалт” гэснийг “Чанарын баталгаажуулалт” гэж, 8.2 дахь хэсгийн “Хүний өмнөх мэдлэг, ур чадвар, чадамжийг” гэснийг “Эзэмшсэн мэдлэг, ур чадварыг” гэж өөрчилж, 8.1 дэх хэсгийн "суралцагч" гэсний өмнө "мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын" гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 8.3, 8.4, 8.5, 8.6, 8.7 дахь хэсгийг нэмэх.

“8.3.Мэргэжлийн сургалтын байгууллагын төгсөгчийн чадамжийг үнэлэх, баталгаажуулах, гэрчилгээжүүлэх журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

8.4.Магадлан итгэмжлэлийг Боловсролын ерөнхий хуулийн 17.9-д заасан байгууллага мөн хуулийн 30.1.12-т заасан журмын дагуу хэрэгжүүлнэ.

8.5.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг таван жил тутам магадлан итгэмжилнэ.

8.6.Боловсролын ерөнхий хуулийн 29.1.8-д заасан мэргэжлийн болон техникийн боловсролын эрэлттэй, тэргүүлэх мэргэжлийн хөтөлбөрийг заавал магадлан итгэмжилнэ.

8.7.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага Боловсролын ерөнхий хуулийн 40.7-д заасны дагуу дотоод чанарын баталгаажуулалтыг хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	2
Бүгд:	9

77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “түвшинтэй” гэснийг “ангилалтай” гэж, 9.14 дэх хэсгийн “дадлагын баазад” гэснийг “чадамжийн төв, дадлагын баазад” гэж, 9.15 дахь хэсгийн “төв, бааз, аж ахуй” гэснийг “чадамжийн төв, дадлагын бааз, туслах аж ахуй” гэж өөрчилж, 9.12, 9.13 дахь хэсгийг нэгтгэн доор дурдсан агуулгатай 9.12 дахь хэсэг болгон өөрчлөн найруулж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 9.17 дахь хэсэг нэмэх:

“9.12.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага харьяалалдаа чадамжийн төв, салбар дундын дадлагын бааз, гарааны компани, бизнес инкубатор төв, туслах аж ахуйтай байж болно.

9.17.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага дотуур байртай байж болно. Дотуур байрын орчин, үйлчилгээний стандарт, техникийн зохицуулалтыг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд заасны дагуу баталж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	2
Бүгд:	9

77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтын “чанартай” гэснийг “Боловсролын ерөнхий хуулийн 30.1.31-д заасан журмын дагуу” гэж, 10.1.3 дахь заалтын “байгууллагаар дамжуулан” гэснийг “энэ хуулийн 9.12-т заасан байгууллагаар дамжуулан” гэж, 10.1.8 дахь заалтын “гэрээ хэлэлцээр байгуулах” гэснийг “хамтран ажиллах” гэж, 10.1.9 дэх заалтын “туслах /дэмжлэг үзүүлэх/” гэснийг “дэмжлэг үзүүлэх” гэж өөрчилж, 10.1.3 дахь заалтын "судалгаа хийх" гэсний дараа "зөвлөн туслах" гэж, 10.1.10 дахь заалтын "хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн" гэсний дараа "байгаль орчинд ээлтэй, жендэрийн мэдрэмжтэй, хүртээмжтэй" гэж /цаашид тохиолдол бүрд/ нэмж, 10.1.4 дэх заалтыг төслөөс хасаж, 10.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төсөлд 10.1.12 дахь заалт нэмэх:

“10.1.5.эзэмшсэн мэдлэг, ур чадварын үнэлгээг түншлэгч талтай хамтран зохион байгуулах;

10.1.12.түншлэлийг хэрэгжүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн "63.1, 63.2, 63.3 дахь заалтад" гэснийг "63 дугаар зүйлд заасныг" гэж өөрчилж, төслөөс 11.6 дахь хэсгийн “хяналт тавьж,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Төслийн 12 дугаар зүйлийн 12.3, 12.5, 12.6 дахь хэсгийг төслөөс хасаж, доор дурдсан агуулгатай 12.9 дэх хэсэг нэмэх:

“12.9.Дээд боловсролын тухай хуулийн 5.8-д заасан шаталсан сургалттай хөгжмийн дээд боловсролын сургалтын байгууллагын элсэгчид энэ хуулийн 12.1, 12.2 дахь хэсэг хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Төслийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “хөтөлбөрийг эзэмшсэн иргэнд” гэснийг “байгууллагыг төгсөгчид” гэж, 13.2 дахь хэсгийн "Иргэний албан бус боловсрол, амьдралын орчинд суралцаж эзэмшсэн чадамжийг" гэснийг "эзэмшсэн мэдлэг, ур чадварыг" гэж, мөн хэсгийн "13.1.1, 13.1.2" гэснийг "13.1" гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “5” гэснийг “3” гэж, 14.3 дахь хэсгийн “дээд түвшний чадамжтай” гэснийг “өндөр ур чадвартай” гэж, 14.2, 14.3 дахь хэсгийн “багшлах эрхтэй” гэснийг “багшлах эрхийн гэрчилгээтэй” гэж өөрчилж, төсөлд доор дурдсан агуулгатай 14.4 дэх хэсэг нэмэх:

“14.4.Багшийн мэдлэг, ур чадварын үнэлгээг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, мэргэжлийн холбоо, ажил олгогч, сургалтын байгууллагатай хамтран дөрвөн жил тутам зохион байгуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Төслийн 16 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 16.1.3 дахь заалт нэмэх:

“16.1.3.мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан, дотуур байрын багш, арга зүйч, номын санч, эмч, хоол зүйч, тогооч, сэтгэл зүйч, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэнд эхний тав дахь жил болон дараагийн гурав дахь жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг ажиллаж байгаа боловсролын сургалтын байгууллагаас олгох.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Төслийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалтын “хангагдсан” гэсний дараа “байгаль орчинд ээлтэй, жендэрийн мэдрэмжтэй, хүртээмжтэй” гэж, 17.2.1 дэх заалтын “сургалтын байгууллагын” гэсний өмнө “үйлдвэрлэлийн болон” гэж нэмж, 17.1.6 дахь заалтын "11.4" гэснийг "11.3" гэж, 17.2.5 дахь заалтын “явцад” гэснийг "үед" гэж өөрчилж, 17.2.1 дэх заалтын “байгууллагын” гэснийг, 17.2.3 дахь заалтыг төслөөс тус тус хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 17.3, 17.4 дэх хэсэг нэмэх:

“17.3.Суралцагч элссэн хөтөлбөрөөр суралцах хугацаандаа тухайн чиглэлийн мэргэжлийн бусад хөтөлбөрт суралцаж, хос мэргэжил эзэмшиж болно.

17.4.Суралцагч энэ хуулийн 17.3-т заасан ижил чиглэлийн мэргэжлийн хөтөлбөрт хамрагдах тохиолдолд сургалтын төлбөр төлөх бөгөөд тэтгэлгийг давхардуулан олгохгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Төслийн 19 дүгээр зүйлийн 19.2.1 дэх заалтын "боловсруулахад оролцох" гэсний дараа "санал болгох" гэж, 19.3.6 дахь заалтын "дадлага сургалтыг" гэсний дараа "байгаль орчинд ээлтэй, жендэрийн мэдрэмжтэй, хүртээмжтэй" гэж нэмж, 19.3.7 дахь заалтын "дадлагажуулагч багшаар" гэснийг "дадлагажуулагчаар" гэж өөрчилж, 19.3.13 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 19.4, 19.5, 19.6 дахь хэсэг нэмэх:

“19.3.13.дагалдан суралцагчид Хөдөлмөрийн тухай хуулийн 63 дугаар зүйлд заасны дагуу цалин хөлс олгох.

19.4.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 15.1.4, 15.1.5, 15.1.6, 15.1.9-д заасан зардал, дэмжлэг, хандивыг албан татвар ногдох орлогоос хасагдах зардалд тооцуулж болно.

19.5.Аж ахуйн нэгж, байгууллага нь эдийн засгийн үйл ажиллагааны салбар, үйлдвэрлэл, үйлчилгээний онцлогоос хамааран мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг дэмжих санд энэ хуулийн 22.1-д заасан Зөвлөлийн тогтоосон хувь хэмжээгээр санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.

19.6.Хосмог сургалт зохион байгуулсан тохиолдолд ажил олгогчоос болон ажилтнаас төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг Хөдөлмөрийн тухай хуулийн 63.3-т заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас төлнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Төслийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, 20.2.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 20.2.4 дэх заалт нэмэх:

“20.1.Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын мэдээллийн санг Боловсролын ерөнхий хуулийн 48.9-д заасан журмын дагуу бүрдүүлж, ажиллуулна.

20.2.1.хөдөлмөрийн зах зээл дэх ур чадварын эрэлт, нийлүүлэлт, төгсөгчийн хөдөлмөр эрхлэлт, мөшгөх судалгаа, ажил олгогчийн сэтгэл ханамжийн судалгааны мэдээлэл;

20.2.4.мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын чадамжийн болон үнэлгээний мэдээлэл.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1.Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын удирдлага нь Боловсролын ерөнхий хуулийн 27.1-т заасан удирдлагын тогтолцооноос бүрдэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Төслийн 22 дугаар зүйлийн “Үндэсний зөвлөл” гэснийг “Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын зөвлөл” гэж, 22.1 дэх хэсгийн “Үндэсний зөвлөл” гэснийг “мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын зөвлөл /цаашид “зөвлөл” гэх/” гэж, 22.2 дахь хэсгийн “төрийн захиргааны байгууллага” гэснийг “төрийн захиргааны төв байгууллага” гэж, мөн хэсгийн “бүрдэнэ” гэснийг “бүрдсэн нийт 15 гишүүнтэй байна” гэж, 22.3, 22.5 дахь хэсгийн “Засгийн газар” гэснийг “Боловсролын ерөнхий хуулийн 27.4-т заасан Үндэсний зөвлөл” гэж, 22.6 дахь хэсгийн “Засгийн газарт” гэснийг “Боловсролын ерөнхий хуулийн 27.4-т заасан Үндэсний зөвлөлд” гэж өөрчилж, төслийн 22.9.5 дахь заалтын “засгийн” гэсний дараа "эрэлттэй болон" гэж нэмж, 22.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.4.Зөвлөлийн даргыг гишүүдийн олонхын саналаар томилогдсон этгээд хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Төслийн 23 дугаар зүйлийн 23.1.8 дахь заалтын “их сургууль, дээд сургуулийн” гэснийг “дээд боловсролын сургалтын байгууллагын” гэж өөрчилж, 23.1.4, 24.1.7 дахь заалтын “тусгай” гэснийг, 23.1.8 дахь заалтын “энгийн” гэснийг, мөн зүйлийн 23.1.9 дэх заалтыг хасаж, доор дурдсан агуулгатай 23.1.10 дахь заалт нэмэх:

“23.1.10.төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын захирлыг сонгон шалгаруулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “хүрээнд” гэсний дараа “Боловсролын ерөнхий хуульд зааснаас гадна” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 24.1.7, 24.1.8 дахь заалт, 24.2 дахь хэсэг нэмэх.

“24.1.7.багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааг түншлэгч талуудтай хамтран зохион байгуулах;

24.1.8.багш, ажилтны мэргэжлийн зэрэг олгох, ахиулах, сунгах.

24.2.Энэ хуулийн 24.1.7-д заасан чиг үүргийг Засгийн газрын тухай хуулийн 19.1-д заасан байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 3

Бүгд: 9
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Төслийн 25 дугаар зүйлийн “25.2.1-25.2.10” дахь заалтын дугаарлалтыг “25.1.1-25.1.10” гэж өөрчилж, мөн зүйлийн, 25.2.9 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Төслийн 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчилж, төсөлд 26.5.3, 26.5.4, 26.5.5, 26.5.6 дахь заалт, 26.7 дахь хэсэг нэмэх:

“26.4.Удирдах зөвлөл нь нийт арван нэгэн гишүүнтэй байх бөгөөд төрийн захиргааны төв байгууллагаас гурав, нутгийн захиргааны байгууллагаас гурав, тухайн сургалтын байгууллагын хамт олныг төлөөлөх нэг, аж ахуйн нэгж, байгууллагыг төлөөлөх гурав, суралцагчийн нэг төлөөллөөс бүрдэнэ. Удирдах зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байна.

26.5.3.мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын тухайн жилийн төсвийн төслийг хэлэлцэх, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн хуваарилалтыг батлах, үр дүн, чанар, гүйцэтгэлд хяналт тавих;

26.5.4.төсвийн хязгаарт нийцүүлэн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаар, цалингийн санг тогтоох;

26.5.5.төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын захирлыг энэ хуулийн 23.1.10-т заасан журмын дагуу сонгон шалгаруулж, томилох, хууль тогтоомжид заасан үндэслэлээр чөлөөлөх;

26.5.6.боловсролын сургалтын байгууллагын захиралтай байгуулсан гэрээг дүгнэх.

26.7.Төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Төслийн 27 дугаар зүйлийн 27.2.1 дэх заалтын “бакалавр” гэснийг “магистр” гэж, 27.2.2 дахь заалтын “мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага” гэснийг “боловсролын сургалтын байгууллага” гэж, “10-аас” гэснийг “5-аас” гэж, “сургалтын менежер, арга зүйч, тэнхимийн эрхлэгчээр 4-өөс” гэснийг “удирдах албан

тушаалд гурваас” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 27.5.12, 27.5.13, 27.5.14 дэх заалт нэмэх:

“27.5.12.гүйцэтгэлд суурилсан санхүүжилт, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос багш, ажилтныг урамшуулах, нийгмийн баталгааг хангах боломж, нөхцөлийг бүрдүүлэх;

27.5.13.Боловсролын ерөнхий хуулийн 12.9-д заасны дагуу багшийн мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааг зохион байгуулах;

27.5.14.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26.2-т заасны дагуу батлагдсан төсвийн 0.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	3
Бүгд:	9

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Төслийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсгийг төслөөс хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	3
Бүгд:	9

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Төслийн 29 дүгээр зүйлийн 29.3.1 дэх заалтын “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан” гэснийг “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хуваарилсан хөрөнгө” гэж, 29.4.1 дэх заалтын “төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн, техникийн боловсролын сургалтын байгууллагын” гэснийг “өмчийн хэлбэр үл харгалзан мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 29.3.3, 29.3.4 дэх заалт нэмэх:

“29.3.3.төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын өөрийн болон туслах үйл ажиллагааны орлогын тодорхой хувь;

29.3.4.энэ хуулийн 19.4-т заасны дагуу төвлөрүүлсэн хөрөнгө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	2
Бүгд:	9

77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Төслийн 33 дугаар зүйлийг төслөөс хасах;

27.Хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг төсөл санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.

1.Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

2.Багшийн хөгжлийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

3.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

4.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

5.Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

6.Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

7.Хөдөлмөрийн эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай:

Төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

8.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай:

Төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Дээд боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл /Засгийн газар 2021.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Г.Ганбаяр, Боловсрол, шинжлэх ухааны яамны Дээд болон мэргэжлийн боловсролын бодлогын газрын дарга Х.Тамир, мөн яамны Мэргэжлийн боловсрол, сургалтын хэлтсийн дарга А.Халиунаа, Боловсролын бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Цолмон, мөн газрын шинжээч Ж.Нарантуяа, Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах шинжээч Ч.Баярмаа, Боловсрол, шинжлэх ухааны сайдын орон тооны бус зөвлөх Д.Билгүүдэй, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн секторын эрхлэгч У.Туяа, Шинжлэх Ухааны академийн Философийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Ш.Ариунаа, Монголын хувийн хэвшлийн бага, дунд сургуулиудын холбооны тэргүүн Н.Номин, Хувийн цэцэрлэгийн үүсгэн байгуулагчдын холбооны тэргүүн А.Цэнгэл, “Бүх

нийтийн боловсролын төлөө” Иргэний нийгмийн үндэсний эвслийн ерөнхий зохицуулагч Д.Тунгалаг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Дээд боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Хуулийн төслийн 4, 5, 9, 10, 23, 27, 30 дугаар зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, Г.Мөнхцэцэг, Ч.Ундрам нарын тавьсан асуултад Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Г.Ганбаяр, Боловсрол, шинжлэх ухааны яамны Дээд болон мэргэжлийн боловсролын бодлогын газрын дарга Х.Тамир нар хариулж, тайлбар хийв.

Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Г.Мөнхцэцэг: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.1.Энэ хуулийн зорилт нь дээд боловсролын удирдлага, зохион байгуулалт, сургалт, судалгаа, санхүүжилттэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.1.Дээд боловсролын зорилго нь нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах, дэвшилтэт шинэ санаа, судалгаа, инновацыг хөгжүүлэх, бүтээлчээр ашиглах, олон соёлын орчинд ажиллаж, амьдрах чадвартай, ёс суртахуунтай иргэн бэлтгэхэд оршино.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “Судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай хууль,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 2
Бүгд: 9
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “дээд боловсролын” гэсний дараа “сургалтын байгууллагын” гэж, 4.1.3 дахь заалтын “төлбөр,” гэсний дараа “судалгааны болон” гэж нэмж, 4.1.1 дэх заалтын “дипломын” гэснийг “дэд бакалаврын” гэж, 4.1.2 дахь заалтын “магистр, докторын хөтөлбөрийн сургалтыг” гэснийг “магистрын болон докторын хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг” гэж, 4.1.4 дэх заалтын “олгогдох” гэснийг “суралцагчид олгох” гэж өөрчилж, 4.1.5, 4.1.6 дахь заалтыг төслөөс хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 4.1.7 - 4.1.10 дахь заалт нэмэх:

4.1.7.“сургалтын төлбөрийн хөнгөлөлт” гэж дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчийн сурлагын амжилт, төлбөрийн чадамжийг тооцож төлбөрөөс тодорхой хувиар чөлөөлөхийг;

4.1.8.“шаталсан сургалт” гэж боловсролын бусад түвшний хөтөлбөрийг зэрэгцсэн болон дараалсан байдлаар хэрэгжүүлэх үйл ажиллагааг;

4.1.9.“грант” гэж Инновацын тухай хуулийн 3.1.7-д зааснаас гадна байгууллага, судлаачийн судалгааны ажилд зориулж иргэн, хуулийн этгээд, олон улсын байгууллагаас урьдчилан нөхцөл, болзолтой буцалтгүй олгох мөнгөн, мөнгөн бус хөрөнгийг;

4.1.10.“судалгааны их сургууль” гэж судалгааны үйл ажиллагаа эрхэлдэг, бакалавр болон ахисан түвшний сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг дээд боловсролын сургалтын байгууллагыг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төсөлд доор дурдсан агуулгатай 5 дугаар зүйл нэмэх:

“5 дугаар зүйл.Дээд боловсролын сургалтын байгууллага үйл ажиллагаандаа баримтлах зарчим

5.1.Дээд боловсролын сургалтын байгууллага үйл ажиллагаандаа Боловсролын ерөнхий хуульд зааснаас гадна дараах зарчмыг баримтална:

5.1.1.эрдмийн эрх чөлөөг эрхэмлэх;

5.1.2. оюуны бүтээл, судалгааны ёс зүйг дээдлэх;

5.1.3.дээд боловсролын сургалтын байгууллагын бие даасан байдлыг дэмжсэн байх;

5.1.4.хамтын удирдлагатай, улс төрөөс хараат бус байх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналыг найруулгын засвартайгаар дэмжлээ.

6.Төслийн 2 дугаар бүлгийн гарчгийн “БОЛОВСРОЛЫН” гэсний дараа “СУРГАЛТЫН” гэж нэмж /цаашид тохиолдол бүрд/, төслийн 5.1 дэх хэсгийн “гэсэн ангилалтай” гэснийг, мөн зүйлийн 5.2, 5.3 дахь хэсгийг төслөөс хасаж, 5.5, 5.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 5.7-5.9 дэх хэсэг нэмэх:

5.5.Энэ хуулийн 5.1, 6.7-д заасан дээд боловсролын сургалтын байгууллагын ангиллыг техникийн зохицуулалтад үндэслэн боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

5.6.Цэрэг, цагдаагийн мэргэжлийн чиглэлийн сургалтын үйл ажиллагааг Боловсролын ерөнхий хуулийн 3.1.19-д заасан төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллага эрхэлнэ.

“5.7.Энэ хуулийн 5.1, 6.7-д заасан дээд боловсролын сургалтын байгууллагад тавих техникийн зохицуулалтыг Засгийн газар батална.

5.8.Консерватор нь ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсрол, техникийн болон дээд боловсрол эзэмшүүлэх шаталсан сургалттай хөгжмийн дээд боловсролын сургалтын байгууллага байна.

5.9.Технологийн коллеж нь бүрэн дунд боловсрол, техникийн болон дээд боловсролын шаталсан сургалттай, дэд бакалавр, бакалаврын зэрэг олгох сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг дээд боловсролын сургалтын байгууллага байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Төслийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.4, 6.6 дахь хэсгийг төслөөс хасаж, 6.1, 6.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 6.7- 6.10 дахь хэсэг нэмэх:

“6.1.Их сургууль нь дэд бакалавр, бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг сургалт, судалгаа, туршилт-үйлдвэрлэлийн байгууллага байна.

6.5.Их сургууль нь харьяалалдаа коллеж, технологийн коллеж, политехник коллеж, мэргэжлийн боловсролын сургууль, судалгааны лаборатори, төв, хүрээлэн, ахлах сургууль, дадлагын баазтай байж болно.

6.7.Их сургуулийг үйл ажиллагааны хүрээ, сургалт, судалгааны чиглэл, сургалтын хөтөлбөр, суралцагч, төгсөгчийн тоо, бусад холбогдох үзүүлэлтэд үндэслэн судалгааны, сургалтын, мэргэжлийн гэж ангилна.

6.8.Их сургууль нь сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор байж болно.

6.9.Багш бэлтгэх их сургууль нь харьяалалдаа цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, соёл, урлаг, цэргийн мэргэжлийн чиглэлээр сургалтын үйл ажиллагаа эрхэлдэг их сургууль нь бүрэн дунд сургуультай /6-12 дугаар анги/ байж болно.

6.10.Судалгааны их сургуулийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал хуулиар байгуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “бакалаврын сургалт эрхлэх эрх бүхий сургалтын” гэснийг “дэд бакалавр, бакалавр, магистрын зэрэг олгох сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг сургалт, судалгааны” гэж, 7.4 дэх хэсгийн “боловсрол, сургалтын байгууллагатай” гэснийг “боловсролын сургууль, ахлах сургуультай” гэж өөрчилж, төслийн 7.2, 7.3, 7.5 дахь хэсгийг төслөөс хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 8.2 дахь хэсгийг төслөөс хасах:

“8.1.Коллеж нь дэд бакалавр, бакалавр, магистрын зэрэг олгох сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг сургалт-судалгаа, сургалт-үйлдвэрлэлийн байгууллага байна.

8.3.Коллеж нь харьяалалдаа политехник коллеж, мэргэжлийн боловсролын сургууль, ахлах сургуультай байж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “зөвшөөрөл” гэсний өмнөх “, тусгай” гэснийг хасаж, 9.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.3.Төрийн бус өмчийн дээд боловсролын сургалтын байгууллага боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрснөөр харьяаллын сургууль байгуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “Эрдмийн зөвлөл,” гэсний дараа “хөтөлбөрийн хороо,” гэж, 10.3 дахь хэсгийн “Эрдмийн” гэсний дараа “зөвлөл болон хөтөлбөрийн хороо,” гэж нэмж, төслийн 10.5 дахь хэсгийн “Төрийн өмчийн” гэснийг, мөн зүйлийн 10.4, 10.6, 10.7, 10.9, 10.11, 10.15 дахь хэсгийг төслөөс хасаж, 10.14 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 10.16 -10.18 дахь хэсэг нэмэх:

“10.14.Дээд боловсролын сургалтын байгууллага нь дотуур байртай байж болно. Дотуур байранд тавигдах шаардлагыг стандарт, техникийн зохицуулалтаар тогтооно.

10.16.Дээд боловсролын сургалтын байгууллага нь сургалтын хөтөлбөр боловсруулах, үнэлэх, сайжруулах дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус Хөтөлбөрийн хороотой байна.

10.17.Энэ хуулийн 10.5-д заасан их сургуулийн эмнэлэг нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, сургалт-эрдэм шинжилгээний үйл ажиллагаа эрхэлж болно.

10.18.Энэ хуулийн 9.2-т заасан дээд боловсролын сургалтын байгууллага нь цэрэг, цагдаагийн тогтолцоонд хамаарах анги, байгууллага, цэргийн байртай байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Төслийн 11 дүгээр зүйлийг 18 дугаар зүйл болгон шилжүүлж, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“18 дугаар зүйл.Дээд боловсролын сургалтын байгууллагын элсэлт

18.1.Дээд боловсролын сургалтын байгууллагын дэд бакалавр, бакалаврын хөтөлбөрт бүрэн дунд боловсрол эзэмшсэн, элсэлтийн шаардлага хангасан хүнийг элсүүлнэ.

18.2.Политехник коллеж, шаталсан сургалттай дээд боловсролын сургалтын байгууллагын төгсөгч тухайн мэргэжлийн чиглэлээр дэд бакалавр, бакалаврын хөтөлбөрт элсэхэд энэ хуулийн 18.1 дэх хэсэг хамаарахгүй.

18.3.Боловсролын ерөнхий хуулийн 17.8, энэ хуулийн 18.8-д заасан үнэлгээ, элсэлтийн шалгалт зохион байгуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

18.4.Дэд бакалавр, бакалаврын хөтөлбөрт элсэгчийн элсэлтийн шалгалтын босго оноог өмчийн хэлбэр харгалзахгүйгээр боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн ижил хэмжээгээр тогтооно.

18.5.Элсэлтийн шалгалтын босго оноог шинэчлэхэд өмнөх босго оноог бууруулахгүйгээр тогтооно.

18.6.Дээд боловсролын сургалтын байгууллага мэргэжил эзэмшихэд шаардагдах мэдлэг, ур чадварыг харгалзан элсэлтийн нэмэлт шалгалт зохион байгуулж болно.

18.7.Ахисан түвшний сургалтад элсэгч, суралцагчид тавих шаардлага, элсэлтийн шалгалтыг сургуулийн дотоод журмаар зохицуулна.

18.8.Элсэлтийн шалгалтын зохион байгуулалт, үнэлгээний арга зүйг олон улсын чиг хандлагад нийцүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	3
Бүгд:	9

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Төслийн 12 дугаар зүйлийн гарчгийн **“Чанарын баталгаажуулалт”** гэсний өмнө **“Дээд боловсролын”** гэж нэмж, 12.1 дэх хэсгийн “үйл ажиллагааны” гэснийг, мөн зүйлийн 12.5, 12.6, 12.9, 12.12 дахь хэсгийг төслөөс хасаж, төслийн 12.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төсөлд доор дурдсан агуулгатай 12.13-12.18 дахь хэсэг нэмэх:

“12.8.Дээд боловсролын сургалтын байгууллага, Боловсролын ерөнхий хуулийн 12.4, энэ хуулийн 12.16-д заасан хөтөлбөр, тэргүүлэх, эрэлттэй мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг 5 жил тутам магадлан итгэмжилнэ.

12.13.Дээд боловсролын сургалтын байгууллагын үндэсний эрэмбэ, чансаа, хөтөлбөрийн чанарыг энэ хуулийн 12.18-д заасан цахим сангийн мэдээлэлд үндэслэн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээний байгууллагатай хамтран хоёр жил тутам тогтоон олон нийтэд мэдээлнэ.

12.14.Энэ хуулийн 12.13-т заасан хөндлөнгийн үнэлгээ зохион байгуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

12.15.Анагаах ухааны чиглэлийн сургалтын хөтөлбөрийг заавал магадлан итгэмжилнэ.

12.16.Хөтөлбөрийн магадлан итгэмжлэл, дээд боловсролын сургалтын байгууллагын эрэмбэ, чансааны үзүүлэлт тухайн байгууллагын суралцагчид хуульд заасан дэмжлэг, зээл, тэтгэлэг олгох үндэслэл болно.

12.17.Дээд боловсролын цахим мэдээллийн сан нь Боловсролын ерөнхий хуулийн 48.3-г зааснаас гадна магадлан итгэмжлэл, эрдэм шинжилгээний бүтээл, санхүүжилт, иргэний гадаад улсад эзэмшсэн боловсрол, үнэлгээ, хөдөлмөр эрхлэлт зэрэг мэдээллээс бүрдэнэ.

12.18.Энэ хуулийн 12.8-д заасан хугацаагаар 3 удаа магадлан итгэмжлэл хийлгэсэн дээд боловсролын сургалтын байгууллага цаашид 10 жил тутам магадлан итгэмжлэл хийлгэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Төслийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалтын “эрдэм шинжилгээ” гэснийг “судалгааны ажилд оролцох, бусад сургуулийн суралцагч, багштай хамтран” гэж өөрчилж, төслийн 13.1.6 дахь заалтын “баялаг болгон хувиргах” гэснийг, мөн зүйлийн 13.1.4, 13.1.7 дахь заалтыг төслөөс хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай 13.1.10, 13.1.11 дэх заалт нэмэх:

“13.1.10.улиралд судлах багц цагийг сонгож, суралцах хугацааг төлөвлөх;
13.1.11.ижил түвшний бусад сургуулийн хичээл болон багшийг сонгон суралцах багц цагийг дүйцүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Төслийн 14 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 14.1.4 дэх заалт нэмэх:

“14.1.4.хууль тогтоомжид заасан сургалтын төлбөрийн хөнгөлөлт эдлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Төслийн “Суралцагчийн сургалтын үнэлгээ” гэсэн 15 дугаар зүйлийг 21 зүйл болгон шилжүүлж доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21 дүгээр зүйл. Суралцагчийн үнэлгээ, төгсөлт

21.1.Суралцагчийн үнэлгээ нь суралцахуйн үр дүнг бататгах, бие даан суралцах үйл ажиллагаа, бүтээлч хандлагыг дэмжих, авьяас, ур чадварыг хөгжүүлж урамшуулахад чиглэнэ.

21.2.Дээд боловсролын сургалтын байгууллагын онцлогоос хамааран суралцагчийн судалгааны ажлын үр дүн, суралцаж буй мэргэжлийн чиглэлээр олон улсын тэмцээн, уралдаанд гаргасан амжилтыг багц цагт тооцож болно.

21.3.Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчийн үнэлгээний үлгэрчилсэн журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

21.4.Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчийн суралцахуйн үр дүнг үнэлэх үйл ажиллагааг энэ хуулийн 15.4-т заасан журмаар Боловсролын ерөнхий хуулийн 17.7-д заасан байгууллага, мэргэжлийн холбоод, ажил олгогчийн төлөөлөл хамтран хэрэгжүүлнэ.

21.5.Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид диплом олгох, хүчингүй болгох, гадаадын дээд боловсролын сургалтын байгууллага төгссөн төгсөгчийн дипломыг хүлээн зөвшөөрөх, бүртгэх, баталгаажуулахтай холбогдох харилцааг Боловсролын ерөнхий хуулийн 30.1.31-д заасан журмаар зохицуулна.

21.6.Магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийг тухайн дээд боловсролын сургалтын байгууллагын дотоод журмаар, докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн бүрэлдэхүүн болон дүрмийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Төслийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “хичээлийг” гэснийг “хөтөлбөрийг хэрэгжүүлэх” гэж, “багш заана” гэснийг “байна” гэж өөрчилж, 16.3 дахь хэсгийг төслөөс хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 16.2, 16.5 дахь хэсэг нэмэх:

“16.2.Дээд боловсролын сургалтын байгууллагын багш нь магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байна.

16.5.Дээд боловсролын сургалтын байгууллага нь тухайн сургалтын байгууллагын багшийн мэргэжлийн хөгжлийг хангах журмыг баталж, хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Төслийн 17 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 17.2.3 дахь заалт нэмэх:

“17.2.3.судалгаа, эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 2
Бүгд: 9
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Төслийн 18 дугаар зүйлд доор дурдсан 18.2 дахь хэсэг нэмж, мөн зүйлийн 18.1.4 дэх заалтыг 18.3 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“18.2.Дээд боловсролын сургалтын байгууллагын багшид тухайн ажиллаж байгаа байгууллагаас дараах дэмжлэгийг үзүүлж болно:

18.2.1.орон нутаг дахь төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад ажиллаж байгаа багш, ажилтанд орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийг 5 жил тутамд нэг удаа олгох;

18.2.2.дээд боловсролын сургалтын байгууллагын харьяа мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн багшид Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 18.1.3-т заасан тэтгэмж олгох.

18.3.Энэ хуулийн 18.1.4, 18.1.5-т заасан дээд боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны нийгмийн баталгааг хангахтай холбогдсон бусад харилцааг тухайн сургалтын байгууллагын дотоод журмаар зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Төслийн “Сургалтын зохион байгуулалт” гэсэн 21 дүгээр зүйлийг 19 дүгээр зүйл болгож, төслийн 21.2 дахь хэсгийн “Магистр, докторын сургалтын” гэснийг “Дээд боловсролын сургалтын байгууллага нь сургалт,” гэж өөрчилж, мөн зүйлийн 21.4 дэх хэсгийг төслөөс хасаж, 21.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төсөлд доор дурдсан агуулгатай 21.5-21.8 дахь хэсэг нэмэх:

“21.3.Дээд боловсролын хичээлийн жил нь улиралд хуваагдах бөгөөд 2-4 улиралтай байж болно. Суралцах хугацааг элсэлтийн шалгалттай уялдуулан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөгөөр зохицуулна.

21.5.Суралцагч элссэн мэргэжлийн чиглэлийн хөтөлбөрт суралцах хугацаанд бусад мэргэжлийн чиглэлийн хөтөлбөрт давхар суралцаж хос мэргэжил эзэмшиж болно.

21.6.Ахисан түвшний сургалтын хөтөлбөрийг эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран хэрэгжүүлж болно.

21.7.Дээд боловсролын сургалтын байгууллага нь төгсөгчийн мэргэжлийн хөгжлийг хангах, насан туршийн суралцахуйн тогтолцоог бүрдүүлэх ажлыг зохион байгуулна.

21.8.Дээд боловсролын сургалтын байгууллага нь бие даан эсхүл хамтран цахим сургалтын системийг бүрдүүлэн сургалт зохион байгуулж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	3
Бүгд:	9

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Төслийн “Сургалтын хөтөлбөр” гэсэн 19 дүгээр зүйлд “Сургалтын хөтөлбөрийн агуулга” гэсэн 20 дугаар зүйлийг нэгтгэн ”Сургалтын хөтөлбөр, агуулга” гэсэн 20 дугаар зүйл болгож, төслийн 19.1 дэх хэсгийг төслөөс хасаж, төслийн 20.2 дахь хэсгийн “Сургалтын хөтөлбөрийн агуулга нь” гэснийг “Дэд бакалавр, бакалаврын сургалтын хөтөлбөрт” гэж өөрчилж, төсөлд доор дурдсан агуулгатай 19.9-19.15, 20.5 дахь хэсэг нэмж, төслийн 20.3, 20.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19.9.Сургалтын агуулгыг багц цагаар тооцох, багц цагийг дүйцүүлэх журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

19.10.Дээд боловсролын сургалтын байгууллага нь суралцагчийн хүсэлтээр энэ хуулийн 19.2-т заасан журмын дагуу бакалавр-магистрын 150-иас, магистр-докторын 90-ээс доошгүй багц цаг бүхий нэгдмэл агуулгатай хөтөлбөрийг хэрэгжүүлж болно.

19.11.Энэ хуулийн 19.10-т заасан нэгдмэл хөтөлбөрөөр суралцсан төгсөгчид тухайн түвшин бүрийн боловсролын баримт бичгийг олгоно.

19.12.Бакалаврын хөтөлбөрт суралцаж 90 багц цаг судалсан боловч цаашид суралцах боломжгүй болсон дэд бакалаврын зэрэг олгоход тавих шаардлагыг хангасан тохиолдолд тухайн боловсролын баримт бичгийг дүйцүүлэн олгож болно.

19.13.Боловсролын ерөнхий хуулийн 3.1.4-т заасан багц цаг нь дээд боловсрол эзэмшихэд тавих шаардлага, сургалтын төлөвлөгөө, төлбөр, багшийн ажлын ачаалал зэргийг тогтоох үндэслэл болно.

19.14.Боловсролын ерөнхий хуулийн 30.1.10-т заасан дээд боловсролын мэргэжлийн чиглэл, хөтөлбөрийн индексийн жагсаалтыг 5 жил тутам шинэчлэн батална.

19.15.Сургалтын хөтөлбөрийг тухайн дээд боловсролын сургалтын байгууллага, мэргэжлийн холбоо, ажил олгогч, төгсөгчийн төлөөллөөс бүрдсэн энэ хуулийн 10.3-т заасан хөтөлбөрийн хороо хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.

20.3.Дээд боловсролын түвшин нь багц цагаар хэмжигдэх дэд бакалаврын, бакалаврын, магистрын, докторын зэрэгтэй байна.

20.4.Багц цагийн хэмжээ нь дэд бакалаврын зэрэгт 90 багц цагаас доошгүй, бакалаврын зэрэгт 120 багц цагаас доошгүй, магистрын зэрэгт 30 багц цагаас доошгүй, докторын зэрэгт 60 багц цагаас доошгүй байна.

20.5.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг төгсөгч эзэмшсэн мэргэжлийн чиглэлээр дээд боловсролын сургалтын байгууллагад суралцахад багц цаг дүйцүүлэн тооцож болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	2
Бүгд:	9

77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Төсөлд “**ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ИННОВАЦ**” гэсэн **ТАВДУГААР БҮЛЭГ** нэмж, төслийн 22 дугаар зүйлийг тус бүлэгт хамааруулан, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 22.8 дахь хэсэг нэмэх:

“22.8.Их сургууль салбар дундын судалгааны нээлттэй лаборатори болон технологийн туршилт, зүгшрүүлэлтийн нэгдсэн сүлжээг байгуулж ажиллуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	2
Бүгд:	9

77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Төсөлд доор дурдсан агуулгатай 23 дугаар зүйл нэмэх:

“23 дугаар зүйл. Судалгааны ёс зүй

23.1.Дээд боловсролын сургалтын байгууллагын багш, суралцагчийн эрдэм шинжилгээний бүтээлийн нэгдсэн мэдээллийн сангийн бүртгэл, мэдээлэл солилцох, хадгалах, хамгаалах, баяжуулах, ашиглахтай холбогдох үйл ажиллагааг Шинжлэх ухаан, технологийн сан хариуцна.

23.2.Дээд боловсролын сургалтын байгууллага нь сургалтын байгууллагын багш, суралцагчийн судалгааны ажил хуулбарлалт шалгах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

23.3.Дээд боловсролын судалгааны ёс зүйг Боловсролын ерөнхий хуулийн 27.4-т заасан судалгааны ёс зүйн дэд хороо хариуцна.

23.4.Энэ хуулийн 23.3-т заасан Зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

23.4.1.эрдмийн ажилд оюуны өмч, зохиогчийн эрхийг дээдлэх, зөрчихгүй байх, зөрчихөөс урьдчилан сэргийлэх талаар дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх журам, заавар, зөвлөмж боловсруулах, батлах;

23.4.2.энэ хуулийн 23.4.1-д заасан журмын хэрэгжилтэд хяналт тавих;

23.4.3.судлаачийн ёс зүйн зөрчлийн талаарх гомдлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хянан хэлэлцэх, энэ хуулийн 23.4.1-д заасан журмын дагуу шийдвэрлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Төслийн 5 дугаар бүлгийг 6 дугаар бүлэг болгож, төслийн 23.1 дэх хэсгийн “боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байх бөгөөд” гэснийг хасаж, 23.1.4 дахь заалтын “зэрэг” гэсний дараа “, цол” гэж нэмэн, мөн зүйлийн 23.1.3 дахь заалтыг төслөөс хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай 23.1, 23.3, 23.4 дэх хэсэг нэмэх:

“23.1.Дээд боловсролын удирдлага нь Боловсролын ерөнхий хуулийн 27.1-д заасан байгууллагаас бүрдэнэ.

23.3.Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх нэгжтэй байж болно.

23.4.Энэ хуулийн 23.3-т заасан нэгжийг Засгийн газрын шийдвэрээр байгуулж, бүтэц, ажиллах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналыг найруулгын засвартайгаар дэмжлээ.

25.Төслийн 24 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“24 дүгээр зүйл. Дээд боловсролын зөвлөл

24.1.Боловсролын ерөнхий хуулийн 27.4-т заасан мэргэжлийн зөвлөл нь Дээд боловсролын зөвлөл байна.

24.2.Дээд боловсролын зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх) нь дээд боловсролын удирдлага, зохион байгуулалт, сургалт, судалгааны үйл ажиллагаа, үр дүнг хэлэлцэх, санал зөвлөмж гаргах, оролцогч талуудын оролцоо, хамтын ажиллагааг дэмжих чиг үүрэг бүхий орон тооны бус байгууллага байна.

24.3.Зөвлөл нь төрийн, дээд боловсролын сургалтын байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага болон үйлдвэр, аж ахуйн нэгж, оюутны төлөөллөөс бүрдсэн 15 гишүүнтэй байна.

24.4.Зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг Боловсролын ерөнхий хуулийн 27.6-д заасны дагуу боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Төслийн 25 дугаар зүйлийн 25.4-25.7, 25.9 дэх хэсгийг төслөөс хасаж, мөн зүйлийн 25.10-25.13 дахь хэсэг нэмж, 25.2, 25.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“25.2.Удирдах зөвлөл нь үүсгэн байгуулагч, тухайн сургуулийн багш, суралцагч, төгсөгч, ажил олгогчийн төлөөлөл бүхий 15 хүний бүрэлдэхүүнтэй байна.

25.3.Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлд үүсгэн байгуулагчийн төлөөлөл найм, багшийн төлөөлөл гурав, төгсөгч, ажил олгогчийн гурав, суралцагчийн нэг төлөөлөл байна.

25.10.Төрийн бус өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн энэ хуулийн 25.3-т заасан төлөөллийн оролцоог хангасан байна.

25.11.Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллага дундаа Удирдах зөвлөл байгуулж болно. Энэ тохиолдолд энэ хуулийн 25.3-т заасан төлөөллийг оролцуулсан байна.

25.12.Энэ хуулийн 25.11-д заасан Удирдах зөвлөл байгуулах тохиолдолд зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг Засгийн газар батална.

25.13.Энэ хуулийн 25.1-д заасан удирдах зөвлөлийн даргыг сонгох, гишүүнээр ажиллах, бүрэн эрхийн хугацаа дуусгавар болгох, дарга, гишүүнийг эргүүлэн татах харилцааг зохицуулах удирдах зөвлөлийн нийтлэг дүрмийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Төслийн 26 дугаар зүйлийн 26.1.4 дэх заалтын “журмын дагуу” гэсний дараа “төрөөс хараат бусаар” гэж нэмж, 26.1.10 дахь заалт, 26.3, 26.4 дэх хэсгийг төслөөс хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Төсөлд доор дурдсан агуулгатай 27 дугаар зүйл нэмэх:

“27 дугаар зүйл. Эрдмийн зөвлөл

27.1.Эрдмийн зөвлөл нь 21-ээс доошгүй гишүүнээс бүрдэх бөгөөд гишүүнээр эрдмийн зэрэг, цолтой багшийг үндсэн орон тооны нийт багш нарын хурлаар сонгоно.

27.2.Эрдмийн зөвлөл нь доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

27.2.1.сургалт, судалгааны чиглэлийг тогтоох, хэрэгжилтийн үр дүнг хэлэлцэх, дүгнэлт гаргах;

27.2.2.дэд профессор, профессор хүндэт цол олгох;

27.2.3.судалгааны төсөл болон ахисан түвшний сургалт судалгааны үр дүнг хэлэлцэх, дүгнэх.

27.3.Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагаанд холбогдох бусад харилцааг тухайн дээд боловсролын сургалтын байгууллагын Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагааны журмаар зохицуулна.

27.4.Эрдмийн зөвлөл нь сургалт, эрдэм шинжилгээний бодлого, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох чиг үүрэг бүхий орон тооны бус байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 2

Бүгд: 9

77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Төслийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 27.4 дэх хэсгийн “цагдаа, аюулгүй байдлын” гэснийг “цагдаагийн” гэж, “хууль тогтоомжид” гэснийг “хуульд” гэж өөрчилж, мөн хэсгийн “тус тус” гэснийг хасаж, мөн зүйлийн 27.2, 27.5 дахь хэсгийг төслөөс хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай 27.7, 27.8 дахь хэсэг нэмэх:

“27.1.Дээд боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэх удирдлага нь дээд сургууль, коллежид захирал /цаашид “захирал” гэх/, их сургуульд ректор /цаашид “ректор” гэх/ байна.

27.7.Цэрэг, цагдаагийн дээд боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэх удирдлагад энэ хуулийн 27.6-д зааснаас гадна нэмэлт шаардлага тавьж болно.

27.8.Төрийн болон орон нутгийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэх удирдлагыг сонгон шалгаруулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 2
Бүгд: 9
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Г.Дамдинням дээрх саналын томьёоллын 27.7 дахь хэсгийг татан авч, үг хэлэв.

30.Төслийн 28.1.9 дэх заалтын “бусад харилцааг” гэсний дараа “сургуулийн” гэж нэмж, 29.1.1 дэх заалтын “төрөөс болон удирдах зөвлөлөөс” гэснийг “эрх бүхий этгээдийн” гэж өөрчилж, төсөлд доор дурдсан агуулгатай 29.2 дахь хэсэг нэмэх:

“29.2.Дээд боловсролын сургалтын байгууллага доор дурдсан хамтын ажиллагааг хэрэгжүүлэх үүрэгтэй:

29.2.1.олон улсад өрсөлдөх чадвартай багшлах хүний нөөцийг бэлтгэх, дэмжих;

29.2.2.онцгой авьяастай суралцагчийг дэмжих, авьяасыг хөгжүүлэх хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх;

29.2.3.дээд боловсролын сургалтын байгууллага хооронд харилцан тохиролцсон бусад хэлбэр.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

31.Төслийн 30.1 дэх хэсгийн “байгууллагын санхүүжилт нь” гэсний дараа “Боловсролын ерөнхий хуульд зааснаас гадна” гэж, 30.1.2 дахь заалтын “олон улсын” гэсний дараа “байгууллага” гэж нэмж, “сангуудаас татах” гэснийг “сангаас олгох” гэж өөрчилж, “албан ёсны зээл” гэснийг хасаж, 30.1.4 дэх заалтын “их, дээд сургуулийн” гэснийг “дээд боловсролын сургалтын байгууллагын” гэж, “компаниас орох” гэснийг “компанийн үйл ажиллагаанаас орсон” гэж өөрчилж, 30.1.7 дахь заалтын “олсон орлого” гэсний дараа “гэрээт ажил, үйлчилгээ, түрээс, аж ахуйн үйл ажиллагаанаас орсон орлого” гэж нэмж, 30.1.5, 30.1.6, 30.1.8 дахь заалт, 30.5 дахь хэсгийг төслөөс хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай 30.1.10-30.1.15 дахь заалт, 30.6-30.9 дэх хэсэг нэмж, төслийн 30.2, 30.3 дахь хэсгийг нэгтгэн 30.2 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“30.1.10.хүүгийн орлого;
30.1.11.байгууллагын болон судалгааны грант;
30.1.12.өрсөлдөөнт төсөл;
30.1.13.их сургуулийн эмнэлгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнээс олсон орлого;
30.1.14.хөрөнгө оруулалтын зээл;
30.1.15.орон нутгийн төсвийн дэмжлэг;

30.2.Дээд боловсролын сургалтын байгууллагад улсын төсвөөс дараах дэмжлэг үзүүлнэ:

30.2.1.тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэлээр суралцагчид олгох сургалт, судалгааны тэтгэлэг;

30.2.2.улс орны нийгэм, эдийн засагт үзүүлэх ач холбогдол бүхий Засгийн газрын захиалгат судалгаа шинжилгээ, дэвшилтэт технологи дамжуулалт болон инновацын үйл ажиллагааны зардал;

30.2.3.төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын эзэмшиж, ашиглаж байгаа хөрөнгийн төрийн өмчийн тогтмол зардал;

30.4.Энэ хуулийн 30.1.1-30.1.15-д заасан эх үүсвэрээс бүрдсэн орлогыг захиран зарцуулах журмыг тухайн дээд боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөл батална.”

30.6.Дээд боловсролын сургалтын байгууллагын эндаументын сангийн бүрдүүлэлт болон зарцуулалттай холбогдох нийтлэг журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

30.7.Аймаг, нийслэлийн мэргэжилтэй ажилтны хэрэгцээг хангах зорилгоор нутгийн захиргааны байгууллагаас дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид зориулсан санхүүгийн дэмжлэг олгож болох бөгөөд уг дэмжлэгийг төрөл, хэмжээ, олгох нөхцөл, журмыг тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал тогтоож, тухайн жилийн төсөвтөө тусган санхүүжүүлнэ.

30.8.Энэ хуулийн 30.2-т заасан зардлыг гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлнэ.

30.9.Энэ хуулийн 30.2-т заасан зардлыг санхүүжүүлэх журмыг Засгийн газар батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 2

Бүгд: 9

77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

32.Төслийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалт, 31.2, 31.3 дахь хэсгийг төслөөс хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай 31.1.5 дахь заалт нэмэх:

“31.1.5.дээд боловсролын сургалтын байгууллагын үндсэн үйл ажиллагааг дэмжих зорилгоор мөнгөн хөрөнгийн удирдлагыг оновчтой зохион байгуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 2

Бүгд: 9

77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

33.Төслийн 33 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

34.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн дугаарлалт, бүлэг, зүйл, хэсэг, заалтын дугаарыг агуулгын хувьд эрэмбэлэн, үг найруулгыг жигдлэн, хууль зүйн техникийн болон бусад засварыг хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 43 минут үргэлжилж, 16 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 62.5 хувийн ирцтэйгээр 17 цаг 42 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААН, СПОРТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Г.МӨНХЦЭЦЭГ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 06 дугаар сарын 27-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их Засаг” танхим,
14 цаг 59 минут

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Мөнхцэцэг: Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн ирц бүрдсэн тул нээснийг мэдэгдье. Хуралдааны дэгийн дагуу ирцийн танилцуулгыг хийе.

Амгалангийн Аджьасүрэн /Баянхонгор аймаг, 3 дугаар тойрог/ ирсэн байна. Пүрэв-Очирын Анужин /Сонгинохайрхан дүүрэг, 28 дугаар тойрог/ ирсэн байгаа. Тилеуханы Аубакир /Баян-Өлгий аймаг 2 дугаар тойрог/, Ёндонпэрэнлэйн Баатарбилэг /Архангай аймаг 1 дүгээр тойрог/ чөлөөтэй, Балжсиньямын Баярсайхан /Завхан аймаг, 9 дүгээр тойрог/ чөлөөтэй байна. Энхбаярын Батшугар /Сонгинохайрхан дүүрэг, 28 дугаар тойрог/ гадаад томилолттой байна. Хассуурийн Ганхуяг /Баянгол дүүрэг 26 дугаар тойрог/ ирж байна. Гонгорын Дамдинням /Дархан-Уул, 19 дүгээр тойрог/ орон нутагт ажиллаж байна. Бадарчийн Жаргалмаа /Сонгинохайрхан дүүрэг, 27 дугаар тойрог/ ирсэн байна. Цэрэнжамцын Мөнхцэцэг /Сүхбаатар дүүрэг, 24 дүгээр тойрог/ өвчтэй байна. Чинбатын Ундрэм /Сэлэнгэ аймаг, 13 дугаар тойрог/ ирсэн байна. Ням-Осорын Учрал /Сонгинохайрхан дүүрэг, 28 дугаар тойрог/ гадаад томилолттой байна. Жигжидсүрэнгийн Чинбүрэн /Баянзүрх дүүрэг, 23 дугаар тойрог/, Содномын Чинзориг /Өвөрхангай аймаг, 10 дугаар тойрог/ ирсэн байна. Лувсанцэрэнгийн

Энх-Амгалан /Хөвсгөл аймаг, 17 дугаар тойрог/ ирсэн байна. Ирц бүрдсэн тул өнөөдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 3 асуудал хэлэлцэнэ.

1 дүгээрт Боловсролын ерөнхий хуулийн хамт өргөн мэдүүлсэн Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийнэ. Засгийн газраас 2021 оны 06 дугаар сарын 24-ний өдөр өргөн мэдүүлсэн.

2 дугаарт Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Дээд боловсролын тухай судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай хуулийн анхны хэлэлцүүлгийг хийнэ. Засгийн газраас 2021 оны 06 дугаар сарын 24-ний өдөр өргөн мэдүүлсэн.

3 дугаарт Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн анхны хэлэлцүүлгийг хийнэ. 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн байгаа.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу. Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё. Энх-Амгалан сайд санал хэлье.

Л.Энх-Амгалан: Байнгын хорооны дарга аа, хэлэлцэх асуудал дээр санал алга. Тэгээд хэлэлцэх асуудлын жагсаалт дээр Мэргэжлийн болон техникийн боловсролын хуулийг 2 дугаарт оруулаад, тэгээд Дээд боловсролын хуулийг 3 дугаарт хэлэлцэх асуудлаар оруулж өгөөч гэж санал гаргаж байна. Яагаад гэвэл бид нар чинь мэргэжлийн багц хуулиа яриад, тэгээд СӨБ, ЕБС-ээ ярьж байгаад, тэгээд мэргэжлийн боловсрол, дээд гээд шат шатлалаар нь. Эхлээд Сургуулийн өмнөх болон ЕБС-ийн хуулиа

1 дүгээрт эцсийн хэлэлцүүлэг хийдгээрээ хийгээд, хоёрт нь Мэргэжлийн болон техникийн боловсролын хуулиа оруулж өгөөч ээ. Гуравт нь Дээд боловсролын хуулиа гэж хэлэлцэх асуудлын дарааллыг л.

Г.Мөнхцэцэг: Энх-Амгалан сайдын гаргасан саяын хуралдааны өнөөдрийн хэлэлцэх асуудлын дараалалд өөрчлөлт оруулж өгөөч гэсэн энэ санал дээр санал хураалт явуулна. Энх-Амгалан сайдын хэлж байгаагаар хоёрдугаарт хэлэлцэгдэх байсан Ерөнхий боловсролын хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Дээд боловсролын тухай болон Судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай хуулийг 3 дугаарт оруулж өгөөд, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2 дугаар хуульд өгөөч гээд өнөөдөр хэлэлцэх асуудлын дугаарлалтыг өөрчилж байгаа. Энэ дээр санал хураалтаар шийднэ. Санал хураалт явуулъя. Санал хураалт. Энэ санал хураалт 88,9 хувиар дэмжигдлээ.

Хэлэлцэх асуудалдаа оръё. Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Энэ эцсийн хувилбарын төсөл болон эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг гишүүдэд тараасан байгаа. Танилцуулгатай холбоотойгоор асуух асуулттай гишүүд байна уу. Алга байна. Туваан гишүүнээр тасаллаа. Туваан гишүүний микрофоныг өгье.

Ц.Туваан: Боловсролын хууль маань ингээд багц хууль парламент руу ороод ерөнхийдөө зарим хуулиуд нь ингээд эцсийн хэлэлцүүлэг рүү орох гэж байна. Тэгэхээр энэ дээр бас зарим нэг асуудлыг тодруулж асуух шаардлага үүсээд байгаа юм. Юу гэхээр маш олон

хүмүүсээс ялангуяа энэ тойрогт ажиллахаар энэ сургуулийн болон цэцэрлэгийн багш, иргэдээс энэ боловсролтой холбоотой маш их саналууд ирдэг. Энэ дотор яг энэ хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад энэ СӨБ буюу сургуулийн өмнөх боловсрол дээр та бүхэн энэ юун дээр сая энэ Нийгмийн даатгалын багц хууль ингээд бас давхцаад явж байна. Ялангуяа сайдаас асуучихъя. Энэ багц хууль ингээд явж байгаа дээр энэ орон нутагт ажиллаж байгаа цэцэрлэгийн багш нар, бага ангийн багш нар, дунд ангийн багш нараас энэ биеийн тамирын багш, дууны багш гээд ийм хүмүүс бид нар энэ мэргэжлийн шалтгаантай энэ асуудал их байна. Бид нарын ажил хөдөлмөр жишээлэх юм бол нас өндөр болох тусам цэцэрлэгийн багш хийхэд бол маш хүнд байна. Яагаад вэ гэхээр бид нарыг багшаа гэхгүй ер нь шуудхан хэлэхэд ихэнх нь эмэгтэй хүмүүс ажиллаж байгаа эмээ гээд байна. Тэгэхээр энэ асуудлыг дээр бид нарт тэтгэвэр чинь дээшийгээ сонголттой болж байгаа юм бол энэ доошийгоо сонголттой болох асуудлыг оруулж өгөөч гэдэг ийм асуудал нэлээн тавигддаг. Тэгэхээр энэ асуудал дээр та бүхэн ямар санал өгсөн бэ. Нийгмийн даатгалын багц хууль дээр. Тэгээд ер нь цаашидаа салбарын яам ер нь энэ дээр ямар бодлого барьдаг юм. Энийг нэг сонсчихмоор байна. Биеийн тамирын багш нар гэхэд л 60 дөхчихсөн эрэгтэй биеийн тамирын багш тэнд ажиллахад бол яаж ч бодсон бас л хүнд байгаа шүү дээ. Тийм ээ. Дуу хөгжмийн багш ч гэсэн ялгаагүй. Тэгэхээр ийм нэг асуудал байна.

2 дугаарт нь цэцэрлэг дээр ингээд явахаар дуу хөгжмийн багш, дууны, хөгжмийн боловсрол олгох багшийн хүрэлцээ, хангамж гэдэг асуудал бол ерөөсөө байхгүй. Дуу хөгжмийн багшгүй цэцэрлэг энэ тэр бол зөндөө байгаа. Энэ асуудал чинь энэ хууль дотроо яаж тусаж өгсөн бэ. Ялангуяа энэ юу сургуулийн өмнөх цэцэрлэг дээр ямар байдлаар туссан бэ гэдэг 2 дахь асуулт.

3 дугаар асуулт бол энэ юу байгаа шүү дээ. Хүүхдийн хоолны мөнгөтэй холбоотой асуудал. Орон нутагт ингээд явахаар цэцэрлэгийн хүүхдийн хоолны мөнгө бол ерөөсөө 2475 төгрөг. Тэгээд энэ чинь хүүхдүүд ингээд юун дээрээ зарим нь тендер зарлаад нэг дэлгүүр шалгараад, зарим нь ч ингээд яаж авдаг юм мэдэхгүй. Тэгээд авахаар одоо юмны үнийн өсөлт чинь ямар байгаа билээ. Юмны үнэ тэнгэрт татчихсан. Инфляц ийм өндөр байгаа үе дээр энэ 2475 төгрөг гэдэг юм чинь ерөөсөө өөрчлөгдөөгүй ээ. Тэгээд та хэд энийг мэдсээр байж ингээд нүдэн балай чихэн дүлий гэдэг шиг ингээд энэ асуудал ингээд нэлээн удчихлаа шүү дээ. Бид нар энэ дээр юмны үнэ нэг дахин дор хаяж нэмэгдчихсэн, гурил хэд болчхов, 9-ийн тос нугарчихсан байгаа энэ үед ямар бодлого баримталсан бэ. Орон нутаг дээр явахаар нэг хүлээлт үүссэн байна лээ. Засгийн газрын шийдвэр гарчихсан яамны түвшинд энэ асуудлыг шийдэхийг хүлээж байна л гээд байгаа юм. Сүүлийн миний мэдэхийн лав 2 ч удаа сумд ажиллахад энэ асуудлууд ингээд яригдаж байна лээ. Тэгэхээр энэ дээр яг цаашид барих байр суурь, гаргах шийдвэр чинь ямар байгаа вэ гэсэн асуултад хариулт авъя.

Г.Мөнхцэцэг: Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийг танилцуулъя. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан Боловсрол, шинжлэх ухааны сайд, Ганболдын Ганбаяр Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд, Төмөр-Очирын Ням-Очир Боловсролын ерөнхий газрын дарга, Жадамбын Мягмар Боловсрол, шинжлэх ухааны яамны Сургуулийн өмнөх боловсролын хэлтсийн дарга, Жамцын Нарантуяа Боловсрол, шинжлэх ухааны яамны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын шинжээч, Ухнаагийн Туяа Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн секторын эрхлэгч, Шажинбатын Ариунаа Шинжлэх Ухааны академийн

Философийн хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ажилтан, шинжлэх ухааны доктор, профессор, Чимэдрэгзэний Баярмаа Боловсрол, шинжлэх ухааны яамны Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах шинжээч, Арьяагийн Цолмон Боловсрол, шинжлэх ухааны яамны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч, Авирмэдийн Халиунаа Боловсрол, шинжлэх ухааны яамны Мэргэжлийн боловсрол, сургалтын хэлтсийн дарга, Халиунаа байна уу. Дарьсүхбаатарын Билгүүдэй Боловсрол, шинжлэх ухааны сайдын орон тооны бус зөвлөх, Замбалын Цогтгэрэл Монголын боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга, Наранцэцэгийн Номин Монголын хувийн хэвшлийн бага, дунд сургуулиудын холбооны тэргүүн, Алтангэрэлийн Цэнгэл Хувийн цэцэрлэгийн үүсгэн байгуулагчдын холбооны тэргүүн, Дондогдуламын Тунгалаг Бүх нийтийн боловсролын төлөө иргэний нийгмийн үндэсний эвслийн ерөнхий зохицуулагч. Ийм бүрэлдэхүүнтэй өнөөдрийн хуралдаанд оролцож байна.

Сая Туваан гишүүний асуусан асуултад Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Туваан гишүүний асуултад хариулъя. Туваан гишүүн ээ, ийм байгаа юм. Багш нарын энэ тэтгэврийн настай холбоотой асуудлуудыг цаашидаа энэ салбаруудын салбар хуулиудаар зохицуулагдахгүй гэдэг нэг ийм зарчмыг бид нар Засгийн газар дээр ярьсан юм. Ерөнхийдөө яах вэ, энэ Боловсролын багц хуулийн хэлэлцүүлгийн үед сүүлийн 2 жилд хийсэн хэлэлцүүлгүүдээс хамгийн их өндөр дэмжлэг авсан асуудал энэ багш нарын тэтгэврийн насны л асуудал байгаа юм л даа. Тэгэхээр энэ дээр мэргэжлийн онцлогоос шалтгаалж багш нарыг арай жсаахан эрт тэтгэвэрт гарах энэ эрх зүйн боломжуудыг нь гаргаж өгөх ийм бололцоо байна уу л гэдэг нэг зүйлийг тавьж байгаа юм. Тэгэхээр Засгийн

газар дээр одоо яг нийт төрийн үйлчилгээний болон төрийн албанд ажиллаж байгаа хүмүүсийн цалин хөлсний тогтолцооны асуудлуудыг бас нэг тогтолцоогоор явах ийм шударга ёсны ийм тогтолцоо байх ёстой гэж ойлгож байгаа.

2 дугаарт бас цаашидаа Монгол Улс тэтгэврийн насны тогтолцоог тухайн салбарын салбар хуулиудаар хийдэггүй. Яг энэ Улсын Их Хурал дээр орж ирээд хэлэлцэгдэж эхэлж байгаа Нийгмийн даатгалын энэ багц хуулиудаар цаашидаа Монгол Улсад ямар насны хүмүүс ямар нөхцөл хангасан хүмүүс тэтгэврээ тогтоолгож явах вэ, тэтгэвэр нь ямар хэлбэрээр тогтоолгох вэ гэдэг нь Нийгмийн даатгалын хуулиар зохицуулагдаад явах гэж байгаа учраас та Нийгмийн даатгалын байнгын хороо дээрээ энэ саналуудаа гаргаж, санал хураалгаж байр сууриа илэрхийлсэн нь зөв болов уу гэж бодож байна.

2 дугаар асуудал энэ хөдөө орон нутагт байгаа цэцэрлэгийн багш нар, дуу хөгжмийн багш нарын хомсдолын асуудлыг та хөндөж ярьж байна. Ерөнхийдөө багш нарын хомсдол байгаа юу гэвэл байгаа. Цаашидаа бид нар энэ хууль батлагдаж гарснаар ерөнхийдөө 330 сумд 12 жилийн ерөнхий боловсролын сургуулийн тогтолцоотой байж байгаа энэ үр дүнгүй, тэгээд тодорхой ямар нэгэн үндэслэлгүйгээр сургуулийн хэв шинжүүдийг зохион байгуулсан асуудлуудыг бид нар ер нь эргээж харна гэж бодож байгаа. Тийм учраас аль аль сум дээр, бага сургуулиуд, аль аль сургуулиуд дээр дунд сургуулиуд, аль аль сум дундын ахлах сургуулиуд байгуулагдах вэ гэдэг бол хууль батлагдаж гарсны дараа нэлээн том зохицуулалтууд хийгдэнэ. Энэ хүрээнд бол одоо энэ сумууд дээр байгаа, тэр тусмаа алслагдсан сумууд дээр байгаа цэцэрлэг, бага сургуулиудыг цогцолбор хэлбэрээр ажиллуулах ийм зохицуулалтуудыг бид нар хийнэ. Энэ хүрээнд тэр цэцэрлэг дээр дутагдаж

байгаа дуу хөгжмийн багш, биеийн тамирын багшийн асуудлуудыг бол шийдэх ийм шийдлүүд нь байгаа болов уу гэж харж байгаа.

3 дахь асуудал бол хоолны мөнгийг хөндөж байна. Хоол бол ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар анги дээр төр 100 хувь даадаг ийм хууль зүйн зохицуулалттай. Тийм учраас бол цаашидаа ч гэсэн энэ хуульд л өөрчлөлт орохгүй бол төр энэ 1-5 дугаар ангийнхаа хүүхдийн хоолны зардлыг төр дааж явахаас өөр сонголт байхгүй. Харин сургуулийн өмнөх боловсролын тухайд 3-5 настай хүүхэд цэцэрлэгт хамрагдаж байгаа хүүхдүүдийн хоолны зардлыг ер нь эцэг эхчүүдтэй нь хуваалцах ийм эрх зүйн зохицуулалт өнөөдөр хүртэл хүчин төгөлдөр байгаа хуулиар нээлттэй байгаа. Тэгээд бид нар нэлээн судалгаа хийсэн. Та сая анзаарсан байх. Бид нар үндэсний хэмжээний том чуулганыг бас өнгөрсөн сард хийж ер нь бүх хөдөө орон нутгаас энэ хоолтой холбоотой, хоол үйлдвэрлэлтэй холбоотой энэ бүх төлөөллүүдийг оролцуулж бас нэлээн том зөвлөгөөн хийсэн. Энэ үеэр хийсэн судалгаагаар бол нийт эцэг эхчүүд асран хамгаалагч нар 60 хувь нь хоолны тодорхой хэлбэрийг эцэг эхчүүд нь хуваалцах энэ тогтолцоогоо сэргээх нь зөв гэсэн ийм хариултуудыг өгсөн байгаа. Тэгээд бид нар Засгийн газар дээр оруулж энэ асуудлуудаа шийдвэрлээд явна гэсэн ийм төлөвлөгөөтэй байна. Хэлэлцэж байгаа асуудалдаа оръё. Туваан гишүүн дэгээрээ хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор сургуулийн өмнөх боловсрол чинь харин саналын томъёоллоороо. Тодруулъя. Туваан гишүүний микрофоныг өгье.

Ц.Туваан: Хуулиудыг бол дэмжиж байгаа. Тэгэхдээ энэ дотор бас ярих тодруулах асуудал Улсын Их Хурлын гишүүнийхээ хувиар байна гэж харж байгаа гэдгийг бас энэ Байнгын хорооны дарга, сайдуудад хэлчихье. Тэгээд энэ дээр Нийгмийн даатгалын багцууд хэлэлцэж байгаа мэдэж байгаа. Энэ дээр

ядаж энэ салбарын онцлогтой холбоотой салбарын яам нь энэ багш нарынхаа өндөр насны тэтгэвэр дээр ямар байр суурьтай байдаг юм бэ гэдгийг л би асуусан юм. Нэгдүгээрх нь.

Хоёрдугаарх нь би 33 хэсэг Засаг захиргааны нэгжийн цэцэрлэгүүдтэй уулзсан. Заамар сумын цэцэрлэгийн эрхлэгч л ганихан цэцэрлэгийн хүүхдийн хоолны мөнгийг тодорхой хувийг эцэг эхээс даахыг дэмжиж байгаа гэж хэлсэн. Бусад нь бүгд эсрэг байна лээ. Яагаад эсрэг байгаа юм бэ гээд асуухаар бид нар энэ хүүхдүүдийг чинь хамран сургах хувь гэдэг юм байдаг юм аа. Тэгэхээр амьдрал ийм хүнд хэцүү байгаа цагт дээрээс нь энэ хүүхдүүдийн тэр.../минут дуусав/

Г.Мөнхцэцэг: Энх-Амгалан гишүүн гүйцээгээд хариулъя.

Л.Энх-Амгалан: Энэ хууль дээр цэцэрлэгийн хүүхдийн хооллолттой холбоотой зохицуулалтууд ямар нэгэн зохицуулалтууд, тэр тусмаа хүүхдийн цэцэрлэгийн хоолны тарифтай холбоотой зохицуулалтууд ерөөсөө байхгүй. Тэгэхээр бид нар ойлгож байгаа. Одоо бид нар чинь 2 сонголтын л өмнө ирчхээд байгаа шүү дээ.

1-т нь бол одоогийнхоор төр даагаад ингээд явна. Би СӨБ-ын түвшинд ярьж байна шүү Туваан гишүүн ээ. СӨБ-ын түвшинд даагаад яваад байна гэхээр 2475 төгрөгөөр өнөөдөр үдийн хоол өгөхөд энэ үнэ инфляцуудын өссөний дараа бол өнөөдөр хүүхэд цэцэрлэгээс авах ёстой калорийнхоо дөнгөж 40 хүрэхгүй хувийг авч байна. Далд хагас өлсгөлөн хэлбэрт л байгаад байгаа байхгүй юу. Тэгээд бид нар хүүхдийн яг энэ цэцэрлэгийн хоолны хүүхдийн мөнгөн дээр чинь жилд 70 орчим тэрбум төгрөг төсвөөс санхүүжүүлээд яваад байдаг. Тэгэхээр мэдээж энийг хамгийн багадаа бид нар 4 мянган төгрөг болгоно гэвэл дахиад энэ төсвөөс санхүүжүүлэх 70 тэрбум чинь

140 тэрбум төгрөг болох гээд байгаа юм. Эцэг эхчүүдтэй хуваалцаж байсан саяхныг хүртэл хуваалцаж байсан шүү дээ. Саяхныг хүртэл хуваалцаж байсан. Ингээд энийг цаашидаа бид нар хуваалцах юм бол юу гэдэг юм яг хэдэн хувийг нь эцэг эхчүүд, асран хамгаалагч нар гаргах вэ. Яг ямар ямар хүн амынхаа эмзэг давхарга орлого багатай иргэдийнхээ хүүхдүүдийг төр даагаад явах вэ. 1 цэцэрлэгт цэцэрлэгийн насны 2-3 хүүхэдтэй байгаа гэр бүлүүд дээр бид нар ямар ямар хөнгөлөлтүүд өгөх вэ гэдэг энэ тооцооллуудыг бид нар хийж байна Туваан гишүүн ээ. Тэгээд удахгүй бид нар Засгийн газар дээр энэ асуудлуудаа оруулж, ингэж шийдвэр гаргуулах л ийм төлөвлөгөөтэй байгаа юм.

Г.Мөнхцэцэг: Хариулт авч дууслаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор бас хуралдааны дэгийг даваад уншиж танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-д заасны дагуу нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж боловсруулсан зарчмын зөрүүтэй саналыг хураалгана гэсэн ийм хуралдааны дэг байгаа.

Тийм учраас өнөөдрийн хэлэлцэж байгаа ерөнхий боловсролын тухай хуулийн төслийн талаарх ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрөөтэй 5 саналаар санал хураалт явуулна. Санал хураалгах зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг уншиж танилцуулъя.

1.Төслийн 17 дугаар зүйлийн 17.1.3 дахь заалтын “нөхцөл боломжийг бүрдүүлэх” гэснийг, мөн зүйлийн 17.6 дахь хэсгийг төслөөс хасаж, 17.1.5 дахь заалтын “сургуулийн” гэснийг “сургууль, дотуур байрын” гэж өөрчилж, 17.1.3

дахь заалтын “суралцагчийн хөгжил, төлөвшилийг дэмжих” гэсний өмнө “хамран сургах тойргийн хүүхэд бүрийг үзэж, сургуульд бүрэн хамруулах, бүртгэх ажлыг зохион байгуулах,” гэж, “сургалтын” гэсний дараа “үйл ажиллагааны” гэж, 17.1.5 дахь заалтын “зохион байгуулах” гэсний дараа “эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, тэдний эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах,” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 17.1.10, 17.1.11 дэх заалт, 17.7, 17.8 дахь хэсэг нэмж, 17.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“17.1.8.боловсролын чанар, үр дүнг суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, нутгийн удирдах болон захиргааны байгууллагад тухайн хичээлийн жилд тайлагнах;

17.1.10.энэ хуулийн 18.8-д заасан байгууллагад арга зүйн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

17.1.11.Төсвийн тухай хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж, төсөв, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагналтай холбоотой мэдээллийг багш, ажилтан, суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид ил тод, нээлттэй, ойлгомжтой байдлаар мэдээлэх.

17.7.Боловсролын ерөнхий хуулийн 10.2 дахь хэсэг, энэ хуулийн 13.1.2, 13.1.3-т заасан үүргээ биелүүлээгүй суралцагчийг ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтны болон сэтгэл зүйчийн зөвлөгөө, үйлчилгээнд хамруулж болно. Шаардлагатай тохиолдолд холбогдох хуульд заасан үйлчилгээнд холбон зуучилж болно.

17.8.Боловсролын ерөнхий хуулийн 45.3-т заасан эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй байгуулах гэрээнд сургалтын төлбөр төлөх, хураамж авах

харилцаанд багш, суралцагчийг оролцуулахыг хориглоно.”

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ санал 70 хувиар дэмжигдлээ.

2.Төслийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн “сургалтыг” гэснийг “сургалтыг бага, дунд, ахлах” гэж, 22.6 дахь хэсгийн “суралцах, хөдөлмөрийн зах зээлд шилжихэд” гэснийг “суралцахад” гэж, мөн зүйлийн 22.2 дахь хэсгийг хасаж, 22.3, 22.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төсөлд 22.7, 22.8, 22.9 дэх хэсэг нэмэх:

“22.3.Ерөнхий боловсролын сургууль нь нэг бүлэгт суралцах суралцагчийн тоо, суралцагчийн ялгаатай хэрэгцээнээс хамаарч холимог бүлгээр хичээллэж болно.

22.5.Суралцагчийг ерөнхий боловсролын сургуулийн орчинд дасан зохицоход дэмжлэг үзүүлэх, сургалтын агуулгыг нөхөх зорилгоор энэ хуулийн 20.11, 20.12-т заасан сургалт үйл ажиллагаа, нэмэлт сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

22.7.Ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын ерөнхий хуулийн 30.1.15-д заасан журмыг баримтлан зайн болон цахим сургалтыг зохион байгуулна.

22.8.Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүсэлтээр бага боловсролыг гэрийн сургалтаар эзэмшүүлж болох бөгөөд гэрийн сургалт зохион байгуулах, түүнд хяналт тавих журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ санал 77,8 хувиар дэмжигдлээ.

Саяын эхний хураагдсан 2 санал бол өөрөө гуравны хоёроор дэмжигдэж хураагдсан, одоо бол ердийн олгохоор хураана гэдэг энэ саналаар санал хураалт. 1 дүгээр саналаар санал

хураалт. Сая уншаад танилцсан. Энэ санал 77,8 хувиар дэмжигдлээ.

Одоо сая уншиж танилцуулсан 2 дугаар саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. Энэ санал 7,8 хувиар дэмжигдлээ.

3.Төслийн 19 дүгээр зүйлийн нэрийг “Цэцэрлэг” гэж, 19.1 дэх хэсгийн “хүүхдийн цэцэрлэг /цаашид “цэцэрлэг” гэх/” гэснийг “Цэцэрлэг” гэж, 19.2 дахь хэсгийг 21.2 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.2.Сургалт, үйл ажиллагааг бага, дунд, ахлах болон бэлтгэл, холимог бүлгээр зохион байгуулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалтыг цуцалъя. Туваан гишүүн асуултаа асууя. Санал хураалттай холбогдуулж асууна шүү дээ. Туваан гишүүний микрофоныг өгье.

Ц.Туваан: Үгүй ээ, яах вэ энэ хуулийг дэмжиж байгаа гэдгээ би хэлсэн. Дээрээс нь энэ бодлогын юмнуудыг чинь хэдүүлээ бас ярьчихсан нь зөв байх. Тэгээд л энд тэнд гараад ямар хэвлэл дээр ярьж байгаа биш. Ер нь иргэдээс ирж байгаа санал. Энэ хууль чинь өөрөө иргэдэд зориулж батлагдаж байгаа шүү дээ. Тэгэхээр би тэрийг дамжуулах хүнийхээ хувьд л ингээд яриад байгаа. Өөр байнгын хороо ч гэсэн. Тэгэхээр энэ дээр нэг тодруулах юм нь би энийг СӨБ гээд явчихсан чинь ЕБС-тэй холбоотой юмнууд бас зарчмын зөрүүтэй санал яваад байна. Тэгэхээр би яг жилийн өмнө энэ Байнгын хорооны хуралдаан дээр оруулж ирж зарчмын зөрүүтэй санал гаргаж байсан. Тэр нь юу гэхээр маш тийм бодитой санал байхгүй юу. Одоо хөдөө орон нутгаас сонгогдсон гишүүд та хэд бүгдээрээ мэдэж байгаа. Хөдөө орон нутагт 6 настай хүүхэдтэй эцэг эхүүд чинь ялангуяа малчид, тариаланчид хүүхдүүдээ дагаад гэр бүл 2 салчхаад байгаа байхгүй юу. Тэгээд үүний дагаж гарч ирж байгаа тэр сөрөг нөлөөлөл нь маш их байгаа. Тийм учраас хөдөө аж

ахуйн салбарт ажиллагсдын хүүхдийг 7 настайгаас сургаж өгнө үү гэсэн ийм зарчмын зөрүүтэй санал гараад тэр үед дэмжигдээд тэгээд суугдаад явсан. Одоо тэгээд сая бас харсан чинь энэ заалт ондоо болчихсон. Өөрөөр хэлбэл юу гэдэг юм чуулган дээр дэмжигдээгүй гээд ингэж байна. Тэгэхээр сая сайдаас асуухаар энэ заалт арай өөр байдлаар сонголттой болсон гэдэг ийм тайлбарыг хэлж байна. Тэгэхээр энэ дээр би бас нэг ямар болчхов гээд өөрийнхөө гаргасан зарчмын зөрүүтэй саналын талаарх юмнуудынхаа араас ингээд явж байгаа санаатай юм.

2 дугаарт нь энэ анги дүүргэлт. Одоо жишээлэх юм бол манай Төв аймгийн зарим сумдад 12 дугаар ангид сумд сурч байгаа хүүхэд 6, 7 хүүхэдтэй сум байна. Энэ хүүхдүүд дээр байгалийн шинжлэх ухаан хамгийн гол шинжлэх ухааны мэдлэгийг авах ёстой энэ хүүхдүүд дээр авч чадахгүй байгаа асуудал зөндөө байгаа. Яагаад гэхлээр анги дүүргэлт байхгүй, багш байхгүй гээд иймэрхүү асуудлууд бас байгаа юм. Тэгэхээр энэ асуудал дээр бол яах вэ зарчмын зөрүүтэй санал гараагүй. Тэгэхдээ энэ дээр бас ямар байдлаар ажлын хэсэг тэртээ тэргүй энд орж ирчихсэн байгаа юм чинь би бас Их Хурлын гишүүнийхээ хувиар ийм асуудлыг асуучихъя.

Дараагийн ЕБС-тэй холбоотой нэг асуудал нь Монгол хэлний түвшин тогтоох шалгалт гээд нэг шалгалт явсан. 3 сум дээр би бүүр тодорхой хэлье. Би энэ асуудлаар Ганбаяр дэд сайдтай ярьж байсан. Нөгөө хүмүүс дээр мэдээлэл дутуу байдлаасаа болоод маш олон хүүхдүүд Монгол хэлний шалгалтад уначихсан. Би ЭЕШ өгч чадахгүй юм байна гэдэг ийм асуудлаар надад бүр асуудал тавиад, зарим эцэг эх бүүр уйлж ирээд хүүхэд нь энэ шалгалтдаа уначихсан гээд алга болчихлоо, сэтгэл санааны хүнд хохиролд орчихлоо энэ тэр гээд ийм асуудлууд ярьсан байхгүй юу. Тэгэхээр энэ байдлыг бас зохицуулалт нь

орсон байх. Тэгээд цаашидаа ер нь энэ дээр ямаруу байдлаар шийдэж байгаа вэ гэдэг дээр нэгэнт энэ ажлын хэсэг орж ирсэн байгаа учраас боломж байвал нэг хариулт өгчхөөч ээ гэсэн ийм хүсэлт байна.

Г.Мөнхцэцэг: Малчдын хүүхэд, хөдөө аж ахуйд хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн хүүхдүүдийг сургуульд хамруулах насны талаар манай Туваан гишүүн зарчмын зөрүүт санал хураалгасан. Энэ санал өөрөө бас хурал дээр ороод уначихсан. Гэхдээ энэ өөрөө ерөнхий боловсролын энэ хууль дотор тодорхой хэмжээгээр заагдсан байгаа гэсэн учир шалтгаанаар унасан. Энэ талаар тэгээд 2, 3 асуулт асуулаа. Энэ чиглэлээр нь Энх-Амгалан сайд хариулт өгчихье.

Л.Энх-Амгалан: Туваан гишүүн ээ, таны гаргасан санал бол зарчмаараа дэмжигдсэн гэж бол ойлгож болно Туваан гишүүн ээ. Тэрнээс биш таны гаргасан санал унасан гэж та бас нийтэд мэдээлж болохгүй шүү. Харин та сайн санал гаргасан учраас таны саналуудыг тал талаас нь ярьж байгаад нэлээн сайн боловсруулагдаж орсон. Таны санал бол 4.7 дээр хүүхдийн өсөлт хөгжил, эрүүл мэндийн болон бусад хүндэтгэх шалтгаантай хүүхдийг 7 настайд нь ЕБС-д элсүүлж болно.

4.8 дээр энэ хуулийн 4.7-д заасан тохиолдол үүсэхэд эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь Ерөнхий боловсролын сургуулийн захиргаанаас өгсөн чиглэлийн дагуу хүүхдийн хөгжлийг дэмжинэ гэж ингэж орсон байгаа юм. Тэгэхээр яах вэ бид нар би ч гэсэн хөдөөгөөс сонгогдсон гишүүн. Яг өнөөдөр малчдын хүүхдүүдийн асуудлаас болоод хүүхэд 6 настайгаас болоод үнэхээр нийгэм дээр томоохон асуудал үүссэн гэдгийг бол бид нар бүгдээрээ мэдэж, ойлгож байгаа. Энэ дээр тэгээд хамгийн зөв шийдэл л хэрэгтэй юм байгаа юм. Тэгэхдээ хамгийн зөв шийдэл нь яг амьдрал дээр

хэрэгжих тийм шийдэл хийхгүй бол бид нар ингээд хуулиуд дээр нэг ийм лоозонгийн шинж чанартай заалтууд хийгээд, тэр нь амьдрал дээр очихоор хэрэгжихэд их хүндрэлтэй байдаг ийм нөхцөлүүдийг бид нар харгалзаж үзэж, ерөнхийдөө энэ хуулиар авч байгаа бид нарын том давуу талууд бол ер нь сургалтыг жаахан уян хатан болгоё. Ер нь цаашидаа бол боловсролд танхимын болон танхимын бус гэдэг хосмог сургалтууд байна гэдэг энэ концепц, зарчмууд орж ирж байгаа учраас энэ хүрээндээ бид нар ер нь аваад явчихъя. Яг энэ малчдын хүүхдийг боловсролд хамруулах асуудал дээр ер нь тусгайлсайд бодлого явуулах ёстой юм байна гэж энэ хууль батлагдсаны дараа ер нь тусгайлсан бодлого яг ямар тогтолцоогоор яаж авч явах вэ. Зуны сургалтын хэлбэрээр жишээ нь 6 настай хүүхдүүдийг яаж зохион байгуулах вэ, зуны сургуулийг жишээ нь яаж зохион байгуулах вэ энэ тэр гээд та энэ асуудлыг хөндөж гаргаж ирж тавьсан учраас, яг таны гаргасан энэ санал дээр бид нар үндсэндээ энэ тогтолцооны шинэчлэл хийхээр эрх зүйн томъёолуудыг оруулж ирсэн юм байгаа юм шүү гэдгийг би бас хэлчихье. Тэгээд энэ боломжийг ашиглаад манай Туваан гишүүн хөдөөд амьдарч байгаа энэ малчдын хүүхдийг 7 настайд нь сургуульд оруулах асуудлыг хуульчилж оруулж өгөхөд их томоохон хувь нэмэр оруулсан гишүүн гэдгийг бас би энэ албан ёсоор хэлчихье. Тэгээд хамгийн гол нь цаашаа хуульд заалт оруулах нэг өөр, хамгийн гол нь заалтыг амьдралд бид нар яаж хэрэгжүүлэх вэ гэдэг талаар тусгайлсан ийм тогтолцооны шийдлүүд бас гаргаж байгаа шүү гэдгийг бас би танд бүр онцлоод хэлчихье гэж бас бодож байна бас талархаж байна.

2-т нь хөдөө орон нутагт хүүхэд цөөтэй байгаа ахлах сургуулиуд 9, 10, 11, 12 дугаар анги дээр байгаа байгалийн ухааны хичээлүүд дээр багш нар хомс учраас хүүхдүүд байгалийн ухааны хичээлдээ орж чадахгүй 1 дүгээрт, 2

дугаарт 10 дугаар ангиас сонгоны бүлэг бүрдэж чаддаггүй учраас бид нар өнгөрсөн жилээс Монгол Улс даяар энэ *medlee.mn* гэдэг сургуулийг зохион байгуулсан Туваан гишүүн ээ. Тийм учраас энэ *medlee.mn* дээр 10 мянган хүүхэд энэ жил 9 дүгээр ангийн хүүхдүүд төгсөлт хийж байна. Энэ бол Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумд сурч байгаа хүүхэд хүртэл тухайн сумд нь тэр байгалийн ухааны багш өөрийнх нь сонгосон багш байхгүй бол манай Мэдлээ сургууль дээр төгсөөд, төгсөлтөө өнөөдөр хийж байна. Ирэх 7 хоногт бид нар анхныхаа хонхны баярыг хийнэ. Цаашидаа бид нар 10 дугаар анги 11, 12 дугаар ангийг Монгол Улсын хэмжээнд мэдлээ гэсэн энэ цахим сургалтын хэлбэрээр зохион байгуулна.

2 дахь асуудал би бас түрүүн хөндөж танд хэлсэн. Энэ хуулиар цаашидаа сургууль дээр байгаа ЕБС-ийнхаа энэ бүтэц хэв шинжүүдийг эргэж харахаас өөр аргагүй болчихсон. Та түрүүн хэллээ шүү дээ. 1 ангид 5-6 хүүхэдтэй сурч байгаа 12 жилийн тогтолцоотой сургуулиуд маш олон байна. Энийг бид нар сум дундын ахлах сургууль хэлбэрээр зохион байгуулж байж боловсролын чанарт зарчмын өөрчлөлт гарах ёстой гэж харж байгаа.

3 дугаар асуудал бол Монгол хэлний ЭЕШ-тай холбоотой асуудал байгаа. Ер нь яг үнэнийг хэлэхэд яг энэ манай боловсролын бүх судлагдахуун чанар үнэхээр уначхаад байна аа. Үнэхээр уначхаад байна. Тэр тусмаа Монгол хэлний хүүхдүүдийн түвшний асуудал. Энэ Баян-Өлгий аймаг дээр хамгийн том тулгамдсан асуудал байгаа 860 хүүхэд ЭЕШ-д орох.../минут дуусав/

Г.Мөнхцэцэг: Энх-Амгалан сайд гүйцээгээд хариулчихъя. 1 минут.

Л.Энх-Амгалан: 860 хүүхэд ороход дөнгөж 200 хүүхэд л ЭЕШ-ын босго оноо давж байгаа. Ийм байгаа шүү дээ. Ер нь цаашидаа бид нар энэ ЭЕШ-

ынхаа тогтолцоог ер нь жаахан өөрчилье. Ер нь ЭЕШ-ын босго оноо бол хүүхдүүдийг өргөдөг тогтолцоо шүү дээ. Ер нь дунджаас нь өргөчихдөг тогтолцоо байхгүй юу. Тэгээд дунд сургуульд байхдаа дүн нь хуурамч, анги дэвшиж байгаа дүнгийн тогтолцоонууд нь хуурамч, зөвхөн багшийн үзэмжээр анги дэвшүүлээд хүүхдийнхээ хувь заяаг бодож байна гэж дэвшүүлээд байдаг. Гэтэл хүүхдийнхээ хувь заяаг хорлож байгаа. Дахиад энэ ЭЕШ, анги дэвшиж байгаа шалгалтуудынхаа тогтолцоог бид нар энэ хуулиар ер нь өөрчилье. Энэ жилийн хувьд өнгөрсөн жилээс бид нар ЭЕШ-ыг жилд 2 удаа авдаг болчихсон шүү дээ Туваан гишүүн ээ. Тэгээд энэ хууль дээрээ бид нар бас ЭЕШ-ыг жилд 2 удаа 2-оос доошгүй удаа авч зохион байгуулдаг ийм зохицуулалтуудыг бас хийж өгч байгаа.

Г.Мөнхцэцэг: Асуултад хариуллаа. 19 дүгээр зүйлээр санал хураалтын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт. Энэ гуравны хоёроор санал хураалт. Энэ санал 77,8 хувиар дэмжигдлээ. Энэ саналаа дэмжье гээд сая 3-ны 2-оор санал хураалт болсон. Дахиад санал хураалт. 3 дахь санал нь. Энэ санал 77,8 хувиар дэмжигдлээ.

4 дүгээр санал хураалтыг явуулъя.

Төслийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.3.Ерөнхий боловсролын сургуульд судлах үндсэн гадаад хэл нь энэ хуулийн 10.1-д заасан сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалд туссан хэл байна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалтыг цуцалъя. Ундрам гишүүн энэ саналтай холбогдуулж үг хэлнэ.

Ч.Ундрам: Энэ заалт дээр би зүгээр л хамгийн эцсийн үгээ хэлье гэдэг шиг л та бүхнийг бас хамгийн сүүлийн удаа бодож үзээсэй л гэж хүсэж байгаа

юм. Хөтөлбөр өнөөдөр Энх-Амгалан сайд бол англи хэлийг заана. Энэ хөтөлбөрийн үзэл баримтлалыг батлуулчихна. Хуулийнхаа дагуу 10 жил үзэл баримтлал нь өөрчлөгдөхгүй, Засгийн газар энийг нь баталж байгаа гээд энэ тайлбаруудыг би ойлгоод байгаа. Гэхдээ хэрвээ дараагийн өөр үзэл баримтлалтай, өөр санаатай хүн орж ирээд батлуулчихвал яах юм. Тэр хүн хариуцлага хүлээхгүй шүү дээ. Энэ хамтын шийдвэр байсан энэ тэр гээд л янз бүрийн тайлбар хэлээд л, ямар нэгэн хариуцлага тооцох хуулийн санкц байхгүй шүү дээ. Тэгэхээр уг нь бид нар энийгээ ингээд яг хамгаалаад явсан бол уг нь зүгээр байсан юм гэж би хэлэх гээд байгаа юм. Гэхдээ цаашид үеийн үед олон нийт, сэтгүүлчид болон бид нар энэ Англи хэлний асуудлыг, энэ хөтөлбөрийг нь өөрчлөхгүй байх, үзэл баримтлалыг нь өөрчлөхгүй байх, тогтвортой байлгах тал дээр бид нар манах ёстой шүү гэж та бүхнээсээ би хүсэж байгаа юм. Бид нар. Дараа нь хэн нэгэн өөр юм боддог өөр хүн орж ирээд энийг өөрчлөх гэж байвал энэ заалтыг бид нар юу ярьж байснаа сануулж, манах ёстой шүү гэдгийг би хамгийн сүүлд хэлмээр байна.

Г.Мөнхцэцэг: Ундрам гишүүн санал хэллээ. 9 дүгээр зүйл дээр уншиж танилцуулсан. Санал хураалт явуулъя. Санал хураалт. Энэ саналд 55,6 хувиар дэмжигдлээ.

Энэ чинь гуравны хоёроор хураагдах ёстой санал. Аубакир гишүүн горимын санал гаргая.

Т.Аубакир: Би сая дэмжиж саналаа өгсөн юм. Миний санал дэмжээгүйгээр орчихсон байна. Тийм учраас дахин санал хураалгаж өгнө үү гэж.

Г.Мөнхцэцэг: Аубакир гишүүний гаргаж байгаа дахин санал хураалт явуулах саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт. Дахин санал хураалт явуулъя гэсэн саналын томъёолол 66,7 хувиар дэмжигдлээ.

Дахин санал хураалт гуравны хоёроор санал хурааж байгаа. Энэ гишүүний гаргасан санал 66,7 хувиар дэмжигдсэн. Энэ 9 дүгээр зүйл дээр дахин санал хураалт явуулна. Санал хураалт энэ санал 66,7 хувиар дэмжигдлээ.

5.Төслийн 30 дугаар зүйлийг төслөөс хасах. Санал хураалт. Энэ санал 77,8 хувиар дэмжигдлээ. Гуравны хоёроор дэмжсэн. Одоо гуравны хоёроор дэмжигдсэн учраас ахиад санал хураалт явуулах ёстой. Санал хураалтад оръё. Санал хураалт. Энэ санал 77,8 хувиар дэмжигдлээ.

Ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол буюу Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулах хүн байна уу. Чуулганы нэгдсэн хуралдаанд Ундрам гишүүн танилцуулна. Ундрам гишүүн танилцуулъя.

15.40 цаг.

Горимын саналаар хэлэлцэх асуудлын дараалал өөрчлөгдсөн. Хэлэлцэх асуудлын 2 дугаар асуудалд оръё.

Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийн хуулийн төслүүдийг зүйл бүрээр нь хэлэлцэнэ. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу. Туваан гишүүн асуултаа асууя.

Ц.Туваан: Энэ дээр нэг товчхон ийм асуулт байгаа юм. Одоо энэ хөдөө орон нутагт мэргэжлийн боловсон хүчний дутагдал ихтэй байна. Тэр нь ялангуяа малын эмч, агроном, малын зоотехникч гэсэн ийм мэргэжилтэй хүмүүс маш дутагдалтай байна. Тэгэхээр энэ дээр өмнөх нийгэмд социалист нийгэмд гэдэг юм уу шийдэж байсан аргыг нь ингээд судлаад үзэхээр энэ ачааллыг дунд мэргэжлийн хүмүүс маш их үүрч байсан. Бараг 10 мэргэжилтний 8 нь ч юм уу дунд мэргэжилтний хүмүүс үүрч байсан юм байна лээ. Тэгэхээр бид нар энэ дандаа дээд мэргэжлийн буюу энэ их сургууль төгссөн бакалаврын зэрэгтэй малын эмч, зоо техникч, агроном гэж байхаар дунд мэргэжлийн хүмүүсээ өөрөөр хэлбэл сургах, тэднийг бас ажлын байраар хангах асуудал үүсээд байна л даа. Тэгэхээр энэ мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай энэ хууль дээрээ яг миний энэ ярьж байгаа дунд мэргэжилтэн гэж ярьдаг дундын зоо, агротехникч, малын бага эмч гэдэг шиг ийм хүмүүсийг сургах бодлого энэ МСҮТ энэ тэр дээр сургах ийм бодлого явж байгаа юу. Ер нь бас энийг далимдуулаад энэ чиглэлээр төгсөх суралцах хүмүүсээ энэ боловсролын зээлийн сангаар ч юм уу эс үгүй бол ямар нэгэн сувилагч нарт үзүүлж байгаа дэмжлэг шиг ийм төрлийн дэмжлэг ер нь байгаа юу гэсэн асуултыг асууя.

Г.Мөнхцэцэг: Туваан гишүүний асуултад Энх-Амгалан сайд хариулах уу. Энх-Амгалан сайдын микрофоныг өгье.

Л.Энх-Амгалан: Туваан гишүүн ээ, ер нь яг бид нарын өнөөдрийн энэ Боловсролын багц хуулиар өөрчлөгдөх гэж байгаа гол асуудал бол ерөөсөө энэ боловсролын тогтолцооны түвшин бүр маань улс орныхоо хөгжлийн эрэлт хэрэгцээг хангаж чаддаг ийм түвшнийг л бий болгох ёстой гэж харж бид нар энэ Мэргэжлийн болон техникийн боловсрол тэгээд Дээд боловсролынхоо хуулийн хоорондын уялдааг хангаж л оруулж

ирж энэ эрх зүйн шинэчлэлтүүдийг хийх гэж байгаа юм.

Яг таны хөндсөн яг гол асуудал бол хөдөө аж ахуйн салбарт ажиллаж байгаа энэ ажилтнуудын зах зээл, эрэлт нийлүүлэлтэд нийцсэн ямархуу мэргэжлийн боловсролын болон техникийн боловсролын цаашилаад дээд боловсролын тогтолцоог яаж бий болгож, яаж тогтвортой авч явах вэ гэдэг дээр л бид нар энэ өөрчлөлтүүдийг хийж байгаа юм л даа.

Тэгэхээр бид нар яг энэ хууль батлагдаж гарснаар ерөнхийдөө энэ мэргэжлийн боловсролын болон дээд боловсролын гол зорилго бол яг энэ хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлт. Тэр тусмаа сүүлийн жилүүдэд дэлхий нийтээр ч ярьдаг болсон. Манайх ч бас нэлээн асуудалд бэрхшээлтэй, сорилттой тулгагдаж байгаа асуудал бол энэ ур чадварын эрэлт нийлүүлэлтийн асуудлууд байгаа юм. Тэгэхээр энэ ур чадварынхаа эрэлт нийлүүлэлтүүдийг бид нар ер нь энэ тогтолцоогоороо авч явъя. Тэгээд ер нь бол техникийн боловсрол, Мэргэжлийн боловсрол нь хөгжлийн бодлогод 1 дүгээрт нийцсэн байх ёстой. 2 дугаарт нь бол хөдөлмөр эрхлэлт ур чадварын хөгжлийг дэмжсэн ийм тогтолцоог л бид нар бий болгоё гэж харж байгаа юм.

Тэгээд яг энэ хөдөө аж ахуйн чиглэлийн мэргэжилтнүүдийг бэлтгэхэд бид нар энэ МСҮТ гэж байсныг бид нар Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн сургууль гэж статусыг нь нэлээн дээшлүүлж байгаа юм. Сургууль тэгээд цаашаа коллеж. Тийм учраас хүүхэд бүхэн 12 дугаар анги төгсөж байгаа Бараг үндсэндээ 90% нь их, дээд сургууль руу ордог. Манайх чинь ийм буруу тогтолцоотой шүү дээ тийм ээ. Тэгэхээр өнөөдөр энэ Мэргэжлийн болон техникийн боловсролын хууль гарснаар яг 10 дугаар анги 9 дүгээр ангиа төгсөөд 12 дугаар анги руугаа орж байгаа мэргэжлийн болон техникийн боловсрол

руугаа орж байгаа 9 10 дугаар анги руугаа орж байгаа ЕБС руугаа орж байгаа ахлах сургуулийн тогтолцоо, тэгээд тэр нь дээшийгээ шатлаад яаж дэвшээд явах вэ энэ хоорондоо кредитүүдээ яаж солилцоод явах вэ гэдэг асуудлуудыг нэлээн тийм уян хатан зохион байгуулж өгч байгаагаараа нэлээн онцлогтой хууль.

2 дугаар асуудал бол яг таны хөндсөн цаашидаа Монгол Улс тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийнхээ жагсаалтуудыг баталдаг болъё. Энийгээ 2-3 жилийн турш шинэчилдэг болъё. Яг тэгээд эрэлттэй болон тэргүүлэх мэргэжлээр суралцаж байгаа яг МСҮТ-ийн суралцаж байгаа оюутнуудад төрийн ямар дэмжлэг байх юм, дээд боловсролд орж байгаа хүүхдүүд дээр яг төрийн ямар дэмжлэг байх юм бэ гэдгийг бид нар энэ хууль дээрээ зохицуулалт хийгээд, цаашидаа Боловсролын зээлийн сангаас энэ мэргэжлүүд дээр тэтгэлэг олгож сургадаг ийм зохицуулалтуудыг л нээж өгч байгаа юм.

Г.Мөнхцэцэг: Гишүүн асуулт асууж, хариулт авлаа. Санал гаргаагүй учраас санал хураахгүй. Дараа нь Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу. Алга байна.

Мэргэжлийн болон сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 3 дугаар зүйл дээр санал хураалт байгаа. Санал хураалтад оръё.

1.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтын “ахисан түвшний чадамжийг” гэснийг “чадамжийг” гэж, 3.1.9 дэх заалтын “богино хугацааны сургалтыг” гэснийг “сургалтыг” гэж, 3.1.11 дэх заалтын “өмнө эзэмисэн мэдлэг” гэснийг “эзэмисэн мэдлэг, ур чадвар” гэж, “мэдлэг, ур чадварыг” гэснийг “чадамжийг” гэж өөрчилж,

3.1.12 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.12.“дадлагажуулагч” гэж суралцагчийг үйлдвэрлэлийн орчинд дагалдуулан сургах, ур чадвар эзэмшүүлэх үүрэг бүхий, арга зүйн сургалтад хамрагдсан ажилтныг” гэж. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт энэ санал 77,8 хувиар дэмжигдлээ.

2.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын зорилго нь нийгмийн хөгжил, эдийн засгийн бүтээмжийг дэмжих, хөдөлмөрийн зах зээл, ур чадварын эрэлт, шаардлагад нийцсэн мэргэжлийн ур чадвар бүхий иргэн бэлтгэж, мэргэшлийн түвшин ахиулах, тасралтгүй хөгжих хэрэгцээг хангахад оршино.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ санал 66,7 хувиар дэмжигдлээ.

3.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.3 дахь заалт, 5.1.4 дэх заалтын “нийгмийн” гэснийг тус тус төслөөс хасаж, доор дурдсан агуулгатай 5.1.5, 5.1.6 дахь заалт нэмэх:

“5.1.5.хөгжлийн бодлогод нийцсэн байх;

5.1.6.хөдөлмөр эрхлэлт, ур чадварын хөгжлийг дэмжсэн байх.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ санал 77,8 хувиар дэмжигдлээ.

4.Төслийн 6 дугаар зүйлийн 6.7 дахь хэсгийн “6.3,” гэснийг төслөөс хасаж, 6.2 дахь хэсгийн “бие даан ажил” гэснийг “хувиараа” гэж /цаашид тохиолдол бүрд/, 6.5 дахь хэсгийн “хэмжих ба багц цагийг дараагийн түвшний боловсролд тооцож дүйцүүлнэ” гэснийг “тооцох бөгөөд дараагийн боловсролын түвшинд дүйцүүлнэ” гэж, 6.6 дахь хэсгийн “багц цаг” гэснийг “Мэргэжлийн болон техникийн боловсролын багц цаг” гэж, 6.8 дахь хэсгийн “ажил

олгогчийн” гэснийг “түншлэлийн” гэж өөрчилж, 6.14 дэх хэсгийн “тусгай” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ санал 77,8 хувиар дэмжигдлээ.

5.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн "тавигдах" гэснийг "тавих нийтлэг" гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ санал 77,8 хувиар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн гарчгийн “Үнэлгээ, баталгаажуулалт” гэснийг “Чанарын баталгаажуулалт” гэж, 8.2 дахь хэсгийн “Хүний өмнөх мэдлэг, ур чадвар, чадамжийг” гэснийг “Эзэмисэн мэдлэг, ур чадварыг” гэж өөрчилж, 8.1 дэх хэсгийн "суралцагч" гэсний өмнө "мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын" гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 8.3, 8.4, 8.5, 8.6, 8.7 дахь хэсгийг нэмэх:

“8.3.Мэргэжлийн сургалтын байгууллагын төгсөгчийн чадамжийг үнэлэх, баталгаажуулах, гэрчилгээжүүлэх журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

8.4.Магадлан итгэмжлэлийг Боловсролын ерөнхий хуулийн 17.9-д заасан байгууллага мөн хуулийн 30.1.12-т заасан журмын дагуу хэрэгжүүлнэ.

8.5.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг таван жил тутам магадлан итгэмжилнэ.

8.6.Боловсролын ерөнхий хуулийн 29.1.8-д заасан мэргэжлийн болон техникийн боловсролын эрэлттэй, тэргүүлэх мэргэжлийн хөтөлбөрийг заавал магадлан итгэмжилнэ.

8.7.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага Боловсролын ерөнхий хуулийн 40.7-д

заасны дагуу дотоод чанарын баталгаажуулалтыг хэрэгжүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг.

Хүний өмнөх гэж энэ томъёолол нь юу вэ. Засвар орж байгаа юм байна. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 77,8 хуваарийн санал дэмжигдлээ.

7.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “түвшинтэй” гэснийг “ангилалтай” гэж, 9.14 дэх хэсгийн “дадлагын баазад” гэснийг “чадамжийн төв, дадлагын баазад” гэж, 9.15 дахь хэсгийн “төв, бааз, аж ахуй” гэснийг “чадамжийн төв, дадлагын бааз, туслах аж ахуй” гэж өөрчилж, 9.12, 9.13 дахь хэсгийг нэгтгэн доор дурдсан агуулгатай 9.12 дахь хэсэг болгон өөрчлөн найруулж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 9.17 дахь хэсэг нэмэх:

“9.12.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага харьяалалдаа чадамжийн төв, салбар дундын дадлагын бааз, гарааны компани, бизнес инкубатор төв, туслах аж ахуйтай байж болно.

9.17.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага дотуур байртай байж болно. Дотуур байрын орчин, үйлчилгээний стандарт, техникийн зохицуулалтыг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд заасны дагуу баталж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ санал 77,8 хувиар дэмжигдлээ.

Гэхдээ түрүүн бас бид нар ажлын хэсэг дээр ярьсан Дээд боловсролын хуультайгаа бас нийцүүлж найруулгыг нь засах ийм найруулан засвар хийх шаардлага үүсэж байна гэдгийг манай дэд ажлын хэсэг анхаараарай.

8.Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтын “чанартай” гэснийг

“Боловсролын ерөнхий хуулийн 30.1.31-д заасан журмын дагуу” гэж, 10.1.3 дахь заалтын “байгууллагаар дамжуулан” гэснийг “энэ хуулийн 9.12-т заасан байгууллагаар дамжуулан” гэж, 10.1.8 дахь заалтын “гэрээ хэлэлцээр байгуулах” гэснийг “хамтран ажиллах” гэж, 10.1.9 дэх заалтын “туслах /дэмжлэг үзүүлэх/” гэснийг “дэмжлэг үзүүлэх” гэж өөрчилж, 10.1.3 дахь заалтын “судалгаа хийх” гэсний дараа “зөвлөн туслах” гэж, 10.1.10 дахь заалтын “хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн” гэсний дараа “байгаль орчинд ээлтэй, жендэрийн мэдрэмжтэй, хүртээмжтэй” гэж /цаашид тохиолдол бүрд/ нэмж, 10.1.4 дэх заалтыг төслөөс хасаж, 10.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төсөлд 10.1.12 дахь заалт нэмэх:

“10.1.5.эзэмисэн мэдлэг, ур чадварын үнэлгээг түншлэгч талтай хамтран зохион байгуулах;

10.1.12.түншлэлийг хэрэгжүүлэх.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ санал 77,8 хувиар дэмжигдлээ.

9.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн “63.1, 63.2, 63.3 дахь заалтад” гэснийг “63 дугаар зүйлд заасныг” гэж өөрчилж, төслөөс 11.6 дахь хэсгийн “хяналт тавьж,” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ санал 66,7 хувиар дэмжигдлээ.

10.Төслийн 12 дугаар зүйлийн 12.3, 12.5, 12.6 дахь хэсгийг төслөөс хасаж, доор дурдсан агуулгатай 12.9 дэх хэсэг нэмэх:

“12.9.Дээд боловсролын тухай хуулийн 5.8-д заасан шаталсан сургалттай хөгжмийн дээд боловсролын сургалтын байгууллагын элсэгчид энэ хуулийн 12.1, 12.2 дахь хэсэг хамаарахгүй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ санал 77,8 хувиар дэмжигдлээ .

11.Төслийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “хөтөлбөрийг эзэмисэн иргэнд” гэснийг “байгууллагыг төгсөгчид” гэж, 13.2 дахь хэсгийн “Иргэний албан бус боловсрол, амьдралын орчинд суралцаж эзэмисэн чадамжийг” гэснийг “эзэмисэн мэдлэг, ур чадварыг” гэж, мөн хэсгийн “13.1.1, 13.1.2” гэснийг “13.1” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ санал 77,8 хувиар дэмжигдлээ.

12.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “5” гэснийг “3” гэж, 14.3 дахь хэсгийн “дээд түвшний чадамжтай” гэснийг “өндөр ур чадвартай” гэж, 14.2, 14.3 дахь хэсгийн “багшлах эрхтэй” гэснийг “багшлах эрхийн гэрчилгээтэй” гэж өөрчилж, төсөлд доор дурдсан агуулгатай 14.4 дэх хэсэг нэмэх:

“14.4.Багшийн мэдлэг, ур чадварын үнэлгээг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, мэргэжлийн холбоо, ажил олгогч, сургалтын байгууллагатай хамтран дөрвөн жил тутам зохион байгуулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт энэ санал 77,8 хувиар дэмжигдлээ.

13.Төслийн 16 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 16.1.3 дахь заалт нэмэх:

“16.1.3.мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан, дотуур байрын багш, арга зүйч, номын санч, эмч, хоол зүйч, тогооч, сэтгэл зүйч, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэнд эхний тав дахь жил болон дараагийн гурав дахь жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг ажиллаж байгаа боловсролын сургалтын байгууллагаас олгох.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ санал 77,8 хувиар дэмжигдлээ.

14.Төслийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалтын "хангагдсан" гэсний дараа "байгаль орчинд ээлтэй, жендэрийн мэдрэмжтэй, хүртээмжтэй" гэж, 17.2.1 дэх заалтын "сургалтын байгууллагын" гэсний өмнө "үйлдвэрлэлийн болон" гэж нэмж, 17.1.6 дахь заалтын "11.4" гэснийг "11.3" гэж, 17.2.5 дахь заалтын "явцад" гэснийг "үед" гэж өөрчилж, 17.2.1 дэх заалтын "байгууллагын" гэснийг, 17.2.3 дахь заалтыг төслөөс тус тус хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 17.3, 17.4 дэх хэсэг нэмэх:

"17.3.Суралцагч элссэн хөтөлбөрөөр суралцах хугацаандаа тухайн чиглэлийн мэргэжлийн бусад хөтөлбөрт суралцаж, хос мэргэжил эзэмшиж болно.

17.4.Суралцагч энэ хуулийн 17.3-т заасан ижил чиглэлийн мэргэжлийн хөтөлбөрт хамрагдах тохиолдолд сургалтын төлбөр төлөх бөгөөд тэтгэлгийг давхардуулан олгохгүй." Санал гаргасан ажлын хэсэг Санал хураалт. Энэ санал 77,8 хувиар дэмжигдлээ.

15.Төслийн 19 дүгээр зүйлийн 19.2.1 дэх заалтын "боловсруулахад оролцох" гэсний дараа "санал болгох" гэж, 19.3.6 дахь заалтын "дадлага сургалтыг" гэсний дараа "байгаль орчинд ээлтэй, жендэрийн мэдрэмжтэй, хүртээмжтэй" гэж нэмж, 19.3.7 дахь заалтын "дадлагажуулагч багшаар" гэснийг "дадлагажуулагчаар" гэж өөрчилж, 19.3.13 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 19.4, 19.5, 19.6 дахь хэсэг нэмэх:

"19.3.13.дагалдан суралцагчид Хөдөлмөрийн тухай хуулийн 63 дугаар зүйлд заасны дагуу цалин хөлс олгох.

19.4.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 15.1.4, 15.1.5, 15.1.6, 15.1.9-д заасан зардал, дэмжлэг, хандивыг албан татвар ногдох орлогоос хасагдах зардалд тооцуулж болно.

19.5.Аж ахуйн нэгж, байгууллага нь эдийн засгийн үйл ажиллагааны салбар, үйлдвэрлэл, үйлчилгээний онцлогоос хамааран мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг дэмжих санд энэ хуулийн 22.1-д заасан Зөвлөлийн тогтоосон хувь хэмжээгээр санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.

19.6.Хосмог сургалт зохион байгуулсан тохиолдолд ажил олгогчоос болон ажилтнаас төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг Хөдөлмөрийн тухай хуулийн 63.3-т заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас төлнө." Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ санал 77,8 хувиар дэмжигдлээ.

16.Төслийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, 20.2.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 20.2.4 дэх заалт нэмэх:

"20.1.Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын мэдээллийн санг Боловсролын ерөнхий хуулийн 48.9-д заасан журмын дагуу бүрдүүлж, ажиллуулна.

20.2.1.хөдөлмөрийн зах зээл дэх ур чадварын эрэлт, нийлүүлэлт, төгсөгчийн хөдөлмөр эрхлэлт, мөшигөх судалгаа, ажил олгогчийн сэтгэл ханамжийн судалгааны мэдээлэл;

20.2.4.мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын, чадамжийн болон үнэлгээний мэдээлэл." Санал гаргасан ажлын хэсэг. Мөшигөх судалгаа гэж юу юм бэ. Энэ томъёолол нь зөв үү. Мөшигөх судалгаа ингэж байгаа юм уу. Мөшигөх гэдэг чинь яг юу гэсэн үг юм бэ. Энийг тайлбарлаад өгөөч. Энэ ажлын хэсэг дээр би байгаагүй учраас мэдэхгүй байна. Энх-Амгалан сайд.

Л.Энх-Амгалан: Энэ бол нөгөө төгсөгчдөө ажлын байртай болгож чадаж байна уу, чадахгүй байна уу гэдгийг л бид нар мөшигөө гэж байгаа юм.

Тэгээд энэ цаашидаа их, дээд сургуулиудын үзүүлэлтүүд, мэргэжлийн боловсролын үзүүлэлтүүдийн нэг гол нь төгсөгчид нь шууд төгсөөд хэдэн хувь нь ажлын байртай болж байна, хэдэн хувь нь ажлын байртай болж чадахгүй байна, яагаад ажлын байртай болж чадахгүй байна гэдэг энэ судалгааг байнга хийж байж цаашидаа хөтөлбөртэй, индекстэй өөрчлөлт хийх ийм манай салбарт ингээд тогтчихсон нэр томъёо. Хөдөлмөрийн яам дээр ч гэсэн ингэж явдаг. Боловсролын яам дээр ч гэсэн ингэж явдаг. Ийм л юм байгаа юм.

Г.Мөнхцэцэг: Хуульдаа ингэж нэр томъёолоод ингээд ирчихсэн бас тэгэхдээ үгийн хувьд сонголтын хувьд ямар юм бэ дээ. Англиар нь юу гэж байгаа юм. Мөшигөх гэдэг нь бас яг буухаараа мөрдөн мөшигөх гээд л яг л ингэж хуульдаа байдаг юм уу. Томъёолол нь үгийн хувьд сонголтын хувьд миний хувьд буухгүй л байгаад байна. Зүгээр яг ингээд энэ нэр томъёололдоо ингээд багтаад явчихсан л бол өөрчлөх боломжгүй юм байна. Олон хуульд ийм заалт байгаа юу. Санал гаргасан ажлын хэсэг Санал хураалт. Энэ санал 77,8 хувиар дэмжигдлээ.

17.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1.Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын удирдлага нь Боловсролын ерөнхий хуулийн 27.1-т заасан удирдлагын тогтолцооноос бүрдэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг Санал хураалт. Аубакир гишүүн санал хураалтад гүйцэд оролцоно гэж энэ дээр бичсэн байна л даа. Энэ санал 77,8 хувиар дэмжигдлээ.

18.Төслийн 22 дугаар зүйлийн "Үндэсний зөвлөл" гэснийг "Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын зөвлөл" гэж, 22.1 дэх хэсгийн "Үндэсний зөвлөл" гэснийг "мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын зөвлөл /цаашид "зөвлөл" гэх/" гэж, 22.2 дахь

хэсгийн "төрийн захиргааны байгууллага" гэснийг "төрийн захиргааны төв байгууллага" гэж, мөн хэсгийн "бүрдэнэ" гэснийг "бүрдсэн нийт 15 гишүүнтэй байна" гэж, 22.3, 22.5 дахь хэсгийн "Засгийн газар" гэснийг "Боловсролын ерөнхий хуулийн 27.4-т заасан Үндэсний зөвлөл" гэж, 22.6 дахь хэсгийн "Засгийн газарт" гэснийг "Боловсролын ерөнхий хуулийн 27.4-т заасан Үндэсний зөвлөлд" гэж өөрчилж, төслийн 22.9.5 дахь заалтын "засгийн" гэсний дараа "эрэлттэй болон" гэж нэмж, 22.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.4.Зөвлөлийн даргыг гишүүдийн олонхын саналаар томилогдсон этгээд хэрэгжүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ санал 77,8 хувиар дэмжигдлээ.

19.Төслийн 23 дугаар зүйлийн 23.1.8 дахь заалтын “их сургууль, дээд сургуулийн” гэснийг “дээд боловсролын сургалтын байгууллагын” гэж өөрчилж, 23.1.4, 24.1.7 дахь заалтын “тусгай” гэснийг, 23.1.8 дахь заалтын “энгийн” гэснийг, мөн зүйлийн 23.1.9 дэх заалтыг хасаж, доор дурдсан агуулгатай 23.1.10 дахь заалт нэмэх:

“23.1.10.төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын захирлыг сонгон шалгаруулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ санал нь 77,8 хувиар дэмжигдлээ.

20.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “хүрээнд” гэсний дараа “Боловсролын ерөнхий хуульд зааснаас гадна” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 24.1.7, 24.1.8 дахь заалт, 24.2 дахь хэсэг нэмэх.

“24.1.7.багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааг

түншлэгч талуудтай хамтран зохион байгуулах;

24.1.8.багш, ажилтны мэргэжлийн зэрэг олгох, ахиулах, сунгах.

24.2.Энэ хуулийн 24.1.7-д заасан чиг үүргийг Засгийн газрын тухай хуулийн 19.1-д заасан байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ санал 66,7 хувиар дэмжигдлээ. Адьясүрэн гишүүнээс юу ороогүй байх шиг байна.

21.Төслийн 25 дугаар зүйлийн “25.2.1-25.2.10” дахь заалтын дугаарлалтыг “25.1.1-25.1.10” гэж өөрчилж, мөн зүйлийн, 25.2.9 дэх заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ санал 77,8 хувиар дэмжигдлээ.

22.Төслийн 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчилж, төсөлд 26.5.3, 26.5.4, 26.5.5, 26.5.6 дахь заалт, 26.7 дахь хэсэг нэмэх:

“26.4.Удирдах зөвлөл нь нийт арван нэгэн гишүүнтэй байх бөгөөд төрийн захиргааны төв байгууллагаас гурав, нутгийн захиргааны байгууллагаас гурав, тухайн сургалтын байгууллагын хамт олныг төлөөлөх нэг, аж ахуйн нэгж, байгууллагыг төлөөлөх гурав, суралцагчийн нэг төлөөллөөс бүрдэнэ. Удирдах зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байна.

26.5.3.мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын тухайн жилийн төсвийн төслийг хэлэлцэх, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн хуваарилалтыг батлах, үр дүн, чанар, гүйцэтгэлд хяналт тавих;

26.5.4.төсвийн хязгаарт нийцүүлэн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаар, цалингийн санг тогтоох;

26.5.5.төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын захирлыг энэ хуулийн 23.1.10-т заасан журмын дагуу сонгон шалгаруулж, томилох, хууль тогтоомжид заасан үндэслэлээр чөлөөлөх;

26.5.6.боловсролын сургалтын байгууллагын захиралтай байгуулсан гэрээг дүгнэх.

26.7.Төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилно.” Санал гаргасан ажлын хэсэг Санал хураалт. Энэ санал 77,8 хувиар дэмжигдлээ.

23.Төслийн 27 дугаар зүйлийн 27.2.1 дэх заалтын “бакалавр” гэснийг “магистр” гэж, 27.2.2 дахь заалтын “мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага” гэснийг “боловсролын сургалтын байгууллага” гэж, “10-аас” гэснийг “5-аас” гэж, “сургалтын менежер, арга зүйч, тэнхимийн эрхлэгчээр 4-өөс” гэснийг “удирдах албан тушаалд гурваас” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 27.5.12, 27.5.13, 27.5.14 дэх заалт нэмэх:

“27.5.12.гүйцэтгэлд суурилсан санхүүжилт, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос багш, ажилтныг урамшуулах, нийгмийн баталгааг хангах боломж, нөхцөлийг бүрдүүлэх;

27.5.13.Боловсролын ерөнхий хуулийн 12.9-д заасны дагуу багшийн мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааг зохион байгуулах;

27.5.14.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26.2-т заасны дагуу батлагдсан төсвийн 0.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн

болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулах.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ санал 66,7 хувиар дэмжигдлээ.

24.Төслийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсгийг төслөөс хасах. Санал гаргасан ажлын хэсэг.Санал хураалт. Энэ санал 66,7 хувиар дэмжигдлээ.

25.Төслийн 29 дүгээр зүйлийн 29.3.1 дэх заалтын “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан” гэснийг “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хуваарилсан хөрөнгө” гэж, 29.4.1 дэх заалтын “төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн, техникийн боловсролын сургалтын байгууллагын” гэснийг “өмчийн хэлбэр үл харгалзан мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 29.3.3, 29.3.4 дэх заалт нэмэх:

“29.3.3.төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын өөрийн болон туслах үйл ажиллагааны орлогын тодорхой хувь;

29.3.4.энэ хуулийн 19.4-т заасны дагуу төвлөрүүлсэн хөрөнгө.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ санал 77,8 хувиар дэмжигдлээ.

26.Төслийн 33 дугаар зүйлийг төслөөс хасах. Шууд байгаа юм уу.

27.Хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг төсөл санаачлагчид буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ санал 77,8 хувиар дэмжигдлээ.

Түр завсарлага. Материал хэвлэгдээд иртэл гишүүд түр завсарлаж

байя. 3 дугаар асуудал 30 гаруй санал хураалттай байгаа.

Хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг танилцуулаад санал хураалт явуулж явуулж байя.

1.Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай:

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу. Алга байна.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу. Алга байна.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу. Алга байна.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

2.Багшийн хөгжлийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай:

Багшийн хөгжлийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр санал, асуулттай гишүүн байна уу. Алга байна.

Багшийн хөгжлийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу. Алга байна.

Багийн хөгжлийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу. Алга байна.

Багийн хөгжлийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

3.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай:

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр санал, асуулттай гишүүн байна уу. Алга байна.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу. Алга байна.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

4.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай:

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу. Алга байна.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу. Алга байна.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 3 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу. Алга байна.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

5.Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль хүчингүй болгосонд тооцох тухай:

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу. Алга байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу. Алга байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

6.Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай:

Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу. Алга байна.

Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу. Алга байна.

Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

7.Хөдөлмөрийн эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай:

Хөдөлмөрийн эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу. Алга байна.

Хөдөлмөрийн эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу. Алга байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу. Алга байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу. Алга байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

8.Хөгжлийн бэрхиээлтэй хүний эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай:

Хөгжлийн бэрхиээлтэй хүний эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу. Алга байна.

Хөгжлийн бэрхиээлтэй хүний эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу. Алга байна.

Хөгжлийн бэрхиээлтэй хүний эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу. Алга байна.

Хөгжлийн бэрхиээлтэй хүний эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу. Алга байна.

Хөгжлийн бэрхиээлтэй хүний эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Боловсролын эрх хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Дээд боловсролын тухай, судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр санал хураалт байгаа. Хэлэлцэх асуудлын 2 дугаарт байсныг 3 дугаарт болгож өөрчилсөн.

3 дугаар асуудалдаа оръё. 2 дугаар асуудлаар санал хураалт явуулж дууссан. Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Жаргалмаа танилцуулчих уу. Жаргалмаа гишүүн танилцуулна.

3 дугаар асуудалдаа оръё.

16.23 цаг.

Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Дээд боловсролын тухай судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж эхэлье.

Ажлын хэсгийн гишүүд түрүүчийн ирц хэвээрээ байгаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэнэ гэсэн дэгтэй. 39.11-д болохоор гишүүн хуулийн төслийн тухайн зүйлтэй холбогдуулан хууль санаачлагчаас асуулт болон бусад оролцогчоос асуулт асууж болно гэсэн ийм хуулийн дэг байгаа. Энэ дэгийг танилцууллаа. Хуулийн төслүүдийг зүйл бүрээр нь хэлэлцэнэ. Дээд боловсролын тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Зүйл бүрээр нь гишүүд асуулт асууж болно гэсэн дэгтэй байгаа юм.

Санал хураалтын саналын томъёоллыг танилцуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.1.Энэ хуулийн зорилт нь дээд боловсролын удирдлага, зохион байгуулалт, сургалт, судалгаа, санхүүжилттэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Ердийн олонхоор санал хураалт явуулна. Энэ санал 77,8 хувиар дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.1. Дээд боловсролын зорилго нь нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах, дэвшилтэт шинэ санаа, судалгаа, инновацыг хөгжүүлэх, бүтээлчээр ашиглах, олон соёлын орчинд ажиллаж, амьдрах чадвартай, ёс суртахуунтай иргэн бэлтгэхэд оршино.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ дээр нөгөө найруулгын засвар ороод байсныг яаж өөрчилж байгаа юм бэ. Иргэн гэдгээрээ оруулаад явчихсан уу. Энэ санал 77,8 хувиар дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “Судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай хууль,” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Энэ материал дээр дэд ажлын хэсэг гэсэн саналын томъёолол оруулж ирээд хураалгаад байх юм. 77,8 хувиар дэмжигдлээ.

4.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “дээд боловсролын” гэсний дараа “сургалтын байгууллагын” гэж, 4.1.3 дахь заалтын “төлбөр,” гэсний дараа “судалгааны болон” гэж нэмж, 4.1.1 дэх заалтын “дипломын” гэснийг “дэд бакалаврын” гэж, 4.1.2 дахь

заалтын “магистр, докторын хөтөлбөрийн сургалтыг” гэснийг “магистрын болон докторын хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг” гэж, 4.1.4 дэх заалтын “олгогдох” гэснийг “суралцагчид олгох” гэж өөрчилж, 4.1.5, 4.1.6 дахь заалтыг төслөөс хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 4.1.7 - 4.1.10 дахь заалт нэмэх:

4.1.7.“сургалтын төлбөрийн хөнгөлөлт” гэж дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчийн сурлагын амжилт, төлбөрийн чадамжийг тооцож төлбөрөөс тодорхой хувиар чөлөөлөхийг;

4.1.8.“шаталсан сургалт” гэж боловсролын бусад түвшний хөтөлбөрийг зэрэгцсэн болон дараалсан байдлаар хэрэгжүүлэх үйл ажиллагааг;

4.1.9.“грант” гэж Инновацын тухай хуулийн 3.1.7-д зааснаас гадна байгууллага, судлаачийн судалгааны ажилд зориулж иргэн, хуулийн этгээд, олон улсын байгууллагаас урьдчилан нөхцөл, болзолтой буцалтгүй олгох мөнгөн, мөнгөн бус хөрөнгийг;

4.1.10.“судалгааны их сургууль” гэж судалгааны үйл ажиллагаа эрхэлдэг, бакалавр болон ахисан түвшний сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг дээд боловсролын сургалтын байгууллагыг.” Санал гаргасан ажлын хэсэг. Чинбүрэн гишүүн асуулт асууя.

Ж.Чинбүрэн: Би нэг ийм юм асуух гэсэн юм. Ер нь бол энэ анагаах ухааны сургалт бол ердийн дээд сургуулийг бодох юм бол 4 жил биш 6 жил сурдаг. Тэгээд төгссөн диплом нь бол адилхан бакалавр зэрэгтэй төгсөөд байдаг. Тэгээд олон улсын практикаас харахад бол бакалавраас дээгүүр хэмжээний төгсөлт сургалт гэж үздэг. Энэ дээр тийм бодлогын өөрчлөлт бидэнд бий юу. Энэ хуульд

энэ тухай орсон санаа, оноо бий юу гэж асуух гэсэн юм.

Г.Мөнхцэцэг: Ажлын дэд хэсэг 2 дугаар микрофон дээр Тамир дарга Чинбүрэн гишүүний асуултад хариулъя.

Х.Тамир: Чинбүрэн гишүүний асуултад хариулъя. Ажлын дэд хэсгийн гишүүн Боловсрол, шинжлэх ухааны яамны Тамир.

Бакалавр болон магистрын хөтөлбөрийг хамтад нь нэгдмэл агуулгаар суралцаж төгсгөж болно оо гэсэн нэг заалт орж байгаа юм. Тэгэхээр бакалавртайгаа, магистртайгаа хамт 6 жил дотор сурч болох зохицуулалт нь энэ хуулиар орж байгаа гэсэн үг. 150 кредитээр. Анагаахын хөтөлбөр угаасаа их олон кредитээр үзэж байгаа учраас шууд магистр олгож болох тийм зохицуулалт нь орж байгаа.

Г.Мөнхцэцэг: Чинбүрэн гишүүн асуултад хариулт авлаа. Ундрам гишүүн асуултаа асууя.

Ч.Ундрам: Энэ 4.1.9-ийн нэр томъёог судалгааны гранд гэж нэрлэе. Ресерч гранд гэдэг болохоор. Тийм л санал байна.

Г.Мөнхцэцэг: Ундрам гишүүний хэлсэн найруулгын засварыг анхаараарай. Санал хураалт. Энэ санал 66.7 хувиар дэмжигдлээ.

5.Төсөлд доор дурдсан агуулгатай 5 дугаар зүйл нэмэх:

“5 дугаар зүйл.Дээд боловсролын сургалтын байгууллага үйл ажиллагаандаа баримтлах зарчим

5.1.Дээд боловсролын сургалтын байгууллага үйл ажиллагаандаа Боловсролын ерөнхий хуульд зааснаас гадна дараах зарчмыг баримтална:

5.1.1.эрдмийн эрх чөлөөг эрхэмлэх;

5.1.2. оюуны бүтээл, судалгааны ёс зүйг дээдлэх;

5.1.3.дээд боловсролын сургалтын байгууллагын бие даасан байдлыг дэмжсэн байх;

5.1.4.хамтын удирдлагатай, улс төрөөс хараат бус байх.”

Энэ дээр түрүүн ажлын хэсэг дээр яриад байсан. Ингэж улс төрөөс яг энүүгээр тогтсон юм уу. Ажлын хэсгийн гишүүд ингэж яг энэ улс төрөөс хараат бус байх. Энэ 5.1.4 дээр яг энэ томъёоллоор санал хураалт явуулаад, эцэслэсэн юм уу. Арай өөр байдлаар санагдаад байх юм. Ажлын дэд хэсэг 2 дугаар микрофон дээр хариулт авъя.

Х.Тамир: Дээд боловсролын сургалтын байгууллагад улс төрөөс оролцоогүй байх гэсэн тийм найруулгын засвар өгсөн. Бид бас сая цаг хугацааны юунд шахагдаад орхисон байна. Найруулгын засвар.

Г.Мөнхцэцэг: Энэ яг энүүгээрээ биш өөр байдлаар томъёолж орж ирсэн байх ёстой тийм үү. Найруулгын засвар дээр анхаараарай. Найруулга дээр анхаарна гэж түрүүн ажлын хэсэг дээр 5.1.4 дээр найруулгын засвар. Санал хураалт. Энэ санал 77,8 хувиар дэмжигдлээ.

Хэлэлцэж байгаа асуудлын 3 дугаар асуудал дээр холбогдуулаад ажлын хэсгийн нэрс өөрчлөгдсөн байгаа. Энийг бас танилцуулчихъя.

Боловсрол, шинжлэх ухааны сайд Энх-Амгалан оролцож байгаа. Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Ганбаяр, Боловсролын Ерөнхий газрын дарга Ням-Очир, Боловсрол, шинжлэх

ухааны яамны Дээд болон мэргэжлийн боловсролын бодлого удирдлага зохицуулалтын газрын дарга Тамир, Нарантуяа Боловсрол, шинжлэх ухааны яамны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын шинжээч, Туяа Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн секторын эрхлэгч, Намнан Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн захирал, Чулуундорж Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн захирал, Ариунаа Монгол Улсын консерваторын эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал, шинжлэх ухааны доктор, профессор, Цогтгэрэл Монголын боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний холбооны дарга, Номин Монголын хувийн хэвшлийн бага, дунд сургуулиудын холбооны тэргүүн, Анударь Монголын оюутны холбооны ерөнхийлөгч. Анударь байгаа юм уу. Анударь, Тунгалаг Бүх нийтийн боловсролын төлөө иргэний нийгмийн үндэсний эвслийн ерөнхий зохицуулагч, Баярмаа Боловсрол, шинжлэх ухааны яамны Хууль эрх зүйн хэлтсийн ахлах шинжээч, Цолмон Боловсрол, шинжлэх ухааны яамны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч, Билгүүдэй Боловсрол, шинжлэх ухааны сайдын орон тооны бус зөвлөх, Халиунаа Боловсрол, шинжлэх ухааны яамны Мэргэжлийн боловсрол сургалтын хэлтсийн дарга. Ийм бүрэлдэхүүнтэй хэлэлцэж байгаа асуудалд оролцож байна.

Санал хураалт танилцуулсан.

6.Төслийн 2 дугаар бүлгийн гарчгийн **“БОЛОВСРОЛЫН”** гэсний дараа **“СУРГАЛТЫН”** гэж нэмж /цаашид тохиолдол бүрд/, төслийн 5.1 дэх хэсгийн **“гэсэн ангилалтай”** гэснийг, мөн зүйлийн 5.2, 5.3 дахь хэсгийг төслөөс хасаж, 5.5, 5.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 5.7-5.9 дэх хэсэг нэмэх:

5.5.Энэ хуулийн 5.1, 6.7-д заасан дээд боловсролын сургалтын байгууллагын ангиллыг техникийн зохицуулалтад үндэслэн боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

5.6.Цэрэг, цагдаагийн мэргэжлийн чиглэлийн сургалтын үйл ажиллагааг Боловсролын ерөнхий хуулийн 3.1.19-д заасан төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллага эрхэлнэ.

“5.7.Энэ хуулийн 5.1, 6.7-д заасан дээд боловсролын сургалтын байгууллагад тавих техникийн зохицуулалтыг Засгийн газар батална.

5.8.Консерватор нь ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсрол, техникийн болон дээд боловсрол эзэмшүүлэх шаталсан сургалттай хөгжмийн дээд боловсролын сургалтын байгууллага байна.

5.9.Технологийн коллеж нь бүрэн дунд боловсрол, техникийн болон дээд боловсролын шаталсан сургалттай, дэд бакалавр, бакалаврын зэрэг олгох сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг дээд боловсролын сургалтын байгууллага байна.” Санал гаргасан ажлын хэсэг. Тэр 5.8 дээр консерватороо ингээд бүгдийг нь яг мэргэжил олгох, боловсрол олгох юмнуудын зарчмыг нь бол ингээд шаталсан сургалтыг нь бол тохирчихсон байгаад байдаг. Яг нөгөө нэг арай өөр хэлбэрээр найруулахаар орж ирж байсан даа. Энэ дээр нэмэлт заалт оруулахаар орж ирж байсан даа. Санхүүжилттэй холбоотойгоор. Тэр хаана орж байгаа юм. 1 дүгээр микрофон дээр Ганбаяр сайд хэлчих дээ. Протокол тэмдэглэе дээ.

Г.Ганбаяр: Консерватортой холбоотой томъёолол нь бол ингээд 5.8-аар ороод, энэ консерватортой холбоотой санхүүжилттэй холбоотой

асуудал энэ хуулийн санхүүжилт гэсэн хэсэг дээр нь бид нар оруулж өгөхөөр томъёолоод, тодорхой яах вэ найруулга бол байж болох байх. Томъёолол бол бид нар тэр хэсэг дээрээ тавьчихсан байгаа.

Г.Мөнхцэцэг: Санхүүжилтийн хэсэгт орсон гэж ойлголоо. Санал хураалт. Энэ санал 77,8 хувиар дэмжигдлээ.

7.Төслийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.4, 6.6 дахь хэсгийг төслөөс хасаж, 6.1, 6.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 6.7- 6.10 дахь хэсэг нэмэх:

“6.1.Их сургууль нь дэд бакалавр, бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг сургалт, судалгаа, туршилт-үйлдвэрлэлийн байгууллага байна.

6.5.Их сургууль нь харьяалалдаа коллеж, технологийн коллеж, политехник коллеж, мэргэжлийн боловсролын сургууль, судалгааны лаборатори, төв, хүрээлэн, ахлах сургууль, дадлагын баазтай байж болно.

6.7.Их сургуулийг үйл ажиллагааны хүрээ, сургалт, судалгааны чиглэл, сургалтын хөтөлбөр, суралцагч, төгсөгчийн тоо, бусад холбогдох үзүүлэлтэд үндэслэн судалгааны, сургалтын, мэргэжлийн гэж ангилна.

6.8.Их сургууль нь сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор байж болно.

6.9.Багш бэлтгэх их сургууль нь харьяалалдаа цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, соёл, урлаг, цэргийн мэргэжлийн чиглэлээр сургалтын үйл ажиллагаа эрхэлдэг их

сургууль нь бүрэн дунд сургуультай /6-12 дугаар анги/ байж болно.

6.10.Судалгааны их сургуулийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал хуулиар байгуулна.” Энэ дээр асуулттай гишүүн байхгүй байна уу. Багш бэлтгэх сургууль нь харьяалалдаа цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, соёл урлаг, цэргийн мэргэжлийн чиглэл, сургалтын үйл ажиллагаа эрхэлдэг их сургууль. Энэ найруулгын алдаа байна уу. Яг томъёоллын хувьд нэг л уншигдахгүй бөгөөд ийм нэг бүрэн дунд сургуультай байна гээд. Их сургууль нь гээд дээр нь уг нь тодорхойлоод ингэчихсэн байгаа юм. Тийм үү. Тэгсэн дахиад доод талд нь дахиад ийм ажиллагаа эрхэлдэг их сургууль нь бүрэн дунд сургуультай байна. Энийг салгахгүй бол 1 өгүүлбэрээр уншигдахгүй байна. Багш бэлтгэх сургууль нь харьяалалдаа ингээд ингээд байна гэхээд дахиад тусдаа 2 өөр агуулгатай томъёолол орж ирээд байгаа юм биш үү.

Соёл урлаг, цэргийн мэргэжлийн чиглэлээр сургалтын үйл ажиллагаа эрхэлдэг их сургууль нь тусдаа өөр юм байгаа биз дээ тээ, сургууль нь дунд сургуультай байх тухай ингээд 2 өөр агуулгын юмыг нийлүүлээд нэг өгүүлбэр болгочихсон нь ингээд уншигдахгүй байгаад байгаа бөгөөд ер нь нэг тийм хураагдахгүй л байгаад байна. Тэгж уншигдаж байна. Та бүхэн юу яаж байна. “А”, “Б” ч гэдэг юм уу ямар нэгэн байдлаар салахгүй бол ерөөсөө уншигдахгүй байгаад байна. Энэ дээр анхаараарай. Судалгааны их сургуулийг Засгийн газар өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал хуулиар байгуулна гэхчхэн үү. Ингэж томъёолж оруулж ирж байгаа юу. Асуулт асуух гишүүн байхгүй юу.

6.9 дээр редакцын засвар хийхээр болсон. Санал хураалт. Энэ санал 55,6 хувиар дэмжигдлээ.

8.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “бакалаврын сургалт эрхлэх эрх бүхий сургалтын” гэснийг “дэд бакалавр, бакалавр, магистрын зэрэг олгох сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг сургалт, судалгааны” гэж, 7.4 дэх хэсгийн “боловсрол, сургалтын байгууллагатай” гэснийг “боловсролын сургууль, ахлах сургуультай” гэж өөрчилж, төслийн 7.2, 7.3, 7.5 дахь хэсгийг төслөөс хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ санал 66,7 хувиар дэмжигдлээ.

9.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 8.2 дахь хэсгийг төслөөс хасах:

“8.1.Коллеж нь дэд бакалавр, бакалавр, магистрын зэрэг олгох сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг сургалт-судалгаа, сургалт-үйлдвэрлэлийн байгууллага байна.

8.3.Коллеж нь харьяалалдаа политехник коллеж, мэргэжлийн боловсролын сургууль, ахлах сургуультай байж болно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ санал 66,7 хувиар дэмжигдлээ.

10.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “зөвшөөрөл” гэсний өмнөх “, тусгай” гэснийг хасаж, 9.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.3.Төрийн бус өмчийн дээд боловсролын сургалтын байгууллага боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрснөөр харьяаллын сургууль байгуулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Асуулт байна. Түрүүн ажлын хэсэг дээр бас л яриад л байсан. Энэ байгууллагын зөвшөөрснөөр харьяаллын сургууль байгуулна гэж. Энийг яг ямар байдлаар оруулж ирсэн юм бэ. Энэ дээр дэд ажлын хэсгээс

хариулах хүн байна уу. Харьяаллын сургууль байгуулна гэгчихсэн. 2 номерын микрофоныг өгчихье.

Х.Тамир: Дээд боловсролын газраас Тамир хариулъя. Сая ажлын хэсэг дээр бол үүсгэн байгуулагчийн шийдвэрийг үндэслэж төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрснөөр харьяа сургууль байгуулна гэж байсныг үүсгэн байгуулагчийн шийдвэрийг гэдгийг нь авч найруулсан байгаа.

Г.Мөнхцэцэг: Найруулгын засвар хийсэн байна. Тэгээд энийг бас нэг эргээж харахаар л байх шиг байна. Та хэд маань эцсийнхээ найруулга дээр хараадхаарай. Санал хураалт. Энэ санал 66,7 хувиар дэмжигдлээ.

11.Төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “Эрдмийн зөвлөл,” гэсний дараа “хөтөлбөрийн хороо,” гэж, 10.3 дахь хэсгийн “Эрдмийн” гэсний дараа “зөвлөл болон хөтөлбөрийн хороо,” гэж нэмж, төслийн 10.5 дахь хэсгийн “Төрийн өмчийн” гэснийг, мөн зүйлийн 10.4, 10.6, 10.7, 10.9, 10.11, 10.15 дахь хэсгийг төслөөс хасаж, 10.14 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 10.16 - 10.18 дахь хэсэг нэмэх:

“10.14.Дээд боловсролын сургалтын байгууллага нь дотуур байртай байж болно. Дотуур байранд тавигдах шаардлагыг стандарт, техникийн зохицуулалтаар тогтооно.

10.16.Дээд боловсролын сургалтын байгууллага нь сургалтын хөтөлбөр боловсруулах, үнэлэх, сайжруулах дүгнэлт, гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус Хөтөлбөрийн хороотой байна.

10.17.Энэ хуулийн 10.5-д заасан их сургуулийн эмнэлэг нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, сургалт-эрдэм шинжилгээний үйл ажиллагаа эрхэлж болно.

10.18.Энэ хуулийн 9.2-т заасан дээд боловсролын сургалтын байгууллага нь цэрэг, цагдаагийн тогтолцоонд хамаарах анги, байгууллага, цэргийн байртай байна.” Санал гаргасан ажлын хэсэг. Техникийн зохицуулалтаар тогтооно гэж. Энийг бас юу гэж ойлгох вэ. Дотуур байранд тавигдах шаардлагыг стандарт техникийн зохицуулалтаар тогтооно гэж. Техникийн зохицуулалт гэдэг ямар томъёолол вэ. Энийг ямар байдлаар оруулж ирсэн юм. Угаасаа энд ер нь шаардлагыг стандарт гээд тавьчихсан л байна шүү дээ. 1 номерын микрофон дээр дэд сайд Ганбаяр хариулъя.

Г.Ганбаяр: Боловсролын ерөнхий хууль дээр ч энэ томъёоллоороо явж байгаа. Засгийн газраас баталдаг заавал мөрдөх ёстой зохицуулалтын шаардлага. Тэгэхээр энийг бол дотуур байр дээр тавигдах шаардлагыг заавал мөрдөж ажилла гэдгийг хуульчилж байгаа хэлбэр.

Г.Мөнхцэцэг: Хууль дээрээ бас ингэж техникийн зохицуулалт гээд ингээд байдаг юм байна. Санал хураалт. Энэ санал 77,8 хувиар дэмжигдлээ.

12.Төслийн 11 дүгээр зүйлийг 18 дугаар зүйл болгон шилжүүлж, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“18 дугаар зүйл.Дээд боловсролын сургалтын байгууллагын элсэлт

18.1.Дээд боловсролын сургалтын байгууллагын дэд бакалавр, бакалаврын хөтөлбөрт бүрэн дунд боловсрол эзэмисэн, элсэлтийн шаардлага хангасан хүнийг элсүүлнэ.

18.2.Политехник коллеж, шаталсан сургалттай дээд боловсролын сургалтын байгууллагын төгсөгч тухайн мэргэжлийн чиглэлээр дэд бакалавр, бакалаврын хөтөлбөрт элсэхэд энэ хуулийн 18.1 дэх хэсэг хамаарахгүй.

18.3.Боловсролын ерөнхий хуулийн 17.8, энэ хуулийн 18.8-д заасан үнэлгээ,

элсэлтийн шалгалт зохион байгуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

18.4.Дэд бакалавр, бакалаврын хөтөлбөрт элсэгчийн элсэлтийн шалгалтын босго оноог өмчийн хэлбэр харгалзахгүйгээр боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн ижил хэмжээгээр тогтооно.

18.5.Элсэлтийн шалгалтын босго оноог шинэчлэхэд өмнөх босго оноог бууруулахгүйгээр тогтооно.

18.6.Дээд боловсролын сургалтын байгууллага мэргэжил эзэмшихэд шаардагдах мэдлэг, ур чадварыг харгалзан элсэлтийн нэмэлт шалгалт зохион байгуулж болно.

18.7.Ахисан түвшиний сургалтад элсэгч, суралцагчид тавих шаардлага, элсэлтийн шалгалтыг сургуулийн дотоод журмаар зохицуулна.

18.8.Элсэлтийн шалгалтын зохион байгуулалт, үнэлгээний арга зүйг олон улсын чиг хандлагад нийцүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Энэ санал 66,7 хувиар дэмжигдлээ.

13.Төслийн 12 дугаар зүйлийн гарчгийн “Чанарын баталгаажуулалт” гэсний өмнө “Дээд боловсролын” гэж нэмж, 12.1 дэх хэсгийн “үйл ажиллагааны” гэснийг, мөн зүйлийн 12.5, 12.6, 12.9, 12.12 дахь хэсгийг төслөөс хасаж, төслийн 12.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төсөлд доор дурдсан агуулгатай 12.13-12.18 дахь хэсэг нэмэх:

“12.8.Дээд боловсролын сургалтын байгууллага, Боловсролын ерөнхий хуулийн 12.4, энэ хуулийн 12.16-д заасан хөтөлбөр, тэргүүлэх, эрэлттэй мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг 5 жил тутам магадлан итгэмжилнэ.

12.13.Дээд боловсролын сургалтын байгууллагын үндэсний эрэмбэ, чансаа, хөтөлбөрийн чанарыг энэ хуулийн 12.18-д заасан цахим сангийн мэдээлэлд үндэслэн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээний байгууллагатай хамтран хоёр жил тутам тогтоон олон нийтэд мэдээлнэ.

12.14.Энэ хуулийн 12.13-т заасан хөндлөнгийн үнэлгээ зохион байгуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

12.15.Анагаах ухааны чиглэлийн сургалтын хөтөлбөрийг заавал магадлан итгэмжилнэ.

12.16.Хөтөлбөрийн магадлан итгэмжлэл, дээд боловсролын сургалтын байгууллагын эрэмбэ, чансааны үзүүлэлт тухайн байгууллагын суралцагчид хуульд заасан дэмжлэг, зээл, тэтгэлэг олгох үндэслэл болно.

12.17.Дээд боловсролын цахим мэдээллийн сан нь Боловсролын ерөнхий хуулийн 48.3-т зааснаас гадна магадлан итгэмжлэл, эрдэм шинжилгээний бүтээл, санхүүжилт, иргэний гадаад улсад эзэмшсэн боловсрол, үнэлгээ, хөдөлмөр эрхлэлт, зэрэг мэдээллээс бүрдэнэ.

12.18.Энэ хуулийн 12.8-д заасан хугацаагаар 3 удаа магадлан итгэмжлэл хийлгэсэн дээд боловсролын сургалтын байгууллага цаашид 10 жил тутам магадлан итгэмжлэл хийлгэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ санал 66,7 хувиар дэмжигдлээ.

14.Төслийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалтын “эрдэм шинжилгээ” гэснийг “судалгааны ажилд оролцох, бусад сургуулийн суралцагч, багштай хамтран” гэж өөрчилж, төслийн 13.1.6 дахь заалтын “баялаг болгон хувиргах” гэснийг, мөн зүйлийн 13.1.4, 13.1.7 дахь

заалтыг төслөөс хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай 13.1.10, 13.1.11 дэх заалт нэмэх:

“13.1.10.улиралд судлах багц цагийг сонгож, суралцах хугацааг төлөвлөх;

13.1.11.ижил түвшний бусад сургуулийн хичээл болон багшийг сонгон суралцах багц цагийг дүйцүүлэх.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүд асуулт ерөөсөө байхгүй юм уу. Ямар сайн юм бэ. Унишж байгаа би ерөөсөө зарим нэг зүйл дээр гацаад байна шүү дээ. Зүгээр үү. Үгүй ээ, тэр биш ойлгомжтой уншаад байхад ойлгогдохгүй байна шүү дээ зарим нь. Энэ санал 77,8 хувиар дэмжигдлээ.

15.Төслийн 14 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 14.1.4 дэх заалт нэмэх:

“14.1.5.хууль тогтоомжид заасан сургалтын төлбөрийн хөнгөлөлт эдлэх;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Микрофондоо засаад хэлчихье. Сургалтын төлбөрийн хөнгөлөлт юм байна шүү. 66,7 хувиар энэ санал дэмжигдлээ.

Дарааллыг хараарай энэ 14.1.5 гээд явж байна шүү. 14.1.4 шүү.

16.Төслийн “Суралцагчийн сургалтын үнэлгээ” гэсэн 15 дугаар зүйлийг 21 зүйл болгон шилжүүлж доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21 дүгээр зүйл. Суралцагчийн үнэлгээ, төгсөлт

21.1.Суралцагчийн үнэлгээ нь суралцахуйн үр дүнг бататгах, бие даан суралцах үйл ажиллагаа, бүтээлч хандлагыг дэмжих, авьяас, ур чадварыг хөгжүүлж урамшуулахад чиглэнэ.

21.2.Дээд боловсролын сургалтын байгууллагын онцлогоос хамааран

суралцагчийн судалгааны ажлын үр дүн, суралцаж буй мэргэжлийн чиглэлээр олон улсын тэмцээн, уралдаанд гаргасан амжилтыг багц цагт тооцож болно.

21.3.Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчийн үнэлгээний үлгэрчилсэн журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

21.4.Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчийн суралцахуйн үр дүнг үнэлэх үйл ажиллагааг энэ хуулийн 15.4-т заасан журмаар Боловсролын ерөнхий хуулийн 17.7-д заасан байгууллага, мэргэжлийн холбоод, ажил олгогчийн төлөөлөл хамтран хэрэгжүүлнэ.

21.5.Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид диплом олгох, хүчингүй болгох, гадаадын дээд боловсролын сургалтын байгууллага төгссөн төгсөгчийн дипломыг хүлээн зөвшөөрөх, бүртгэх, баталгаажуулахтай холбогдох харилцааг Боловсролын ерөнхий хуулийн 30.1.31-д заасан журмаар зохицуулна.

21.6.Магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийг тухайн дээд боловсролын сургалтын байгууллагын дотоод журмаар, докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн бүрэлдэхүүн болон дүрмийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ санал 77,8 хувиар дэмжигдлээ.

17.Төслийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “хичээлийг” гэснийг “хөтөлбөрийг хэрэгжүүлэх” гэж, “багш заана” гэснийг “байна” гэж өөрчилж, 16.3 дахь хэсгийг төслөөс хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 16.2, 16.5 дахь хэсэг нэмэх:

“16.2.Дээд боловсролын сургалтын байгууллагын багш нь магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байна.

16.5.Дээд боловсролын сургалтын байгууллага нь тухайн сургалтын байгууллагын багийн мэргэжлийн хөгжлийг хангах журмыг баталж, хэрэгжүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ санал 77,8 хувиар дэмжигдлээ.

18.Төслийн 17 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 17.2.3 дахь заалт нэмэх:

“17.2.3.судалгаа, эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх.” Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. Энэ санал 77,8 хувиар дэмжигдлээ.

19.Төслийн 18 дугаар зүйлд доор дурдсан 18.2 дахь хэсэг нэмж, мөн зүйлийн 18.1.4 дэх заалтыг 18.3 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“18.2.Дээд боловсролын сургалтын байгууллагын багшид тухайн ажиллаж байгаа байгууллагаас дараах дэмжлэгийг үзүүлж болно:

18.2.1.орон нутаг дахь төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад ажиллаж байгаа багш, ажилтанд орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийг 5 жил тутамд нэг удаа олгох;

18.2.2.дээд боловсролын сургалтын байгууллагын харьяа мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн багшид Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 18.1.3-т заасан тэтгэмж олгох.

18.3.Энэ хуулийн 18.1.4, 18.1.5-т заасан дээд боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны нийгмийн баталгааг хангахтай холбогдсон бусад

харилцааг тухайн сургалтын байгууллагын дотоод журмаар зохицуулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ санал хураалт 66,7 хувиар дэмжигдлээ.

20.Төслийн “Сургалтын зохион байгуулалт” гэсэн 21 дүгээр зүйлийг 19 дүгээр зүйл болгож, төслийн 21.2 дахь хэсгийн “Магистр, докторын сургалтын” гэснийг “Дээд боловсролын сургалтын байгууллага нь сургалт,” гэж өөрчилж, мөн зүйлийн 21.4 дэх хэсгийг төслөөс хасаж, 21.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төсөлд доор дурдсан агуулгатай 21.5-21.8 дахь хэсэг нэмэх:

“21.3.Дээд боловсролын хичээлийн жил нь улиралд хуваагдах бөгөөд 2-4 улиралтай байж болно. Суралцах хугацааг элсэлтийн шалгалттай уялдуулан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөгөөр зохицуулна.

21.5.Суралцагч элссэн мэргэжлийн чиглэлийн хөтөлбөрт суралцах хугацаанд бусад мэргэжлийн чиглэлийн хөтөлбөрт давхар суралцаж хос мэргэжил эзэмшиж болно.

21.6.Ахисан түвшиний сургалтын хөтөлбөрийг эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран хэрэгжүүлж болно.

21.7.Дээд боловсролын сургалтын байгууллага нь төгсөгчийн мэргэжлийн хөгжлийг хангах, насан туршийн суралцахуйн тогтолцоог бүрдүүлэх ажлыг зохион байгуулна.

21.8.Дээд боловсролын сургалтын байгууллага нь бие даан эсхүл хамтран цахим сургалтын системийг бүрдүүлэн сургалт зохион байгуулж болно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ санал 66,7 хувиар дэмжигдлээ.

21.Төслийн “Сургалтын хөтөлбөр” гэсэн 19 дүгээр зүйлд

“Сургалтын хөтөлбөрийн агуулга” гэсэн 20 дугаар зүйлийг нэгтгэн “Сургалтын хөтөлбөр, агуулга” гэсэн 20 дугаар зүйл болгож, төслийн 19.1 дэх хэсгийг төслөөс хасаж, төслийн 20.2 дахь хэсгийн “Сургалтын хөтөлбөрийн агуулга нь” гэснийг “Дэд бакалавр, бакалаврын сургалтын хөтөлбөрт” гэж өөрчилж, төсөлд доор дурдсан агуулгатай 19.9-19.15, 20.5 дахь хэсэг нэмж, төслийн 20.3, 20.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19.9.Сургалтын агуулгыг багц цагаар тооцох, багц цагийг дүйцүүлэх журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

19.10.Дээд боловсролын сургалтын байгууллага нь суралцагчийн хүсэлтээр энэ хуулийн 19.2-т заасан журмын дагуу бакалавр-магистрын 150-иас, магистр-докторын 90-ээс доошгүй багц цаг бүхий нэгдмэл агуулгатай хөтөлбөрийг хэрэгжүүлж болно.

19.11.Энэ хуулийн 19.10-т заасан нэгдмэл хөтөлбөрөөр суралцсан төгсөгчид тухайн түвшин бүрийн боловсролын баримт бичгийг олгоно.

19.12.Бакалаврын хөтөлбөрт суралцаж 90 багц цаг судалсан боловч цаашид суралцах боломжгүй болсон дэд бакалаврын зэрэг олгоход тавих шаардлагыг хангасан тохиолдолд тухайн боловсролын баримт бичгийг дүйцүүлэн олгож болно.

19.13.Боловсролын ерөнхий хуулийн 3.1.4-т заасан багц цаг нь дээд боловсрол эзэмшихэд тавих шаардлага, сургалтын төлөвлөгөө, төлбөр, багшийн ажлын ачаалал зэргийг тогтоох үндэслэл болно.

19.14.Боловсролын ерөнхий хуулийн 30.1.10-т заасан дээд боловсролын мэргэжлийн чиглэл,

хөтөлбөрийн индексийн жагсаалтыг 5 жил тутам шинэчлэн батална.

19.15.Сургалтын хөтөлбөрийг тухайн дээд боловсролын сургалтын байгууллага, мэргэжлийн холбоо, ажил олгогч, төгсөгчийн төлөөллөөс бүрдсэн энэ хуулийн 10.3 -т заасан хөтөлбөрийн хороо хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.

20.3.Дээд боловсролын түвшин нь багц цагаар хэмжигдэх дэд бакалаврын, бакалаврын, магистрын, докторын зэрэгтэй байна.

20.4.Багц цагийн хэмжээ нь дэд бакалаврын зэрэгт 90 багц цагаас доошгүй, бакалаврын зэрэгт 120 багц цагаас доошгүй, магистрын зэрэгт 30 багц цагаас доошгүй, докторын зэрэгт 60 багц цагаас доошгүй байна.

20.5.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг төгсөгч эзэмшсэн мэргэжлийн чиглэлээр дээд боловсролын сургалтын байгууллагад суралцахад багц цаг дүйцүүлэн тооцож болно.” Санал гаргасан ажлын хэсэг. Энэ томъёоллыг дахиад бас шинээр найруулаад оруулж ирж байгаа. Гүйцээж боловсруулахаар ажлын хэсэг дээр ярьсан юм. Тэгээд гүйцээж боловсруулах гээд ийм томъёоллоор оруулж ирж байгаа юм. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ санал 77,8 хувиар дэмжигдлээ.

22.Төсөлд **“ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ИННОВАЦ”** гэсэн **ТАВДУГААР БҮЛЭГ** нэмж, төслийн 22 дугаар зүйлийг тус бүлэгт хамааруулан, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 22.8 дахь хэсэг нэмэх:

“22.8.Их сургууль салбар дундын судалгааны нээлттэй лаборатори болон технологийн туршилт, зүгшрүүлэлтийн нэгдсэн сүлжээг байгуулж ажиллуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” Санал

гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ санал 77,8 хувиар дэмжигдлээ.

23.Төсөлд доор дурдсан агуулгатай 23 дугаар зүйл нэмэх:

“23 дугаар зүйл. Судалгааны ёс зүй

23.1.Дээд боловсролын сургалтын байгууллагын багш, суралцагчийн эрдэм шинжилгээний бүтээлийн нэгдсэн мэдээллийн сангийн бүртгэл, мэдээлэл солилцох, хадгалах, хамгаалах, баяжуулах, ашиглахтай холбогдох үйл ажиллагааг Шинжлэх ухаан, технологийн сан хариуцна. Энэ мөн үү.

23.2.Дээд боловсролын сургалтын байгууллага нь сургалтын байгууллагын багш, суралцагчийн судалгааны ажил хуулбарлалт шалгах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

Ажлын хуулбарлалт гэж. Энэ дээр бас найруулгын хувьд анхаарахгүй бол болохгүй байна. Судалгааны ажлын хуулбарлалт шалгах журам гэж ийм журам байдаг юм уу. Ажлын дэд хэсэг энэ 23.2 дээр энийг найруулгын хувьд анхаармаар юм шиг байна. Ер нь яах вэ ажлын хуулбарлалт шалгах журам гэж угаасаа байдаг юм байна тийм үү. Тэгээд ер нь бол судалгааны ажлын хуулбарлалт гээд найруулгын хувьд уншигдахгүй бөгөөд нэг л буухгүй байгаад байна. Энийг суралцагчийн, судалгааны, ажлын гээд жаахан найруулгын хувьд давхардсан юм байгаад байна. Энийг хараадхаарай найруулгын хувьд. Энэ дээр анхаараарай.

23.3.Дээд боловсролын судалгааны ёс зүйг Боловсролын ерөнхий хуулийн 27.4-т заасан судалгааны ёс зүйн дэд хороо хариуцна.

23.4.Энэ хуулийн 23.3-т заасан Зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

23.4.1.эрдмийн ажилд оюуны өмч, зохиогчийн эрхийг дээдлэх, зөрчихгүй байх, зөрчихөөс урьдчилан сэргийлэх талаар дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх журам, заавар, зөвлөмж боловсруулах, батлах;

23.4.2.энэ хуулийн 23.4.1-д заасан журмын хэрэгжилтэд хяналт тавих;

23.4.3.судлаачийн ёс зүйн зөрчлийн талаарх гомдлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хянан хэлэлцэх, энэ хуулийн 23.4.1-д заасан журмын дагуу шийдвэрлэх.”

Тэр 23.2 дээр мөн 23.4.1 дээр найруулгын жаахан юунууд байгаад байна. Редакцын засварууд байгаад байна. Энийг манай дэд ажлын хэсэгт жоохон анхаараадхаарай, ер нь анхаараадхаарай. Оюуны өмчийн зохиогчийн эрхийг дээдлэх зөрчихгүй байх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх гээд л ингээд баахан ийм нэг агуулгатай юм шиг хэр нь найруулгын хувьд арай л болж өгөхгүй байгаад байна шүү. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Редакцын засвар хийх юм байна. Энэ санал 77,8 хувиар дэмжигдлээ.

24.Төслийн 5 дугаар бүлгийг 6 дугаар бүлэг болгож, төслийн 23.1 дэх хэсгийн “боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байх бөгөөд” гэснийг хасаж, 23.1.4 дахь заалтын “зэрэг” гэсний дараа “, цол” гэж нэмэн, мөн зүйлийн 23.1.3 дахь заалтыг төслөөс хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай 23.1, 23.3, 23.4 дэх хэсэг нэмэх:

“23.1.Дээд боловсролын удирдлага нь Боловсролын ерөнхий хуулийн 27.1-д заасан байгууллагаас бүрдэнэ.

23.3.Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх нэгжтэй байж болно.

23.4.Энэ хуулийн 23.3-т заасан нэгжийг Засгийн газрын шийдвэрээр байгуулж, бүтэц, ажиллах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” Санал гаргасан ажлын хэсэг. Ундрам гишүүн саналаа хэлье.

Ч.Ундрам: Засгийн газрын газраас өргөн барьсан Дээд боловсролын хуулийн бас нэг том урагшаа алхаж байгаа алхам нь энэ албан тушаалын цол, зэрэглэл 2-ыг нэгтгэж өгсөн ийм төсөл байсан байхгүй юу. Тэгсэн чинь одоо буцаад цол гэж нэмнэ гээд. Зэрэг гэсний дараа цол гэж нэмнэ гээд 1 үг нэмээд оруулаад ирж байна шүү дээ. Ингэнгүүт буцаад л нөгөө зэрэглэл, цол гээд л. Би жишээлбэл МУИС-д ажиллаж байхдаа профессорын зэрэглэлд дэд профессорын цолтой ингээд ажиллаж байсан. Тэгээд ийм нөгөө толгой эргүүлсэн 2 янзын ийм хүний нөөцийн систем яваад байдаг юмыг буцаад энэ үгээр оруулж ирэх юм. Тийм учир багаас энэ цол гэдэг үгийг хасаад, бусад нь бол яг сая таны уншсан хэвээрээ ингэж оруулж өгмөөр байна.

Г.Мөнхцэцэг: Ажлын хэсгийн ахлагч Ундрам бас ажлынхаа хэсэг дээр яриад энэ зүйлүүд байсан. Энэ 23.3 дээр бас л нэг л уншигдахгүй л байгаад байна. Энэ ингэж яах вэ энэ томъёололд хуульдаа ийм юм байдаг юм гээд ингээд хаяад байх юм уу, үгүй юм уу. Ямар ч байсан төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын хөрөнгийн удирдлагыг энэ чинь хэнийг хэлж байгаа ямар томъёолол юм бэ. Яах вэ боловсролын сургалтын байгууллагын хөрөнгийн удирдлагыг гэж байдаг. Хөрөнгийн удирдлага гэж байдаг юм уу. Компани гэж байхгүй байна. Нэгжтэй байж болно гэж нэгжээ хэлээд байгаа юм уу. Энэ уншигдаж байна уу. Надад бол ер нь буухгүй л байгаад байна. Энийг байна шүү дээ бас дахиад ер нь найруулгын засвар хийчихье. Түрүүчийн Ундрам гишүүний, ажлын хэсгийн ахлагчийн хэлээд байсан цол гэснийг хасъя гээд. Хуучин Засгийн газрын өргөн

барьснаараа тэр цол гэдгийг хасъя гэснээр нь оруулаад ингээд цаашаа гүйцээж боловсруулаад найруулаад ингээд явчихъя. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ санал 77,8 хувиар дэмжигдлээ.

25.Төслийн 24 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“24 дүгээр зүйл. Дээд боловсролын зөвлөл

24.1.Боловсролын ерөнхий хуулийн 27.4-т заасан мэргэжлийн зөвлөл нь Дээд боловсролын зөвлөл байна.

24.2.Дээд боловсролын зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх) нь дээд боловсролын удирдлага, зохион байгуулалт, сургалт, судалгааны үйл ажиллагаа, үр дүнг хэлэлцэх, санал зөвлөмж гаргах, оролцогч талуудын оролцоо, хамтын ажиллагааг дэмжих чиг үүрэг бүхий орон тооны бус байгууллага байна.

24.3.Зөвлөл нь төрийн, дээд боловсролын сургалтын байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага болон үйлдвэр, аж ахуйн нэгж, оюутны төлөөллөөс бүрдсэн 15 гишүүнтэй байна.

24.4.Зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг Боловсролын ерөнхий хуулийн 27.6-д заасны дагуу боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” Санал гаргасан ажлын хэсэг. Энэ бас уншигдаж байна уу. Дээд боловсролын салбарын хувьд үгүй ээ энэ тийм юмны хувьд гэж хуульд оруулж болдог юм уу. Энэ дээр бас манайхан 24.1 дээр бас нэг найруулгын засвар байгаад байх шиг байна. Дээд боловсролын салбарын хувьд гэж тийм юмны хувьд, ийм юмны хувьд гээд ярианы яг бичгийн хэл мөн үү. Хуулийн хэллэг мөн үү. Энэ дээр бас найруулгын засвар байна. Тэр хувьд гэдэг үгийг анхаараарай. Санал гаргасан ажлын

хэсэг. Санал хураалт. Энэ санал 66,7 хувиар дэмжигдлээ.

26.Төслийн 25 дугаар зүйлийн 25.4-25.7, 25.9 дэх хэсгийг төслөөс хасаж, мөн зүйлийн 25.10-25.13 дахь хэсэг нэмж, 25.2, 25.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“25.2.Удирдах зөвлөл нь үүсгэн байгуулагч, тухайн сургуулийн багш, суралцагч, төгсөгч, ажил олгогчийн төлөөлөл бүхий 15 хүний бүрэлдэхүүнтэй байна. Түрүүн дээр бас удирдах зөвлөл байсан шүү дээ. Удирдах зөвлөлийг. Энэ санал дээр түрүүн бас Хууль зүйн яамнаас зөвлөсний дагуу энд нэмэх юм байна шүү. Удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигч буюу энийг гүйцээж найруулаад оруулаад ирээрэй. Ингээж уншигдах юм байна. Удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигч буюу үүсгэн байгуулагч тэгээд таслал тухайн сургуулийн багш, суралцагч, төгсөгч, ажил олгогчийн төлөөлөл бүхий 15 хүний бүрэлдэхүүнтэй байна.

25.3.Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлд үүсгэн байгуулагчийн төлөөлөл найм, багшийн төлөөлөл гурав, төгсөгч, ажил олгогчийн төлөөллүүд. Энийг бас гүйцээж найруулмаар байна. Нэгэнт бүгд дээр нь төлөөлөл гэх гэж байгаа юм бол бүгд дээр нь төлөөлөл гэж бичнэ. Тэгэхгүй бол суралцагчийн төлөөлөл 8, багшийн төлөөлөл 3, төгсөгч, ажил олгогчийн 3, суралцагчийн төлөөлөл гээд ерөөсөө ойлгомжгүй ийм найруулгатай байгаад байна. Төлөөлөл гэх гэж байгаа бол бүгд дээр нь төлөөлөл гэдгээр нь оруулаад, үгүй бол нэгдсэн найруулгын засвар хийх хэрэгтэй харагдаж байна. Энийг гүйцээж найруулаарай.

25.10.Төрийн бус өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн энэ хуулийн 25.3-т заасан төлөөллийн оролцоог хангасан байна.

25.11.Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллага дундаа Удирдах зөвлөл байгуулж болно. Энэ тохиолдолд энэ хуулийн 25.3-т заасан төлөөллийг оролцуулсан байна. Заавал дундаа гэхгүйгээр найруулж болохгүй юм уу. Дундаа биш дундын биш юм уу. Энэ дээр бас найруулгын засвар хиймээр байна. Боловсролын сургалтын байгууллага дундын удирдах зөвлөлтэй байж болно гэдэг юм уу. Дэд ажлын хэсэг Ганбаяр сайд аа, энэ 25.11 дээрээ найруулгын засвар хиймээр байна. Дундын удирдах зөвлөлтэй байна гэж байж болно биз дээ. Тэгэхгүй бол дундаа гээд, байгуулж болно гээд энэ бас дахиад найруулгын засвар хиймээр байна.

25.12.Энэ хуулийн 25.11-д заасан Удирдах зөвлөл байгуулах тохиолдолд зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг Засгийн газар батална.

25.13.Энэ хуулийн 25.1-т заасан удирдах зөвлөлийн даргыг сонгох, гишүүнээр ажиллах, бүрэн эрхийн хугацаа дуусгавар болгох, дарга, гишүүнийг эргүүлэн татах харилцааг зохицуулах удирдах зөвлөлийн нийтлэг дүрмийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 77,8 хувиар дэмжигдлээ.

27.Төслийн 26 дугаар зүйлийн 26.1.4 дэх заалтын “журмын дагуу” гэсний дараа “төрөөс хараат бусаар” гэж нэмж, 26.1.10 дахь заалт, 26.3, 26.4 дэх хэсгийг төслөөс хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ санал 77,8 хувиар дэмжигдлээ.

28.Төсөлд доор дурдсан агуулгатай 27 дугаар зүйл нэмэх:

“27 дугаар зүйл. Эрдмийн зөвлөл

27.1.Эрдмийн зөвлөл нь 21-ээс доошгүй гишүүнээс бүрдэх бөгөөд

гишүүнээр эрдмийн зэрэг, цолтой багшийг үндсэн орон тооны нийт багш нарын хурлаар сонгоно. Сая ажлын хэсгийн ахлагчийн гаргасан цол гэдэг авчихлаа шүү дээ. Тэгэхээр одоо яах юм. Цолтой гэдэг юм энэтэй яаж нийцүүлэх юм. Энэ дээр ажлын хэсэг нийцүүлээд, түрүүчийн хассантай нийцүүлээд, томъёолоод найруулаад оруулаад ирээрэй.

27.2.Эрдмийн зөвлөл нь доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

27.2.1.сургалт, судалгааны чиглэлийг тогтоох, хэрэгжилтийн үр дүнг хэлэлцэх, дүгнэлт гаргах;

27.2.2.дэд профессор, профессор хүндэт цол олгох;

27.2.3.судалгааны төсөл болон ахисан түвшний сургалт судалгааны үр дүнг хэлэлцэх, дүгнэх.

27.3.Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагаанд холбогдох бусад харилцааг тухайн дээд боловсролын сургалтын байгууллагын Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагааны журмаар зохицуулна. Найруулга дээр анхаармаар байна.

27.4.Эрдмийн зөвлөл нь сургалт, эрдэм шинжилгээний бодлого, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох чиг үүрэг бүхий орон тооны бус байна.” Санал гарсан ажлын хэсэг.

Энэ 27.3, дээрээс нь тэр 27.1 дээр цолтой холбоотойгоор хасагдаж байгаа найруулга оруулж ирэхдээ энэ 27.3 дээр бас уншигдахгүй байгаад байна. Энэ найруулгын юмнуудаа бас нэг жоохон хараад ажлын дэд хэсэг энэ дээрээ анхаараад дараагийнхаа чуулганд оруулахад анхаараарай. Ганбаяр сайд үг хэлэх гээд байна уу. 1 номерын микрофоныг өгье.

Г.Ганбаяр: Ундрaм гишүүний санaлаар энэ цoлтой холбоотой харилцааг ингээд хумьчихвал нөгөө эрдмийн зөвлөл дээр асуудал үүсэхгүй юу Ундрaм гишүүн ээ. Бид нар тэгж л яагаад эрдмийн зөвлөл дээр заавал зэрэг цол чинь байж байж зөвлөлөө бүрдүүлэх гээд байгаа учраас. Тэгэхээр энэ дээр яах вэ. Би танаас дахиад л чиглэл авах гээд байна.

Г.Мөнхцэцэг: Ундрaм гишүүний микрофоныг өгье.

Ч.Ундрaм: Тухайн их сургууль нь өөрсдийнхөө шаардлагыг тавиад профессорын албан тушаалын зэрэглэл дээр профессоруудаа сонгон шалгаруулаад ажиллуулж байгаа. Тэр хүмүүсээс нь эрдмийн зөвлөл нь бүрдвэл яг зөв болчих юм. Тэгэхээр тухайн сургуулийн профессорын албан тушаал дээр ажиллаж байгаа хүмүүсээс эрдмийн зөвлөл нь бүрдчих юм бол тэгээд л яг л нөгөө хамгийн өндөр тэр шинжлэх ухааны төлөөллүүдээс бүрдсэн эрдмийн зөвлөл болно гэсэн үг болчхож байгаа юм.

Г.Мөнхцэцэг: Засгаас өргө өргөн баригдсан эх төсөл дээрээ ямар байгаад байгаа юм. Тэгээд энийг аваад хаячихаар ер нь ямаршуу юм болох юм. Тэр зарчмаараа явахгүй юм уу. Өргөн барьсан зарчмаараа. 2 номерын микрофоныг өгье.

Х.Тамир: Албан тушаалын цол биш. Энэ цол бол яг эрдмийн зөвлөлөөр олгодог дэд профессор, профессор цол. Өмнө нь хасаж байгаа ч гэсэн бас тэр цолыг хасах шийдвэр эндээс гаргачихлаа. Тэгээд энэ эрдмийн зөвлөл дээр бол дэд профессор, профессор цолоо олгохоо болино гэж үзэж байна шүү дээ. Захиргааны зөвлөлөөр олгох болгох гээд түүрүүчийн юунаас цолыг хасчихлаа гэж ойлгож болох уу.

Г.Мөнхцэцэг: Ундрaм гишүүн микрофон дээр саяынхаа санал хасагдсан

саналыг яг энэ хуультайгаа нийцүүлж байгаад түүрүүн төсөл дээрээ байсан саналтайгаа зөрчилдөж байгаа эсэх дээр нэг саналаа хэлээдхээч.

Ч.Ундрaм: Одоо бол байна шүү дээ. Тухайн сургууль өөрийнхөө дотоод журмаар ямар эрдэм шинжилгээний амжилт гаргасан бүтээлтэй, ямар судалгааны санхүүжилт олж ирсэн хүн нь профессор болох юм бэ үгүй юу гэдгийг оруулаад, тэгээд албан тушаалын зэрэглэл ахихдаа тэр шаардлагыг биелүүлсэн байна уу, үгүй юу гэдгийг нь харж байгаад тэгээд албан тушаалын зэрэглэлийг нь ахиулаад тэр хүнийгээ л ерөөсөө энэ хүн манай сургуулийн профессор юм гээд хүлээн зөвшөөрөөд, тэдгээр хүмүүс нь энэ эрдмийн зөвлөлдөө орчих юм бол манай яриад байгаа энэ вакийн нэг профессорын эрдмийн цолны асуудал, сургуулийн зэрэглэлийн асуудал 2 чинь 1 болчих юм. Тэгэхээр заавал яамнаас сайдын тушаалтай, гар хөлийн үсэгтэй сертификат ирэх шаардлагагүй. Тухайн сургууль нь өөрөө өөрийнхөө профессорыг өөрсдөө ингээд дотоод журмаараа шийдээд явна. Тэр профессор болсон хүмүүс нь эрдмийн зөвлөлдөө орно л гэсэн үг. Өмнө нь вакийнх гээд юмыг та яриад байгаа шүү дээ. Тухайн сургуулийн хүсэлтийн дагуу нэг ийм сертификат өгдөг байхгүй юу.

Г.Мөнхцэцэг: Сая ажлын хэсэг дээр юу гэж ярьсан юм бэ. Дэд ажлын хэсгээс 2 юм.

Ч.Ундрaм: Төсөл дээр яаж орж ирснээрээ л анх энэ хууль чинь угаасаа тэрийгээ янзлаад өргөн барьчихсан байхгүй юу. Тэрнээс нь өмнө бол ингээд зөндөө бид нар ярьж байсан Байнгын хороо дээр. Энэ бүр шинээр ороод ирсэн Эрдмийн зөвлөл гээд. Тэгэхдээ энэ цол, зэрэглэл нэг болох ёстой. Харвардын профессор Харвардынх л байдаг юм. Тэрнээс АНУ-ын Боловсролын яамнаас өгсөн профессор цол гэж байдаггүйтэй адилхан бид нар яг энэ олон улсын жишиг

рүүгээ явж байгаа. МУИС-д би жишээлбэл ажиллаж байгаа МУИС-аас гараад өөр ажилд орсон бол тэгвэл яг л тэр сургуулийнхаараа л явна. Тэгвэл сургуулийн цол, албан тушаалын зэрэглэл цол хоёроо нэгтгэнэ л гэсэн үг.

Г.Мөнхцэцэг: За байз энэ дээр байна шүү дээ. 2 номерын микрофон дээр яг дэд ажлын хэсгээс хариулаад, одоо яг яамнаас олгодог цол гэж байгаа юм уу. Энэ дээр сайд нэг хариулт өгөөдөх дөө. 2 номерын микрофоныг өгье

Х.Тамир: 2 хууль нийлсэнтэй холбоотой эрдмийн зөвлөл гэсэн зүйл, хэсэг бол энд шинээр оршиж байгаа. Тэр дээр бол энэ цолны асуудал Судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай хууль дээр явж байсан учраас наашаа орж ирсэн гэж ойлгож болно. 2 дахь нь бол Вак гэж буюу хуучин нөгөө эрдмийн дээд зөвлөл байхгүй болоод удаж байгаа. Сургуулийн эрдмийн зөвлөлөөрөө энэ дэд профессор, профессор цол зэрэглэлийнхээ асуудлыг шийдээд явж байгаа. Тэр зарчмаар явж байгаа.

Г.Мөнхцэцэг: Энх-Амгалан сайд хариул даа. Энэ ажлын хэсэг чинь яг яаж ажилласан юм бэ.

Л.Энх-Амгалан: Ингэсэн юм байна. Яах вэ энэ чинь нөгөө судалгааны их сургуулийн хууль, Дээд боловсролынхоо хуультай нийлүүлсэн учраас Судалгааны их сургуулийн хууль дотор нөгөө цолтой холбоотой заалт байсан учраас энийгээ нийлүүлж аль нь зэрэг байх юм, аль нь цол байх юм гэдгийг зохицуулж жаахан ойлгомжтой болгосон заалт л юм байна шүү дээ. Ер нь бол. Тэгэхээр түрүүний тэр цолыг яадаг юу тэр болохгүй юм байна. Тэр болохгүй юм байна. Тэр хуучнаараа л байх ёстой юм байна. Сайд журам гаргаад ямар нэгэн эрдмийн цол, зэргийг албан тушаалтан нь уялдуулж өгдөг тийм юм байхгүй болчихсон юм шүү дээ. Одоо цол зөвхөн их сургуулийн тэр эрдмийн академик эрх чөлөөнийхөө

хүрээнд эрдмийн зөвлөлүүд нь олгож явдаг ийм л тогтолцоотой л байхгүй юу.

Би цол олгохгүй. Би болоод миний дараагийн сайд нар цол олгохгүй. Олгохгүй. Тийм юм байхгүй. Тэр зөвхөн зэрэг, цолууд тэр сургуулийнхаа тэр дотоод дүрмээр, эрдмийнхээ зөвлөлийн дүрмээр зохицуулагдаад явна л гэсэн ийм л зүйл байгаа шүү дээ. Зэрэг байвал юу байх юм, цол байвал юу байх юм гэдгийг л тийм биз дээ.

Г.Мөнхцэцэг: Угаасаа энэ ажлын дэд хэсгийг нь оруулж ирсэн санал ажлын хэсэг цааш нь оруулсан санал чинь бол ойлгомжтой санал байна шүү дээ. Сая бол явж байгаа л хуучин ойлголцлын буруугаас, мөн дээрээс нь бас 2 хууль ингээд нийлсэнтэй холбоотойгоор ингээд энэ олгогдох процесс дээр бас жоохон санал зөрөлдсөн юм уу, аль эсвэл санал нэгтгэгдээгүй юм шиг байна. Тэгэхдээ энэ томъёолж орж ирсэн нь бол зөв байгаад байна шүү дээ. Ундрэм гишүүн ээ. Одоо яг энэ үүгээрээ гэхдээ найруулгын хувьд бол засварууд байгаа. Тэр найруулгын засваруудыг хийгээд редакцын засвар, найруулгын редакцын засваруудыг хийгээд ингээд цаашид анхаараад ажиллаарай. Ажлын хэсгийн санал гаргасан. Санал хураалт явуулъя. Санал хураалт. Энэ санал 77,8 хувиар дэмжигдлээ.

29.Төслийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 27.4 дэх хэсгийн “цагдаа, аюулгүй байдлын” гэснийг “цагдаагийн” гэж, “хууль тогтоомжид” гэснийг “хуульд” гэж өөрчилж, мөн хэсгийн “тус тус” гэснийг хасаж, мөн зүйлийн 27.2, 27.5 дахь хэсгийг төслөөс хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай 27.7, 27.8 дахь хэсэг нэмэх:

“27.1.Дээд боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэх удирдлага нь дээд сургууль, коллежид захирал /цаашид “захирал” гэх/, их сургуульд ректор /цаашид “ректор” гэх/ байна.

27.7.Цэрэг, цагдаагийн дээд боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэх удирдлагад энэ хуулийн 27.6-д зааснаас гадна нэмэлт шаардлага тавьж болно.

27.8.Төрийн болон орон нутгийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэх удирдлагыг сонгон шалгаруулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” Санал гаргасан ажлын хэсэг.

Энэ дээр нэг асуулт байгаад байна. Сая цэрэг, цагдаагийн боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэх удирдлагад энэ хуулийн хэсгээс гадна нэмэлт шаардлага тавьж болно гэдэг нь юу вэ. Нэмэлт шаардлага гэдгийг нь яаж тодорхойлсон бэ. Энэ дээр протоколтой явж байгаа учраас Ганбаяр сайд нэг хариулт өгчих. 1 номерын микрофоныг өгье.

Г.Ганбаяр: Хууль сахиулах дотоод хэргийн их сургууль өөрөө тухайлсан яамнуудаа бас удирдагдаж явдаг. Тэнд нөгөө цэргийн анги нэгтгэлийнх нь зарчмаар захирлууд нь томилогддог учраас тэнд яг тэр мэргэжлийнх нь чиглэлийн цэргийн цол, цагдаагийн цолтой холбоотой шаардлагууд байдаг. Зарим дээр нь генерал цол хүртэл яригддаг учраас тэрийг нь бид нар энэ хуулиараа нээлттэй үлдээх зорилгоор нэмэлт шаардлага байж болно гэдэг заалтыг оруулж ирж байгаа юм.

Г.Мөнхцэцэг: Тавьж болно гэж орж ирэх юм уу. Байж болно гэх юм уу. Нээлттэй үлдээгээд тавьж болно гээд ингээд ийм хатуу хэрэгтэй юм уу, үгүй юм уу. Энэ бас л нэг найруулга юм шиг харагдаад байх юм. Энэ дээр нэг хараарай. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ санал 77,8 хувиар дэмжигдлээ.

30.Төслийн 28.1.9 дэх заалтын “бусад харилцааг” гэсний дараа “сургуулийн” гэж нэмж, 29.1.1 дэх

заалтын “төрөөс болон удирдах зөвлөлөөс” гэснийг “эрх бүхий этгээдийн” гэж өөрчилж, төсөлд доор дурдсан агуулгатай 29.2 дахь хэсэг нэмэх:

“29.2.Дээд боловсролын сургалтын байгууллага доор дурдсан хамтын ажиллагааг хэрэгжүүлэх үүрэгтэй:

29.2.1.олон улсад өрсөлдөх чадвартай багшлах хүний нөөцийг бэлтгэх, дэмжих;

29.2.2.оницгой авьяастай суралцагчийг дэмжих, авьяасыг хөгжүүлэх хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх;

29.2.3.дээд боловсролын сургалтын байгууллага хооронд харилцан тохиролцсон бусад хэлбэр.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ санал 77,8 хувиар дэмжигдлээ.

31.Төслийн 30.1 дэх хэсгийн “байгууллагын санхүүжилт нь” гэсний дараа “Боловсролын ерөнхий хуульд зааснаас гадна” гэж, 30.1.2 дахь заалтын “олон улсын” гэсний дараа “байгууллага” гэж нэмж, “сангуудаас татах” гэснийг “сангаас олгох” гэж өөрчилж, “албан ёсны зээл” гэснийг хасаж, 30.1.4 дэх заалтын “их, дээд сургуулийн” гэснийг “дээд боловсролын сургалтын байгууллагын” гэж, “компаниас орох” гэснийг “компанийн үйл ажиллагаанаас орсон” гэж өөрчилж, 30.1.7 дахь заалтын “олсон орлого” гэсний дараа “гэрээт ажил, үйлчилгээ, түрээс, аж ахуйн үйл ажиллагаанаас орсон орлого” гэж нэмж, 30.1.5, 30.1.6, 30.1.8 дахь заалт, 30.5 дахь хэсгийг төслөөс хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай 30.1.10-30.1.15 дахь заалт, 30.6-30.9 дэх хэсэг нэмж, төслийн 30.2, 30.3 дэх хэсгийг нэгтгэн 30.2 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“30.1.10.хүүгийн орлого;

30.1.11.байгууллагын болон судалгааны грант;

30.1.12.өрсөлдөөнт төсөл;

30.1.13.их сургуулийн эмнэлгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнээс олсон орлого;

30.1.14.хөрөнгө оруулалтын зээл;

30.1.15.орон нутгийн төсвийн дэмжлэг;

30.2.Дээд боловсролын сургалтын байгууллагад улсын төсвөөс дараах дэмжлэг үзүүлнэ:

30.2.1.тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэлээр суралцагчид олгох сургалт, судалгааны тэтгэлэг;

30.2.2.улс орны нийгэм, эдийн засагт үзүүлэх ач холбогдол бүхий Засгийн газрын захиалгат судалгаа шинжилгээ, дэвшилтэт технологи дамжуулалт болон инновацын үйл ажиллагааны зардал;

30.2.3.төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын эзэмшиж, ашиглаж байгаа хөрөнгийн төрийн өмчийн тогтмол зардал;

30.4.Энэ хуулийн 30.1.1-30.1.15-д заасан эх үүсвэрээс бүрдсэн орлогыг захиран зарцуулах журмыг тухайн дээд боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөл батална.”

30.6.Дээд боловсролын сургалтын байгууллагын эндаументын сангийн бүрдүүлэлт болон зарцуулалттай холбогдох нийтлэг журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

30.7.Аймаг, нийслэлийн мэргэжилтэй ажилтны хэрэгцээг хангах зорилгоор нутгийн захиргааны байгууллагаас дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид

зориулсан санхүүгийн дэмжлэг олгож болох бөгөөд уг дэмжлэгийг төрөл, хэмжээ, олгох нөхцөл, журмыг тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал тогтоож, тухайн жилийн төсөвтөө тусган санхүүжүүлнэ.

30.8.Энэ хуулийн 30.2-т заасан зардлыг гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлнэ.

30.9.Энэ хуулийн 30.2-т заасан зардлыг санхүүжүүлэх журмыг Засгийн газар батална.Санал гаргасан ажлын хэсэг. Миний энэ гацаад байгаа нэг л уншигдахгүй байгаа болов уу л гэж бодоод байна. Тэгэхээр бас л найруулгын юмнуудыг нь харахгүй л бол. Аймаг, нийслэлийн мэргэжилтэй ажилтны хэрэгцээг гэж юу вэ. Аймаг, нийслэлийн мэргэжилтэй ажилтан гэж юу юм бэ. Тэгэхээр бас мэргэжилгүй ажилтан гээд гарч ирэх нь байна шүү дээ. Тэгээд Нийслэлийн мэргэжилтэй ажилтан гэдэг энийг яг ямар байдлаар томьёолж оруулж ирж байгаа юм. Тэгэхээр харин энийг заавал нэг үг товчлох гэж байгаад ийм ямар ч агуулгагүй ийм болгож байсан дор бол тэгээд аймаг, нийслэлийн юу гэдэг юм захиалгаар бэлтгэсэн мэргэжилтэн мөн үү. Тэгж уншигдах ёстой тийм үү. Тэгэхээр энийг найруулгын, редакцын засварыг анхаараарай. 30.7 дээр байгаа шүү. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ санал хураалт 77,8 хувиар дэмжигдлээ.

32.Төслийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалт, 31.2, 31.3 дахь хэсгийг төслөөс хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай 31.1.5 дахь заалт нэмэх:

“31.1.5.дээд боловсролын сургалтын байгууллагын үндсэн үйл ажиллагааг дэмжих зорилгоор мөнгөн хөрөнгийн удирдлагыг оновчтой зохион байгуулах.”

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ санал хураалт 77,8 хувиар дэмжигдлээ.

Энх-Амгалан сайдын микрофоныг өгье.

Л.Энх-Амгалан: Энэ түрүүчийн 29 дүгээр санал хураалт дээр 27.7 дээр цэрэг, цагдаагийн дээд боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэх удирдлагад энэ хуулийн 27.6-д зааснаас гадна нэмэлт шаардлага тавьж болно гэдэгтэй бид нар ярилаа шүү дээ. Энэ ер нь хасчихъя. Энэ угаасаа журмаараа зохицуулж болох юм байна. Журмаар зохицуулж, тэгэхгүй ингээд нэг сайд нь нөгөө сайдынхаа томилгоо дээр нэмэлт шаардлага тавиад байгаа юм шиг тийм юм үүсгэчихнэ. Энийг хасчихъя. Энэ заалтыг нь тэгээд хасах санал гаргаж байна. Ажлын хэсэг энэ саналаа татчихъя. Ажлын хэсэг татъя гэсэн санал гаргаж байна.

Г.Мөнхцэцэг: Төслийн 33 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ санал 77,8 хувиар дэмжигдлээ.

34.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн дугаарлалт бүлэг энэний өмнө талд энэ юуг хийх ёстой юм байна. Тэгэхгүй бол түрүүчийн 29 дүгээр дугаар буюу 27 дугаар зүйлийн 27.7 дээр нэлээн маргаантай нэмэлт шаардлага гээд энэ дээр найруулгын засвар хийх гээд ингээд чиглэл өгсөн, үүнийг ажлын хэсэг саналаа өөрчилье, татъя гэсэн санал гаргасан учраас микрофондоо хэлээд протокол дээр хэлээд санал хураалт явуулчихъя. Яг 27.7.

Ундрам гишүүн, ажлын хэсгийн ахлагчийн микрофоныг өгье.

Ч.Ундрам: Байнгын хорооны дарга аа, энэ 29 дүгээр саналд байгаа хуулийн төслийн 27.7 цэрэг, цагдаагийн дээд

боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэх удирдлагад энэ хуулийн 27.6-д зааснаас гадна нэмэлт шаардлага тавьж болно гэсэн энэ заалтыг хасуулах санал байна. Ажлын хэсгээс энэ заалтыг татаж авъя гэсэн ийм саналаар санал хураалгаж өгнө үү. Татах хүсэлтээ албан ёсоор өгч байна ажлын хэсгээс.

Г.Мөнхцэцэг: Ажлын хэсгийн ахлагчийн гаргасан саналаар энэ 27.7 дахь хэсгийг санал татсан учраас энэ саналыг татсанд тооцлоо. Хурал тарах болоогүй байна. Энэ 5.9 дээр бас түрүүн санал хураагдчихсан. Санал хураагдсан тэгээд энийг бас тодруулж микрофонд хэлж бас хураагдсан санал дээр микрофонд хэлэх ёстой байгаа. Протоколд тэмдэглүүлэх ёстой байгаа. Энэ хуулийн 5.8-д заасан шаталсан тогтолоо бүхий хөгжмийн урлагийн байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэл үр дүнг харгалзан шаардах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх бөгөөд уг харилцааг зохицуулсан журмыг Засгийн газар баталж мөрдүүлнэ гэж ийм санал тодруулж протокол тэмдэглүүлж байгаа. Түрүүн бол зүйл дээрээ бол санал хураагдчихсан байж байгаа. Энийг эхэллээ.

34.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн дугаарлалт, бүлэг, зүйл, хэсэг, заалтын дугаарыг агуулгын хувьд эрэмбэлэн, үг найруулгыг жигдлэн, хууль зүйн техникийн болон бусад засварыг хийх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ санал 77,8 хувиар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд санал, дүгнэлт унших гишүүнээр ажлын хэсгийн ахлагч Ундрам танилцуулна.

Өнөөдрийн хуралдаанд идэвхтэй, тэсвэртэй оролцсон бүх гишүүдэд болоод ажлын дэд хэсэгт баярлалаа. Боловсрол, соёл, шинжлэх ухаан,

*спортын байнгын хорооны өнөөдрийн
хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.*

***Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ***

Э.СУВД-ЭРДЭНЭ